

ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

БАТЛАВ,
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА


Т.ЖАМБАЛЦЭРЭН

УСЛАЛТЫН СИСТЕМИЙГ ШИНЭЧЛЭН САЙЖРУУЛАХ БАРИЛГЫН АЖИЛ ЭРДЭНЭБҮРЭН ДЭД ТӨСӨЛ (ЭРДЭНЭБҮРЭН, ХОВД)-ИЙН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ТЕНДЕР

Захиалагч: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

Улсын нэр: Монгол улс

Төслийн дугаар ба нэр: L3895/L3896/G9205-MON, Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй төсөл

Тендер шалгаруулалтын нэр: Услалтын системийг шинэчлэн сайжруулах барилгын ажил Эрдэнэбүрэн дэд төсөл (Эрдэнэбүрэн, Ховд)

Тендер шалгаруулалтын дугаар: CW-3-1

Олгосон огноо: 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр

Агуулга

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: Тендер шалгаруулалтын горим

Нэгдүгээр бүлэг: Тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа (ТОӨЗ)

Хоёрдугаар бүлэг: Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт (ТШӨХ)

Гуравдугаар бүлэг: Үнэлгээний ба чадварын шалгуур үзүүлэлт

Дөрөвдүгээр бүлэг: Тендер шалгаруулалтын маягт

Тавдугаар бүлэг: Эрх бүхий орнууд

ХОЁРДУГААР ХЭСЭГ: Ажил гүйцэтгэхэд тавих шаардлага

Зургаадугаар бүлэг: Тодорхойлолт ба бусад шаардлага

ГУРАВДУГААР ХЭСЭГ: Гэрээний нөхцөл ба маягт

Долоодугаар бүлэг: Гэрээний срөнхий нөхцөл (ГЕН)

Наймдугаар бүлэг: Гэрээний тусгай нөхцөл (ГТН)

Есдүгээр бүлэг: Гэрээний маягт

1 дүгээр бүлэг - Тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа

Тендерт оролцогчдод өгөх зааварчилгааг хэрэглэх заавар

Энэ бүлэгт Захиалагчийн шаардлагад нийцсэн тендерийг тендерт оролцогч бэлтгэхэд шаардлагатай мэдээллийг тусгана. Түүнчлэн, тендер илгээх, нээх, үнэлэх, гэрээ байгуулах эрх олгох зэрэг үйл ажиллагаатай холбогдсон мэдээллийг агуулна.

Гүйцэтгэгчийн гэрээний үүрэг, гэрээний төлбөр, талуудын эрх, үүрэг, хүлээх эрсдэлтэй холбогдсон нөхцөлийг энэ бүлэгт бус, харин 7 дугаар бүлэг (Гэрээний ерөнхий нөхцөл) болон 8 дугаар бүлэг (Гэрээний тусгай нөхцөл)-т тус тус заана.

Тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа нь тендерийн баримт бичгийн салшгүй хэсэг мөн боловч гэрээний хэсэг болохгүй.



Гарчиг

- А. Ерөнхий зүйл**.....
1. Тендерийн цар хүрээ.....
 2. Санхүүжилтийн эх үүсвэр.....
 3. Залилган ба авлига.....
 4. Эрх бүхий тендерт оролцогч.....
 5. Эрх бүхий материал, тоног төхөөрөмж ба үйлчилгээ.....
 6. Түншлэл.....
- Б. Тендерийн баримт бичиг**.....
7. Тендерийн баримт бичгийн агуулга.....
 8. Тендерийн баримт бичгийг тодруулах, ажлын талбайтай танилцах ба тендерийн өмнөх уулзалт
 9. Тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулах.....
- В. Тендер бэлтгэх**.....
10. Тендер шалгаруулалтад оролцох зардал.....
 11. Тендерийн хэл.....
 12. Тендерийн иж бүрдэл.....
 13. Тендер ирүүлэх маягт ба үнийн хуваарь.....
 14. Хувилбарт тендер.....
 15. Тендерийн үнэ ба хөнгөлөлт.....
 16. Тендерийн ба төлбөрийн валют.....
 17. Тендерийн саналын бүрдэл баримт бичиг.....
 18. Тендерт оролцогчийн чадварыг нотлох баримт.....
 19. Тендерийн хүчинтэй хугацаа.....
 20. Тендерийн баталгаа.....
 21. Тендер ирүүлэх хувь, түүнд гарын үсэг зурах.....
- Г. Тендер ирүүлэх**.....
22. Тендерийг битүүмжлэх ба бичиглэл үйлдэх.....
 23. Тендер хүлээн авах эцсийн хугацаа.....
 24. Хугацаа хоцорсон тендер.....
 25. Тендерийг буцааж авах, солих ба өөрчлөх.....
- Д. Тендерийг нээх, үнэлэх**.....
26. Тендерийг нээх.....
 27. Нууцлал.....
 28. Тендерийг тодруулах.....
 29. Зөрүү, болзолт нөхцөл ба орхигдуулсан зүйл.....
 30. Тендерийг хянан үзэх, шаардлагад нийцсэн эсэхийг тогтоох
 31. Жигжиг зөрүү.....
 32. Арифметик алдааг залруулах.....
 33. Давуу эрхийн зөрүү.....
 34. Тендерийг үнэлэх, харьцуулах.....
 35. Тендерт оролцогчийн чадвар.....
 36. Аливаа тендерийг хүлээн зөвшөөрөх, болон аливаа эсхүл бүх тендерээс татгалзах захиалагчийн эрх
 37. Хэт бага үнэтэй тендер
 38. Тэнцвэргүй эсхүл зардлыг урьдчилж нэмсэн тендер
 39. Гэрээ байгуулах эрх олгох тухай илэрхийлэл бүхий мэдэгдэл
- Е. Гэрээ байгуулах эрх олгох**.....
40. Гэрээ байгуулах эрх олгох шалгуур.....
 41. Гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл.....
 42. Гэрээнд гарын үсэг зурах.....
 43. Гүйцэтгэлийн баталгаа.....
 44. Тендер шалгаруулалттай холбоотой гомдол.....



А. Ерөнхий зүйл

1. Тендерийн цар хүрээ

- 1.1 Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт (ТШӨХ)-д заасан тендерийн урилга (ТУ)-тай холбогдуулан Захиалагч нь энэхүү тендерийн баримт бичгийг 6 дугаар бүлэг (Тодорхойлолт ба бусад шаардлага)-т заасан ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар гаргав. Нээлттэй өрсөлдөөнт тендер шалгаруулалт (НӨТШ)-ын гэрээний нэр, тодорхойлолт, дугаарыг ТШӨХ-д заав.
- 1.2 Шалгарсан тендерт оролцогч нь гэрээгээр гүйцэтгэх ажлыг ТШӨХ-д заасан хугацаанд багтаан дуусгана.
- 1.3 ТШӨХ-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд тендер шалгаруулалтын дүнд нэг гэрээ байгуулахаар зарлаж болно. Хэрэв тендер шалгаруулалт нь хэд хэдэн гэрээ буюу багцаас бүрдсэн бол тендерт оролцогч нь нэг эсхүл түүнээс олон багцад тендер ирүүлж болно.
- 1.4 Энэхүү тендерийн баримт бичигт:
 - (а) “бичгээр” гэдэг нь хүлээн авсан гэдгээ нотолж бичгээр харилцахыг хэлнэ;
 - (б) тухайн утга агуулгаас нь хамааран ганц тоон дээр илэрхийлсэн үгийг олон тоон дээр, мөн эсрэгээр олон тоон дээр илэрхийлсэн үгийг ганц тоон дээр тус тус ойлгоно;
 - (в) “өдөр” гэж хуанлийн өдрийг хэлнэ.

2. Санхүүжилтийн эх үүсвэр

- 2.1 ТШӨХ-д заасан зээлдэгч буюу хүлээн авагч (цаашид “зээлдэгч” гэх) нь ТШӨХ-д заасан төслийн зардлыг санхүүжүүлэхээр Азийн хөгжлийн банк (цаашид “АХБ” гэх)-наас санхүүжилт (цаашид “санхүүжилт” гэх)-ийг авахаар хүсэлт гаргасан эсхүл хүлээн авсан болно. Зээлдэгч нь энэхүү тендерийн баримт бичигт заасан гэрээний дагуу эрх бүхий төлбөрт санхүүжилтийн хүсэлт гаргах болно.
- 2.2 АХБ-наас төлөх төлбөр нь Зээлдэгч болон АХБ-ны хооронд байгуулсан санхүүжилтийн гэрээ (цаашид “санхүүжилтийн гэрээ” гэх)-ний нөхцөлд заасны дагуу зөвхөн зээлдэгчийн хүсэлт болон АХБ-ны зөвшөөрөл авсан тохиолдолд хийгдэх ба бүхий л тохиолдолд тухайн санхүүжилтийн гэрээний нөхцөлд бүрэн нийцсэн байна. Зээлдэгчээс бусад аль ч тал санхүүжилтийн гэрээнээс аливаа эрх эдлэх эсхүл санхүүжилт нэхэмжлэх ёсгүй.

3. Залилан ба авилга

- 3.1 Төрийн албан хаагч, тендерт оролцогч ба гүйцэтгэгч нь худалдан авах ажиллагаанд оролцох, гэрээг хэрэгжүүлэхдээ ёс зүйн өндөр хэм хэмжээг сахин мөрдөнө.
- 3.2 Гэрээнд өрсөлдөх явцад Авлигын эсрэг хууль, Эрүүгийн хууль, Өрсөлдөөний тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан авлига, залилан мэхлэх, үгсэн хуйвалдах, айлган сүрдүүлэх үйлдэлд аль нэг оролцогч шууд өөрөө эсвэл төлөөлөгчөөрөө дамжуулан холбогдсон тухай нотолгоо баримт байгаа бол төрийн албан хаагч, тендерт оролцогч болон гүйцэтгэгч нь холбогдох албан тушаалтан, хууль, хяналтын байгууллагад зохих ёсоор мэдэгдэх үүрэгтэй.



3.3 АХБ-ны авлигын эсрэг бодлого нь зээлдэгч (түүний дотор АХБ-ны санхүүжилттэй үйл ажиллагааны үр шим хүргэгч) төдийгүй АХБ-ны санхүүжилттэй гэрээний тендерт оролцогч, нийлүүлэгч, гүйцэтгэгчээс худалдан авах ажиллагаа болон гэрээний хэрэгжилтийн явцад ёс зүйн өндөр хэм хэмжээг баримтлахыг шаарддаг. Энэ бодлогыг мөрдлөг болгох үүднээс АХБ нь:

(а) энэхүү заалтын хүрээнд доор дурьдсан нэр томьёог дараах байдлаар тодорхойлно:

- (i) “авлигын үйлдэл” гэдэг нь бусдын үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөхийн тулд аливаа үнэ бүхий зүйлийг шууд буюу шууд бусаар санал болгох, өгөх, авах, эсхүл хүсэхийг хэлнэ;
- (ii) “залилан мэхлэх үйлдэл” гэдэг нь санхүүгийн болон бусад үр шим хүртэх эсхүл үүрэг хариуцлагаас мултрах зорилгоор бусдыг санаатайгаар буюу санамсаргүйгээр төөрөгдүүлэх, эсхүл төөрөгдүүлэхийг оролдсон аливаа үйлдэл хийх, баримтыг орхигдуулах, худал мэдүүлэхийг хэлнэ;
- (iii) “дарамт шахалт үзүүлэх үйлдэл” гэдэг нь аливаа талын үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөхийн тулд аливаа талд буюу түүний өмч хөрөнгөнд шууд эсхүл шууд бусаар хохирол учруулах, эсхүл хохирол учруулахаар заналхийлэхийг хэлнэ;
- (iv) “үгсэн хуйвалдах үйлдэл” гэдэг нь хоёр буюу түүнээс дээш этгээд зүй бус зорилгод хүрэх, түүний дотор бусдын үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөх зорилгоор хоорондоо тохиролцоо хийхийг хэлнэ;
- (v) “шамшигдуулах” гэж АХБ-ны холбогдох үйл ажиллагаанд зориулсан хөрөнгийг санаатайгаар эсэл болгоомжгүй байдлын улмаас хулгайлах, үрэгдүүлэх болон зүй бусаар ашиглахыг хэлнэ;
- (vi) “сонирхлын зөрчил” гэж нэг тал нь нөгөө талын албан үүргээ гүйцэтгэх, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь эсхүл холбогдох хууль тогтоомжийг мөрдөх явцад нь зүй бусаар нөлөөлж болзошгүй сонирхол агуулагдсан аливаа нөхцөл байдлыг хэлнэ;
- (vii) “саад учруулах” гэж (а) АХБ-ны хяналт шалгалтын нотлох баримтыг санаатайгаар устгах, хуурамчаар үйлдэх, өөрчлөх болон нуун дарагдуулах, эсхүл АХБ-ны хяналт шалгалтад саад учруулахын тулд шалгагчдад санаатайгаар худал мэдүүлэг өгөх; (б) банкны хяналт шалгалттай холбогдсон мэдээллийг ил болгох эсхүл хяналт шалгалтыг явуулахаас урьдчилан сэргийлэх зорилгоор аль нэг талыг айлган сүрдүүлэх, дарамтлах, заналхийлэхийг; эсхүл (в) АХБ-ны хувьд аудит, хяналт шалгалт хийх болон мэдээлэл авах зэрэг гэрээний дагуу олгогдсон



эрхээ хэрэгжүүлэхэд нь саад учруулах зорилго бүхий санаатай үйлдлийг хэлнэ;

- (viii) “шударга байдлыг зөрчих” гэж АХБ-ны шударга байдлын зарчим ба журам (2015, цаашид нэмж өөрчлөх)-д заасан, АХБ-ны Авлигатай тэмцэх бодлого, мөн өмнөх (i)-(vii)-д болон дор дурдсан нөхцөлийг зөрчсөн аливаа үйлдэл; АХБ-ны авч хэрэгжүүлэх хориг арга хэмжээ, мэдээлэгч эсхүл гэрчийн эсрэг өшөө авах ажиллагаа болон АХБ-ны Авлигатай тэмцэх бодлого, ёс зүйн өндөр хэм хэмжээг баримтлаагүй зэрэг зөрчлүүдийг хэлнэ.
- (б) Гэрээний эрх олгохоор санал болгосон тендерт оролцогч нь гэрээний эрхийн төлөө өрсөлдөх явцдаа шууд өөрөө эсвэл төлөөлөгчөөр дамжуулан авлига авах, залилан мэхлэх, дарамт шахалт үзүүлэх, эсвэл үгсэн хуйвалдах, саад учруулах болон шударга байдлыг зөрчих зэрэг үйлдэлд оролцсон болох нь тогтоогдвол гэрээний эрх олгох саналаас татгалзана;
- (в) АХБ-наас санхүүжилт авсан зээлдэгчийн эсвэл АХБ-ны санхүүжилтээс үр шим хүртэгчийн төлөөлөгч нь худалдан авах ажиллагаа, эсвэл гэрээг хэрэгжүүлэх явцал авлига авах, залилан мэхлэх, дарамт шахалт үзүүлэх, үгсэн хуйвалдах, саад учруулах эсвэл шударга байдлыг зөрчих зэрэг үйлдэлд оролцсон, мөн зээлдэгч энэ байдлыг засаж залруулах талаар АХБ-ны шаардлагад нийцэхүйц зохистой арга хэмжээг цаг тухайд нь аваагүй болох нь хэзээ нэгэн цагт тогтоогдвол тухайн гэрээнд хуваарилсан санхүүжилтийн хэсгийг цуцална;
- (г) Хэрэв компани ба хувь хүн шууд өөрөө эсвэл төлөөлөгчөөр дамжуулан авлига авах, залилан мэхлэх, дарамт шахалт үзүүлэх, эсвэл үгсэн хуйвалдах, саад учруулах эсвэл шударга байдлыг зөрчих зэрэг үйлдэлд оролцсон болох нь тогтоогдвол, тодорхой эсхүл тодорхойгүй хугацаагаар АХБ-наас санхүүждэг, эсхүл АХБ-ны захиран зарцуулдаг арга хэмжээнд оролцох¹, эсвэл АХБ-наас санхүүждэг, эсхүл АХБ-ны захиран зарцуулдаг гэрээнээс санхүүгийн болон бусад хэлбэрээр үр шим хүртэх эрхгүй болохыг зарлах гэх мэтээр АХБ-ны Авлигын эсрэг бодлого, Шударга байдлын зарчим ба журмын дагуу компани, хувь хүнд зөрчлийг арилгах арга хэмжээг хэдийд ч авч хэрэгжүүлнэ;
- (д) Тендерт оролцогч, нийлүүлэгч, гүйцэтгэгчийн данс бүртгэл болон тендерийн санал ирүүлэх, гэрээний гүйцэтгэлтэй холбоотой баримт бичгийг хянан шалгах, АХБ-наас томилсон аудитын байгууллагаар тэдгээрийг хянуулахыг АХБ, түүний төлөөлөгчид зөвшөөрөхийг тендерт оролцогч, нийлүүлэгч, гүйцэтгэгчээс хүссэн заалтыг АХБ-ны санхүүжилттэй тендерийн баримт бичиг болон гэрээнд тусгасан байхыг шаардах эрхтэй.

¹ Гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч, зөвлөх, үйлдвэрлэгч, нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгч; эсвэл аливаа бусад хэлбэр (тухайн тендерийн баримт бичгээс хамаарч, өөр нэршилнийг хэрэглэдэг).



4. Эрх бүхий тендерт оролцогч

4.1 Тендерт оролцогч нь хувь хүн, хувийн хэвшлийн байгууллага, ТООЗ-ны 4.5-д заасны дагуу төрийн өмчит үйлдвэрийн газар, мөн түншлэлийн хэлбэрээр гэрээ байгуулах тухай албан захидал эсхүл байгуулсан гэрээтэй эдгээр этгээдийн аливаа нэгдлийг хэлнэ. Түншлэл байгуулсан тохиолдолд:

- (а) түншлэлийн бүх гишүүд хамтдаа болон дангаараа хариуцлага хүлээнэ;
- (б) түншлэл нь тендер шалгаруулалтын үед, түншлэлд гэрээ байгуулах эрх олгох, мөн гэрээг хэрэгжүүлэх явцад түншлэлийн аль нэг болон бүх гишүүдийн нэрийн өмнөөс бүхий л үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх үүрэг бүхий төлөөллийг томилно.

4.2 Тендер оролцогч, тендерт оролцогчийг бүрдүүлж буй бүх талууд нь 5 дугаар бүлэг (Эрх бүхий орнууд)-г заасны дагуу эрх бүхий орноос гарал үүсэлтэй байна. Хэрэв тендерт оролцогч нь тухайн улсын хуулийн дагуу иргэний харьяалалтай, эсхүл үүсгэн байгуулагдсан, нэгдэн нийлсэн, бүртгүүлсэн болон үйл ажиллагаагаа явуулдаг бол тендерт оролцогчийг уг улсын гарал үүсэлтэй гэж үзнэ. Энэ шалгуурыг түүнчлэн холбогдох үйлчилгээг оруулан гэрээний аливаа хэсэгт туслан гүйцэтгэгч эсхүл нийлүүлэгчийн гарал угсааг тодорхойлоход хэрэглэнэ.

4.3 Тендерт оролцогч нь сонирхлын зөрчилгүй байна. Сонирхлын зөрчилтэй гэж тогтоогдсон бүх тендерт оролцогчийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд, мөн үүгээр хязгаарлагдахгүйгээр, тендерт оролцогчийг энэхүү тендер шалгаруулалтын нэг эсхүл түүнээс олон талуудтай сонирхлын зөрчилтэй гэж үзэж болно. Үүнд:

- (а) тэдгээр этгээдийн нэг хяналтанд үйл ажиллагаа явуулдаг; эсхүл
- (б) тэдгээрийн аль нэгээс шууд болон шууд бус хэлбэрээр татаас авдаг эсхүл авсан бол; эсвэл
- (в) тендер ирүүлэхтэй холбогдуулан тэдний хуулийн төлөөлөгч нь нэг этгээд байх бол; эсхүл
- (г) тэд өөр хоорондоо шууд болон гуравдагч этгээдээр дамжуулан бусад тендерт оролцогчийн тендерийн талаар их хэмжээний мэдээлэл авах, эсвэл түүнд зүй бусаар нөлөөлөх, эсхүл энэхүү тендер шалгаруулалтын талаар захиалагчийн гаргах шийдвэрт нөлөө үзүүлэхүйц харилцаатай байх; эсвэл
- (д) тендерт оролцогч нь энэхүү тендерийн баримт бичгийн ТООЗ-ны 14-д зөвшөөрсөний дагуу хувилбарт тендер ирүүлэхээс бусад тохиолдолд энэхүү тендер шалгаруулалтанд дангаараа эсхүл түншлэлийн гишүүний хувьд нэгээс дээш тендерт оролцох бол. Энэ нь түүний оролцсон бүх тендерийг шаардлага хангаагүй гэж үзэх үндэслэл болно. ТООЗ-ны 4.3 (а)-(г)-д зааснаар сонирхлын зөрчилтэйг илрүүлсэн хэдий ч, энэ нь тендерт оролцогчийг



өөр тендерт эсхүл нэгээс дээш тендерт туслан гүйцэтгэгчээр оролцоход хязгаарлалт болохгүй; эсвэл

- (е) тендерт оролцогч, түншлэлийн гишүүн, нэгдэн хамтрагч, толгой компани, эсхүл аливаа салбар нэгж нь гүйцэтгэхээр санал болгож буй ажлын зураг төсөл, техникийн тодорхойлолтыг бэлтгэхэд зөвлөхөөр ажилласан бол; эсхүл
- (ё) тендерт оролцогч нь захиалагч эсхүл зээлдэгчийн гэрээнд инженерээр ажиллаж байсан (эсхүл ажиллуулахаар санал болгосон) компани эсхүл этгээдтэй хамтарсан бол; эсвэл
- (ж) Тендерт оролцогч нь шууд ба шууд бус хяналтанд байдаг аливаа салбар нэгжийн оролцоотойгоор, ТШӨХ-ийн 2.1-д дурдсан төслийг бэлтгэх, хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээнээс үүдэлтэй эсвэл шууд холбоотой бараа, ажил, эсвэл зөвлөх бус үйлчилгээг үзүүлэх бол.

4.4 АХБ-ны Авилгаатай тэмцэх бодлого (ТӨӨЗ-ны 3 дугаар заалтыг үзнэ үү)-ын хүрээнд түр түтгэлзүүлэх эсхүл хориглох тухай шийдвэрийг АХБ-аас гаргасан эсхүл Хориглох шийдвэрийг хамтран хэрэгжүүлэх хэлэлцээрийн дагуу АХБ-наас албадан хэрэгжүүлсэн бол компани нь АХБ-ны санхүүжилттэй, захиран зарцуулдаг болон дэмжлэгтэй аливаа төслийн худалдан авах ажиллагаанд оролцох эрхгүй байна. Түр түтгэлзүүлсэн эсхүл хориглосон компанийн тендерээс татгалзана.

4.5 Захиалагч орны төрийн өмчит хуулийн этгээд нь зөвхөн (i) эрх зүйн болон санхүүгийн хувьд бие даасан, (ii) арилжааны хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг, (iii) захиалагчаас хараат бус байгууллага гэдгийг нотолж чадсан тохиолдолд эрх бүхий оролцогч болно.

4.6 Захиалагчаас шалтгаантайгаар шаардсан бол тендерт оролцогч нь эрх бүхий эсэхийг нотлох баримтыг захиалагчийн шаардлагыг хангахуйцаар ирүүлнэ.

4.7 Зээлдэгч орон Нэгдсэн Үндэсний Байгууллагын Дүрмийн 7 дугаар бүлгийн хүрээнд Нэгдсэн Үндэсний Байгууллагын Аюулгүйн зөвлөлөөс гаргасан шийдвэрийн дагуу тухайн улсаас бараа импортлох, ажлын эсвэл үйлчилгээний гэрээ байгуулах, тухайн улсын иргэн, хуулийн этгээдэд төлбөр төлөхийг хориглодог бол уг компанийг хасч болно.

4.8 Тендерт оролцогч ТШӨХ-д заасны дагуу ажил гүйцэтгэхэд шаардагдах тусгай зөвшөөрлийг эзэмшдэг тухай нотолгоог гаргаж өгөх үүрэгтэй.

5. Эрх бүхий материал, тоног төхөөрөмж ба үйлчилгээ

5.1 Гэрээний дагуу нийлүүлэх материал, тоног төхөөрөмж болон үйлчилгээ нь ТӨӨЗ-ны 4.1-д тодорхойлсноор АХБ-ны эрх бүхий орны гарал үүсэлтэй байх ба гэрээний дагуу гарах бүх зардал нь эдгээр материал, тоног төхөөрөмж болон үйлчилгээгээр хязгаарлагдана. Захиалагч нь тендерт оролцогчоос материал, тоног төхөөрөмж болон үйлчилгээний гарал үүслийн нотолгоог гаргаж өгөхийг шаардаж болно.



5.2 ТООЗ-ны 5.1-д дурдсан “гарал үүсэл” гэдэгт тухайн материал ба тоног төхөөрөмжийг олборлосон, ургуулсан, хийж бүтээсэн эсхүл үйлдвэрлэсэн, түүнчлэн үйлчилгээ үзүүлсэн орон буюу газар нутгийг хэлнэ. Материал ба тоног төхөөрөмжийг хийж бүтээх гэдэг нь үйлдвэрлэх, боловсруулах эсхүл эд ангиудын дийлэнх эсхүл гол хэсгийг нь угсрах замаар эд ангиудын үндсэн шинж, зориулалт эсхүл ашиглалтын хэлбэрээс илт өөр шинжийг агуулсан арилжааны шинэ бүтээгдэхүүн хийж гаргахыг хэлнэ.

6. Түншлэл

6.1 Хоёр ба түүнээс дээш хуулийн этгээд түншлэлийн үндсэн дээр тендерг хамтран оролцогч /цаашид талуудыг хамтад нь “түншлэл”, тус бүрийг нь “түншлэлийн гишүүн” гэх/ болж тендер шалгаруулалтад оролцох тохиолдолд ТШӨХ-д өөрөөр заагаагүй бол дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- (а) түншлэлийн бүх гишүүд хамтаар ба дангаар хариуцлага хүлээнэ;
- (б) түншлэлийн хэлбэрээр гэрээ байгуулах хүслийг илэрхийлсэн албан захидал эсхүл хүчин төгөлдөр түншлэлийн гэрээг тендерг хавсаргана;
- (в) түншлэл нь тендер шалгаруулалтын үед, түншлэлд гэрээ байгуулах эрх олгох, мөн гэрээг хэрэгжүүлэх явцад түншлэлийн аль нэг болон бүх гишүүдийн нэрийн өмнөөс бүхий л үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх үүрэг бүхий төлөөллийг томилно.

6.2 Дээрх шаардлагыг түншлэлийн гэрээнд тусгаагүй тохиолдолд түншлэлийг шаардлага хангаагүй гэж үзэж татгалзана.

Б. Тендерийн баримт бичиг

7. Тендерийн баримт бичгийн агуулга

7.1 Тендерийн баримт бичиг нь доор дурдсан бүлэгтэй 3 хэсгээс болон ТООЗ-ны 9 дүгээр заалтын дагуу оруулсан нэмэлт өөрчлөлтөөс бүрдэнэ:

Нэгдүгээр хэсэг. Тендер шалгаруулалтын горим

- 1 дүгээр бүлэг. Тендерг оролцогчлод өгөх зааварчилгаа (ТООЗ)
- 2 дугаар бүлэг. Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт (ТШӨХ)
- 3 дугаар бүлэг. Үнэлгээний ба чадварын шалгуур үзүүлэлт
- 4 дүгээр бүлэг. Тендер шалгаруулалтын маягт
- 5 дугаар бүлэг. Эрх бүхий орнууд

Хоёрдугаар хэсэг. Ажил гүйцэтгэхэд тавигдах шаардлага

- 6 дугаар бүлэг. Годорхойлолт ба бусад шаардлага

Гуравдугаар хэсэг. Гэрээний нөхцөл ба маягт

- 7 дугаар бүлэг. Гэрээний ерөнхий нөхцөл
- 8 дугаар бүлэг. Гэрээний тусгай нөхцөл
- 9 дүгээр бүлэг. Гэрээний маягт

7.2. Захиалагчийн нийтэлсэн тендерийн урилга нь тендерийн баримт бичгийн хэсэг болохгүй.

7.3 Хэрэв тендерг оролцогч тендерийн баримт бичиг, түүний нэмэлт өөрчлөлтийг тендерийн урилгад захиалагчаас зааж өгсөн газраас шууд аваагүй бол тэдгээр баримт бичгийн бүрэн бүтэн байдалтай холбоотой асуудлыг захиалагч хариуцахгүй.

8. Тендерийн баримт бичгийг тодруулах, ажлын талбайтай танилцах ба тендерийн өмнөх уулзалт

7.4 Тендерт оролцогч тендерийн баримт бичгийн бүх зааварчилгаа, маягт, нөхцөл ба тодорхойлолтыг нягталж үзэх нь зүйтэй. Тендерийн баримт бичигт шаардсан мэдээлэл, баримт материалыг ирүүлээгүй нь тендерээс татгалзах үндэслэл болж болно.

8.1 Боломжит тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах шаардлагатай бол ТШӨХ-д заасан захиалагчийн хаягт хандаж хүсэлтээ бичгээр ирүүлнэ. Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ТШӨХ-д заасан өдрийн өмнө хүлээн авсан аливаа хүсэлтэд хариу өгнө. Захиалагч хүсэлтийн агуулга, түүнд өгөх хариуг тендерийн баримт бичиг худалдан авсан бүх тендерт оролцогчдод хүсэлтийн эх сурвалжийг дурдалгүйгээр нэгэн зэрэг бичгээр мэдэгдэнэ.

8.2 Тухайн тодруулгын хүсэлтийн үр дүнд захиалагч тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл энэхүү ТӨӨЗ-ны 9 ба 23.2-г заасан горимыг баримтална.

8.3 Тендерт оролцогч ажлын талбай, түүний орчны нөхцөл байдалтай газар дээр нь танилцан судалж, тендер бэлтгэх ба ажил гүйцэтгэх гэрээ байгуулахад шаардагдах бүх мэдээллийг өөртөө зориулж авч болно. Тендерт оролцогч ажлын талбайтай газар дээр нь очиж танилцах зардлыг өөрөө хариуцна.

8.4 Тендерийн өмнөх уулзалтыг зохион байгуулах талаар ТШӨХ-д заасан бол тендерт оролцогчоос томилсон төлөөлөгчийг түүнд урьж оролцуулна. Уг уулзалт нь тендер бэлтгэх явцад үүсч болох аливаа асуудлыг тодруулах, энэ талаар тендерт оролцогчоос тавьсан асуултанд хариулт өгөх зорилготой.

8.5 Тендерт оролцогч аливаа асуудлыг уулзалтаас нэг долоо хоногийн өмнө захиалагчид бичгээр ирүүлж болно.

8.6 Эдгээр асуудлын агуулга, түүний хариулт бүхий уулзалтын тэмдэглэлийг уулзалтаас хойш бэлтгэгдсэн хариултын хамт асуудлын эх сурвалжийг дурдалгүйгээр бүх тендерт оролцогчдод даруйхан явуулна.

8.7 Тендерийн өмнөх уулзалтын үр дүнд захиалагч тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТӨӨЗ-ны 9-д заасан горимыг баримтална.

8.8 Тендерийн өмнөх уулзалтад оролцоогүй гэсэн шалтгаанаар тендерт оролцогчийн тендерт оролцох эрхийг хязгаарлаж болохгүй.

9. Тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулах

9.1 Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулж болно.

9.2 Ийнхүү оруулсан аливаа нэмэлт өөрчлөлт нь тендерийн баримт бичгийн салшгүй хэсэг болох бөгөөд захиалагч тендерийн баримт бичиг худалдан авсан бүх тендерт оролцогчдод нэмэлт өөрчлөлтийн талаар бичгээр нэгэн зэрэг мэдэгдэнэ. Тендерт оролцогч захиалагчид нэмэлт өөрчлөлт тус бүрийг хүлээн авсан тухайгаа бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

9.3 Тендерийн баримт бичигт орсон нэмэлт өөрчлөлтийн улмаас тендер зайлшгүй өөрчлөгдөх ба уг өөрчлөлтийг бэлтгэхэд шаардагдах



хангалттай хугацаа тендерг оролцогчид олгох шаардлагатай гэж үзвэл захиалагч ТӨӨЗ-ны 23.2-г заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгаж болно.

В. Тендер бэлтгэх

- | | |
|--|---|
| 10. Тендер шалгаруулалтад оролцох зардал | 10.1 Тендерг оролцогч тендерийг бэлтгэх, хүргүүлэхтэй холбогдон гарах бүх зардлыг өөрөө бүрэн хариуцах бөгөөд захиалагч ямар ч нөхцөлд тендер шалгаруулалтын явц, дүнгээс үл хамааран энэхүү зардалтай холбогдох хариуцлага хүлээхгүй. |
| 11. Тендерийн хэл | 11.1 Тендер, түүнчлэн тендертэй холбоотойгоор захиалагч ба тендерг оролцогчийн хооронд харилцаж буй албан бичиг, захидал болон бусад баримт бичиг нь ТШӨХ-д заасан хэл дээр бичигдсэн байна.

11.2 Аливаа тендерийн салшгүй хэсэг болох дагалдах баримт бичиг, хэвлэмэл материал нь өөр хэл дээр байж болох бөгөөд энэ тохиолдолд тэдгээр хэсгийг ТШӨХ-д заасан хэл рүү хөрвүүлсэн орчуулгыг хавсаргасан байх бөгөөд уг орчуулгыг тендерийг хянан үзэх, үнэлэхэд харгалзана. |
| 12. Тендерийн иж бүрдэл | 12.1 Тендерг оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлгээс бүрдэнэ:
(а) ТӨӨЗ-ны 13 дугаар зүйлийн дагуу бэлтгэсэн тендер ирүүлэх маягт;
(б) ТӨӨЗ-ны 13 ба 15 дугаар зүйлд заасны дагуу бэлтгэж бөглөсөн үнийн эсвэл үнэлэгдсэн ажлын тоо хэмжээний хуваарь;
(в) ТӨӨЗ-ны 20 дугаар зүйлд шаардсан тендерийн баталгаа;
(г) ТӨӨЗ-ны 21 дүгээр зүйлд заасны дагуу тендерг оролцогчийг төлөөлж тендерг гарын үсэг зурах этгээдийг томилсон тухай итгэмжлэл бичиг, мөн гарын үсгийн баталгаа;
(д) ТӨӨЗ-ны 18 дугаар зүйлд шаардсаны дагуу, тендерг оролцогч нь тухайн гэрээг хэрэгжүүлэх чадвартайг нотлох баримтууд;
(е) ТӨӨЗ-ны 17 дүгээр зүйлд заасны дагуу бэлтгэж ирүүлэх техникийн санал;
(ё) ТӨӨЗ-ны 14 дүгээр зүйлд тусгайлан зөвшөөрсөн тохиолдолд ирүүлэх хувилбарт тендер;
(ж) ТШӨХ-д шаардсан бусад баримт бичиг. |
| 13. Тендер ирүүлэх маягт ба үнийн хуваарь | 13.1 Тендерг оролцогч нь 4 дүгээр бүлэгт заасан тендерийн жишиг маягтуудаас зохих маягтыг ашиглан ТӨӨЗ-ны 12-т шаардсаны дагуу тендер ирүүлэх маягт, үнийн хуваарь ба бүх баримтыг бэлтгэж ирүүлнэ. Эдгээр маягтын үг, өгүүлбэрт утга агуулгыг нь өөрчилсөн буюу орхигдуулсан аливаа өөрчлөлт эсхүл орлуулгыг зөвшөөрөхгүй. Маягтын бүх хоосон зайд шаардсан мэдээллийг нөхөж бичнэ. |
| 14. Хувилбарт тендер | 14.1 ТШӨХ-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд хувилбарт тендерийг үл харгалзан үзнэ.

14.2 Ажил гүйцэтгэх хувилбар хугацаа ирүүлэхийг зөвшөөрсөн үед үүний улмаас үүсэх нөлөөллийн талаар болон ажил дуусгах ялгаатай хугацааг хэрхэн үнэлэх аргачлалыг ТШӨХ-д заана. |



14.3 ТООЗ-ны 14.4-т зааснаас бусад тохиолдолд тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийн шаардлагад нийцсэн техникийн хувилбарт санал ирүүлэх хүсэлтэй бол тендерийн баримт бичигт захиалагчийн тодорхойлсон зураг төсөлд хамаарах үнийн саналаа эхний ээлжинд заавал ирүүлэх, ба хувилбарт саналыг захиалагч үнэлэхэд шаардагдах ажлын зураг, зураг төсөл, техникийн тодорхойлолт, үнийн задаргаа болон санал болгож буй барилга угсралтын ажлын арга зүй, бусад холбогдох дэлгэрэнгүй мэдээлэл зэрэг бүхий л мэдээллээр хангана. Зөвхөн үндсэн техникийн шаардлагын хувьд хамгийн сайн үнэлэгдсэн тендерт оролцогчийн санал болгосон техникийн хувилбарыг захиалагч харгалзан үзнэ.

14.4 ТШӨХ-д заасан тохиолдолд гүйцэтгэх ажлын тодорхой хэсэгт харгалзан техникийн хувилбарт шийдэл ирүүлэхийг тендерт оролцогчид зөвшөөрнө. Ажлын ийм хэсгийг ТШӨХ болон 6 дугаар бүлэг (Тодорхойлолт ба бусад шаардлага)-т заана. Түүнийг үнэлэх аргачлалыг 3 дугаар бүлэг (Үнэлгээний ба чадварын шалгуур)-т тусгана.

15. Тендерийн үнэ ба хөнгөлөлт

15.1 Тендер ирүүлэх маягт ба үнийн хуваарьт тендерт оролцогчийн санал болгож буй үнэ ба хөнгөлөлт нь дараах шаардлагад нийцсэн байна.

15.2 Тендерийн үнэ нь ТООЗ-ны 1.1-д тодорхойлсон гэрээт ажлын нийт өртгийг илэрхийлэх ба тендерт оролцогчийн ирүүлсэн үнэлэгдсэн ажлын тоо хэмжээнд үндэслэнэ.

15.3 Тендерт оролцогч нь ажлыг үнэлэхдээ үнэлэгдсэн ажлын тоо хэмжээнд тусгагдсан ажлын бүх нэр төрөлд нэгж үнэ ба нийт үнийг зааж өгнө. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн ажлын нэгж үнэ ба нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд бусад нэр төрлийн ажлын үнэд багтсан гэж үзэх бөгөөд захиалагч ийм ажлын гүйцэтгэлийн төлбөрийг хийхгүй.

15.4 Тендер ирүүлэх маягтад тусгасан үнэ нь санал болгож буй үнийн хөнгөлөлтийг оруулаагүй тендерийн нийт үнэ байна.

15.5 Тендерт оролцогч нь аливаа нөхцөлт бус үнийн хөнгөлөлт болон түүнийг хэрэглэх аргачлалыг тендер ирүүлэх маягтад тусгасан байна.

15.6 Гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх төрлийн галвар хураамжийг тендер хүлээж авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнөх өдрийг үндэслэн тендерт оролцогчоос ирүүлсэн тендерийн нэгж үнэ ба нийт үнэд багтаасан байна. Тендерт оролцогч бүх холбогдох маягтад нэгж үнэ, багцын нийт үнэ, ажлын дэлгэрэнгүй тоо хэмжээг тус тус заана.

15.7 Тухайн тендерийн дагуу гүйцэтгэх ажлыг багцалсан эсэх талаарх мэдээллийг ТООЗ-ны 1.3 дугаар заалтад тусгана. Хэрэв багцалсан бол тендерт оролцогч нэг эсхүл түүнээс олон багцад тендер ирүүлэх эрхтэй.

15.8 ТШӨХ-д заасны дагуу тендерийн үнийг тогтмол байхаар эсхүл тохируулга хийх боломжтойгоор тогтооно.

(а) Тогтмол үнийг шаардсан тохиолдолд тендерт оролцогчийн үнэ нь түүний гэрээ хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байх, үнэд



аливаа нэгэн өөрчлөлт оруулахгүй. Тохируулга хийх үнэ ирүүлсэн тохиолдолд шаардлага хангахгүй гэж үзэн уг тендерээс татгалзана.

- (б) Тохируулга хийх үнийг зөвшөөрсөн бол гэрээ хэрэгжүүлэх хугацаанд тендерт оролцогчийн үнэд гэрээний нөхцөлд заасны дагуу ажиллах хүчин, түүхий эд материал, тээвэр болон гүйцэтгэгчийн тоног төхөөрөмж зэрэг зардлын зүйлд өөрчлөлт оруулж тохируулга хийх боломжтой байна. Тогтмол үнэ ирүүлсэн бол шаардлага хангахгүй гэж үзэн уг тендерээс татгалзана. Тендерт оролцогч нь 4 дүгээр бүлэг (Тендерийн маягт)-ийн тохируулгын өгөгдлийн хүснэгтэд заасан үнийн тохируулгын томъёонд харгалзах индекс ба хувийн жинг тусгаж өгөх ба захиалагч нь тендерт оролцогчоос уг санал болгосон индекс ба хувийн жинг тайлбарлахыг шаардаж болно. Индекс ба хувийн жинг заалгүй орхигдуулсан аливаа тендер ирүүлсэн оролцогчоос тодруулга хүснэ.

16. Тендерийн ба төлбөрийн валют

16.1 Тендерийн валют нь Монгол төгрөг байна.

17. Техникийн саналын бүрдэл баримт бичиг

17.1 Тендерт оролцогч нь ажлын шаардлага ба дуусгах хугацааг хангахуйц саналын талаар дэлгэрэнгүй мэдээлэл гаргах үүднээс ажил гүйцэтгэх арга, тоног төхөөрөмж, ажилтнууд, ажлын хуваарь, бусад мэдээлэл зэргийг агуулсан техникийн саналыг 6 дугаар бүлэгт заасны дагуу ирүүлнэ.

18. Тендерт оролцогчийн чадварыг нотлох баримт

18.1 Тендерт оролцогч нь 3 дугаар бүлэг (Үнэлгээний ба чадварын шалгуур)-т заасны дагуу гэрээг хэрэгжүүлэх чадвараа нотлох үүднээс 4 дүгээр бүлэг (Тендер шалгаруулалтын маягт)-ийн холбогдох хүснэгтийг бөглөн, шаардсан мэдээллийг гаргаж өгнө.

19. Тендерийн хүчинтэй хугацаа

19.1 Тендер нь тендер хүлээн авах эцсийн өдрөөс хойш, ТШӨХ-д захиалагчийн тусгайлан заасан хугацаанд хүчинтэй байна. Аливаа тендерийн хүчинтэй хугацаа нь богино байх тохиолдолд захиалагч түүнийг үндсэн шаардлага хангаагүй тендер гэж үзэж татгалзана.

19.2 Онцгой тохиолдолд, тендерийн хүчинтэй хугацааг дуусахаас өмнө захиалагч бүх тендерт оролцогчдод тендерийн хүчинтэй хугацааг сунгах хүсэлт тавина. Энэ хүсэлт ба түүний хариуг бичгээр үйлдэнэ. Тендерт оролцогч хүсэлтээс татгалзвал тендерийн баталгааг улсын орлого болгохгүй. Хүсэлтийг зөвшөөрсөн тендерт оролцогч тендерийг өөрчлөхийг санал болгох, эсхүл өөрчилж болохгүй. Хүсэлтийг зөвшөөрсөн тендерт оролцогч тендерийн баталгааны хүчинтэй хугацааг ТООЗ-ны 20 дугаар зүйлд нийцүүлэн сунгана.

20. Тендерийн баталгаа

20.1 ТШӨХ-д өөрөөр заагаагүй бол, тендерт оролцогч 5 дугаар бүлэг (Эрх бүхий орнууд)-т дурдсан эрх бүхий орны нэр хүндтэй банкнаас гаргасан, ТШӨХ-д заасан дүнтэй тендерийн баталгааг тендерийн баримт бичгийн нэг хэсэг болгон доор дурдсан хэлбэрээр эх хувиар ирүүлнэ:

- (а) нөхцөлт бус банкны баталгаа, эсхүл
- (б) бэлэн мөнгөний эсвэл баталгаат чек;



Банкны баталгааны хувьд, түүнийг 4 дүгээр бүлэг (Тендер шалгаруулалтын маягт)-т заасан маягт, эсхүл захиалагчаас хүлээн зөвшөөрсөн маягтаар ирүүлнэ. Маягтад тендерт оролцогчийн бүтэн нэрийг тусгана. Тендерийн баталгаа нь тендер хүчинтэй байх эцсийн хугацаанаас хойш, эсхүл ТӨӨЗ-ны 19.2-т заасны дагуу хүсэлт тавьсан тохиолдолд тухайн сунгасан хугацаанаас хойш 28 өдрийн хугацаанд хүчинтэй байна.

20.2 Түншлэлийг төлөөлөх гишүүн түншлэлийн тендерийн баталгааг ирүүлнэ.

20.3 ТШӨХ-д өөрөөр заагаагүй бол, шаардлагад нийцсэн тендерийн баталгаа ирүүлээгүй аливаа тендерээс шаардлага хангаагүй гэж үзэн захиалагч татгалзана.

20.4 Шалгарсан тендерт оролцогч ТӨӨЗ-ны 42-т заасны дагуу гэрээнд гарын үсэг зурж, ТӨӨЗ-ны 43-т заасны дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлмэгц, шалгараагүй тендерт оролцогчийн тендерийн баталгааг буцаан олгоно.

20.5 ТӨӨЗ-ны 42 дугаар зүйлийн дагуу шалгарсан тендерт оролцогч гэрээнд гарын үсэг зурж, ТӨӨЗ-ны 43 дугаар зүйлийн дагуу шаардсан гүйцэтгэлийн баталгааг ирүүлсэн даруйд түүний тендерийн баталгааг буцаан олгоно.

20.6 Тендерийн баталгааг дараах тохиолдолд улсын орлого болгоно:

(а) ТӨӨЗ-ны 19.2-т зааснаас бусад тохиолдолд, хэрэв тендерт оролцогч тендер хүчинтэй байх хугацаанд өөрийн тендерийг буцааж авсан, эсхүл буцааж авахыг бичгээр мэдэгдсэн; эсхүл

(б) тендерт оролцогч ТӨӨЗ-ны 32.1-ийн дагуу тендерийн үнэд хийсэн арифметик алдааны залруулгыг хүлээн зөвшөөрөөгүй бол; эсхүл

(в) шалгарсан тендерт оролцогч заасан хугацаанд багтаан:

(i) ТӨӨЗ-ны 42-ын дагуу гэрээнд гарын үсэг зураагүй бол; эсхүл

(ii) ТӨӨЗ-ны 43-ын дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй бол.

21. Тендер ирүүлэх хувь, түүнд гарын үсэг зурах

21.1 Тендерт оролцогч 12 дугаар зүйлд заасан тендерийн бүрдэл баримт бичгүүдийн нэг эх хувийг бэлтгэн хавтаслаж, түүнд “ЭХ ХУВЬ” гэсэн тодорхой бичиглэл хийнэ. Тендерт оролцогч үүнээс гадна ТШӨХ-д заасан тоо ширхэг бүхий тендерийн хуулбар хувийг бэлтгэн хавтаслаж, “ХУУЛБАР ХУВЬ” гэсэн тодорхой бичиглэл хийнэ. Эх хувь болон хуулбар хувиуд хоорондоо зөрчилдсөн тохиолдолд эх хувийг баримтлана.

21.2 Тендерийн эх болон хуулбар хувиудыг хэвлэж эсхүл арилдаггүй бэхээр бичиж, тендерт оролцогчийг төлөөлөн гарын үсэг зурах эрхтэй этгээд гарын үсэг зурж баталгаажуулна. Төлөөлөх эрхийн итгэмжлэл нь ТШӨХ-д заасны дагуу бичгээр үйлдсэн баталгаанаас бүрдэх бөгөөд үүнийг тендерт хавсаргана. Төлөөлөх эрхийн итгэмжлэлд гарын үсэг зурж байгаа хүний нэр, албан тушаалыг гарын үсгийн доод талд бичиж оруулна. Хэрэв тендерт оролцогч нь бүрэн бус итгэмжлэл ирүүлсэн бол эхний ээлжинд түүний тендерээс шууд татгалзахгүй. Захиалагч нь



ТШӨХ-д заасан хугацааны дотор шаардлагад нийцсэн итгэмжлэл ирүүлэхийг тендерт оролцогчоос хүснэ. Хүлээн зөвшөөрөхүйц итгэмжлэлийг захиалагчийн уг хүсэлтэд заасан хугацааны дотор ирүүлээгүй нь тендерээс татгалзах үндэслэл болно. Хэрэв тендер ирүүлэх маягтад гарын үсэг зурж баталгаажуулаагүй бол тендерээс татгалзана.

21.3 Мөр хооронд бичих, хасаж арилгах, давхарлан бичих зэрэг аливаа нэмэлт өөрчлөлтөд зөвхөн тендерт гарын үсэг зурсан этгээд өөрийн гарын үсгийг зурах эсхүл үзэглэсэн тохиолдолд тэдгээр өөрчлөлтийг хүчинтэйд тооцно.

Г. Тендер ирүүлэх

22. Тендерийг битүүмжлэх ба бичиглэл үйлдэх

22.1 Тендерт оролцогч өөрийн тендерийг захиалагчид шуудангаар эсхүл биечлэн хүргэнэ. ТШӨХ-д заасан бол тендерт оролцогч тендерийг цахим хэрэгслээр дамжуулан хүргэж болно.

22.2 Тендерт оролцогч тендерийн эх ба хуулбар бүх хувиндыг тус тусад нь “ЭХ ХУВЬ”, “ХУВИЛБАР ХУВЬ”, “ХУУЛБАР ХУВЬ” гэсэн бичиглэл бүхий дугтуйнд хийж битүүмжлэнэ. Эх ба хуулбар хувиндтай дугтуйнуудыг дахин нэг (гаднах) дугтуйнд давхарлан хийж битүүмжилнэ. Тендерээ дугтуйлан битүүмжлэхдээ ТӨӨЗ-ны 22.3, 22.4-г заасныг баримтлана.

22.3 Доторх ба гаднах дугтуйнууд нь:

(а) тендерт оролцогчийн нэр, хаягийг тусгасан байх;

(б) ТШӨХ-ийн 23.1-д заасны дагуу захиалагчийн нэр дээр хаягласан байх;

(в) ТШӨХ-ийн 1.1-д дурдсан тендер шалгаруулалтын нэр, ялгах дугаарыг тодорхой бичсэн байх;

(г) ТӨӨЗ-ны 26.1-г заасан тендер нээх хугацаанаас өмнө “нээж үл болно” гэсэн тэмдэглэгээг хийсэн байх шаардлагатай.

22.4 Хэрэв бүх дугтуйг ТӨӨЗ-ны 22.3 дугаар зүйлд заасан шаардлагын дагуу битүүмжилж, бичиглэл хийгээгүй нөхцөлд уг тендер буруу хаягаар хүргэгдсэн эсхүл тендер нээхээс өмнө битүүмжлэл задарсан тохиолдолд захиалагч хариуцлага хүлээхгүй.

22.5 Цахим хэрэгслээр дамжуулан тендерийг хүргүүлж байгаа тендерт оролцогч ТШӨХ-д заасан цахим хэрэгслээр тендер хүргүүлэх горимыг баримтлана.

23. Тендер хүлээн авах эцсийн хугацаа

23.1 Тендерүүдийг ТШӨХ-д заасны дагуу захиалагчийн хаягаар, тогтоосон огноо, цагаас өмнө хүргүүлнэ.

23.2 Захиалагч ТӨӨЗ-ны 9 дүгээр зүйлийн дагуу тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулсны улмаас тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгасан тохиолдолд захиалагч болон тендерт оролцогчийн эрх ба үүрэг нь сунгасан хугацааны туршид хэвээр хадгалагдана.



- 24. Хугацаа хоцорсон тендер**
- 24.1 Захиалагч ТООЗ-ны 23 дүгээр зүйлд заасан тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш ирүүлсэн аливаа тендерийг “хугацаа хоцорсон” гэж зарлан түүнээс татгалзаж, нээлгүйгээр буцаана.
- 25. Тендерийг буцааж авах, өөрчлөх, солих**
- 25.1 Тендерт оролцогч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагчид бичгээр мэдэгдэл илгээсэн бол өөрийн тендерийг буцааж авах, солих, эсхүл өөрчлөх эрхтэй.
- 25.2 Тендерийг буцааж авах, солих, өөрчлөх тухай бүх мэдэгдлийг ТООЗ-ны 21 ба 22 дугаар зүйлийн дагуу бэлтгэж ирүүлэхээс гадна холбогдох дугтуйн дээр “ТЕНДЕРИЙГ ӨӨРЧЛӨХ”, “ТЕНДЕРИЙГ СОЛИХ”, эсхүл “ТЕНДЕРИЙГ БУЦААЖ АВАХ” гэсэн бичиглэл хийнэ. Тендерийг буцааж авах мэдэгдлийг цахилгаан шуудангаар ирүүлж болох ба энэ мэдэгдлийн баталгаат эх хувийг тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө заавал ирүүлнэ.
- 25.3 Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш тендерийг өөрчлөхгүй.
- 25.4 ТООЗ-ны 25.1-д заасны дагуу тендерээ буцааж авах тухай хүсэлт ирүүлсэн тендерийг тендерт оролцогчид нээлгүйгээр буцаан олгоно.
- 25.5 Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас тендер хүчинтэй байх хугацаа дуусах хүртэл ямар ч тендерийг буцааж авах, солих, эсхүл өөрчлөхийг хориглоно.

Д. Тендерийг нээх, үнэлэх

- 26. Тендерийн нээх**
- 26.1 Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан хаяг бүхий газарт тогтоосон огноо, цагт тендерт оролцогчдоос томилсон төлөөлөгч, мөн сонирхсон аливаа бусад этгээдийг байлцуулан нийтийн өмнө нээнэ. Хэрэв төлөөлөгч тендерийн нээлтэд оролцсон бол тендерийн нээлтийн тэмдэглэл ба тендерийн нээлтийн бүртгэлийн хуудсанд гарын үсэг зурах ёстой.
- 26.2 Эхлээд “ТЕНДЕРИЙГ БУЦААЖ АВАХ” гэсэн бичиглэл бүхий дугтуйг нээж, уншин танилцуулах бөгөөд уг тендертэй дугтуйг задлахгүйгээр тендерт оролцогчид буцаана. Хэрэв тендерийг буцааж авах тухай хүсэлт нь буцааж авахыг хүссэн хүчин төгөлдөр итгэмжлэлгүй, мөн түүнийг тендерийн нээлт дээр танилцуулж уншаагүй бол ямар ч тендерийг буцаахыг үл зөвшөөрнө. Дараа нь “ТЕНДЕРИЙГ СОЛИХ” бичиглэл бүхий тендерийг нээж зарлах бөгөөд өмнө нь ирүүлсэн тендерийг түүнийг орлох тендерээр сольж, нээлгүйгээр тендерт оролцогчид түүнд буцаан олгоно. Хэрэв тендерийг солих хүсэлт нь солихыг хүссэн хүчин төгөлдөр итгэмжлэлгүй, мөн түүнийг тендерийн нээлт дээр танилцуулж уншаагүй бол ямар ч тендерийг сольж болохгүй. “ТЕНДЕРИЙГ ӨӨРЧЛӨХ” бичиглэл бүхий дугтуйг тухайн тендерийн хамт нээж нийтэд зарлана. Хэрэв тендерийг өөрчлөх хүсэлт нь өөрчлөхийг хүссэн хүчин төгөлдөр итгэмжлэлгүй, мөн түүнийг тендерийн нээлт дээр танилцуулж уншаагүй бол ямар ч тендерийг өөрчлөхийг хориглоно. Зөвхөн тендерийн нээлтийн үеэр нээж, танилцуулсан тендерийг цаашид үнэлгээнд харгалзан авч үзнэ.



- 26.3 Бүх дугуйг нэгэн зэрэг задалж, тендерт оролцогчийн нэр, тендерийн үнэ, үнийн хөнгөлөлт, хувилбарт тендер, өөрчлөлт байгаа эсэх, хэрэв шаардсан бол тендерийн баталгаа байгаа эсэх, болон захиалагч шаардлагатай гэж үзсэн бусад мэдээллийг уншиж танилцуулна. Зөвхөн тендер нээх үед зарласан үнийн хөнгөлөлт ба хувилбарт тендерийг үнэлгээнд харгалзана.
- 26.4 Захиалагч тендерийн нээлтийн тэмдэглэлийг хөглөх бөгөөд уг тэмдэглэл нь дараах мэдээллийг заавал агуулсан байна. Үүнд:
- (а) тендерт оролцогчийн нэр болон тухайн тендерээ буцааж авсан, сольсон, эсхүл өөрчилсөн эсэх;
 - (б) тендерийн үнэ, хөнгөлөлт ба хувилбарт тендер, шаардлагатай бол эдгээр мэдээллийг багц тус бүрээр гаргах;
 - (в) тендерийн баталгаа шаардсан бол түүнийг ирүүлсэн эсэх.
- 26.5 Хугацаа хоцорсон тендерээс бусад тохиолдолд тендерийн нээлтийн үеэр тендерээс татгалзахыг зөвшөөрөхгүй.

27. Нууцлал

- 27.1 Тендерийг хянан үзэх, тодруулах, үнэлэх, харьцуулах, чадварыг дахин магадлах болон гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжтэй холбогдсон мэдээллийг тендерт оролцогч болон тухайн тендер шалгаруулалтын үйл ажиллагаатай албан ёсоор холбогдолгүй аливаа этгээдэд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийг бүх тендерт оролцогчдод хүргэх хүртэл хугацаанд задруулахыг хориглоно.
- 27.2 Захиалагч тендерийг хянан үзэх, үнэлэх, харьцуулах, чадварыг дахин магадлах явцад, эсхүл гэрээ байгуулах эрх олгох шийдвэрт тендерт оролцогчоос нөлөөлөх гэсэн аливаа оролдлого нь тухайн оролцогчийн тендерээс татгалзах үндэслэл болж болно.
- 27.3 Тендерийн нээлтээс гэрээ байгуулах эрх олгох хүртэл хугацаанд тендерт оролцогч тендер шалгаруулалтын асуудлаар захиалагчтай харьцах бол зөвхөн бичгээр харилцана.

28. Тендерийг тодруулах

- 28.1 Тендерийг хянан үзэх, үнэлэх, харьцуулахад туслах зорилгоор захиалагч тендерт оролцогчоос түүний тендерийн талаар тодруулга ирүүлэхийг хүсч болно. Тодруулга хүсэх, түүнд хариулт авахдаа зөвхөн албан бичгээр харилцана. ТӨӨЗ-ны 32-т заасны дагуу тендерийг үнэлэх үед захиалагчийн илрүүлсэн арифметик алдааг залруулахаас бусад тохиолдолд тендерийн үнэ ба агуулгыг өөрчлөхийг хүсэх, санал болгох, эсхүл зөвшөөрөхийг хориглоно.

29. Зөрүү, болзолт нөхцөл ба орхигдуулсан зүйл

- 29.1 Тендер үнэлэх явцад дараах ойлголтууд хэрэглэгдэнэ:
- (а) “Зөрүү” гэдэг нь тендерийн баримт бичигт заасан шаардлагаас өөр аливаа ялгааг хэлнэ;
 - (б) “Болзолт нөхцөл” гэдэг нь хязгаарлагдмал нөхцөл тогтоох эсхүл тендерийн баримт бичигт заасан шаардлагыг бүрэн хүлээн зөвшөөрөхөөс татгалзахыг хэлнэ;
 - (в) “Орхигдуулсан зүйл” гэдэг нь тендерийн баримт бичигт шаардсан мэдээлэл эсхүл баримт бичгийг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг нь ирүүлэхгүй байх алдааг хэлнэ.



30. Тендерийг хянан үзэх, шаардлагад нийцсэн эсэхийг тогтоох

- 30.1 Захиалагч аливаа тендерийг шаардлагад нийцэж байгаа эсэхийг тогтооходоо ТООЭ-ны 12-т заасны дагуу уг тендер нь агуулгын хувьд шаардлага хангаж буй эсэхэд үндэслэнэ.
- 30.2 ТООЭ-ны 30.1-д дурдсан бүх шаардлагыг хангаж байгаа тохиолдолд уг тендерийг шаардлагад үндсэндээ нийцсэн тендер гэж үзнэ.
- 30.3 Шаардлагад үндсэндээ нийцсэн тендер гэж тендерийн баримт бичигт дурдсан бүх шаардлагыг том зөрүү, болзолт нөхцөл, эсхүл орхигдуулсан зүйлгүйгээр хангасан тендерийг хэлнэ. Доор дурдсан зүйлсийг том зөрүү, болзолт нөхцөл, эсхүл орхигдуулсан зүйл гэж үзнэ. Үүнд:
- (а) гэрээнд дурдсан ажлын хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд үлэмж нөлөө үзүүлэхээр бол;
 - (б) гэрээнд заасан захиалагчийн эрх ба тендерт оролцогчийн үүрэг, тендерийн баримт бичигтэй үл нийцэх зарчмын хязгаарлалт оруулсан бол;
 - (в) үнийн саналыг хүлээн зөвшөөрөх, эсвэл залруулах замаар шаардлагад нийцсэн бусад тендерт оролцогчийн өрсөлдөөнт байдалд шударга бусаар нөлөөлөх бол.
- 30.4 Хэрэв тендер нь тендерийн баримт бичгийн шаардлагад үл нийцэж байвал, захиалагч уг тендерээс татгалзах бөгөөд том зөрүү, болзолт нөхцөл, эсхүл орхигдуулсан зүйлд засвар хийж замаар ийм тендерийг шаардлагад нийцсэн болгож болохгүй.
- 30.5 Том зөрүү, болзолт нөхцөл эсхүл орхигдуулсан зүйлгүйгээр, 6 дугаар бүлэг (Тодорхойлолт ба бусад шаардлага)-г тусгасан бүх шаардлагыг хангаж байгаа эсэхийг баталгаажуулах үүднээс захиалагч техникийн тодорхойлолтыг хянан үзнэ.

31. Жижиг зөрүү

- 31.1 Хэрэв тендерийг үндсэндээ шаардлага хангасанд тооцсон бол энэ тендерийн аливаа зөрүү, болзолт нөхцөл эсвэл орхигдуулсан зүйлд том шинжийг агуулаагүй ийм жижиг зөрүүг захиалагч харгалзахгүй байж болно.
- 31.2 Хэрэв тендерийг үндсэндээ шаардлага хангасанд тооцсон бол баримтжуулах шаардлагын улмаас тендерийн жижиг зөрүүг засах үүднээс шаардлагатай мэдээлэл эсхүл баримтыг тодорхой хугацаанд ирүүлэхийг захиалагч тендерт оролцогчоос хүсч болно. Гэхдээ ийм жижиг зөрүүний талаарх мэдээлэл эсхүл баримтыг хүсэх нь тендерийн үнэд өггхон ч хамааралгүй байх ёстой. Тендерт оролцогч ийм хүсэлтийг биелүүлээгүй нь уг тендерээс татгалзах үндэслэл болно.
- 31.3 Хэрэв тендерийг үндсэнд нь шаардлага хангасанд тооцсон бол захиалагч тендерийн үнэд хамааралтай, тоогоор илэрхийлэгдэж болохуйц жижиг зөрүүг засаж залруулна. Үүний үр дүнд орхигдуулсан эсхүл нийцээгүй зүйл эсхүл бүрэлдэхүүн хэсгийн үнийг тусгахын тулд зөвхөн харьцуулах зорилгоор тендерийн үнэд залруулга хийнэ. Залруулга хийхдээ 3 дугаар бүлэг (Үнэлгээний ба чадварын шалгуур)-г тодорхойлсон аргачлалыг хэрэглэнэ.



32. Арифметик алдааг залруулах

32.1 Захиалагч шаардлагад нийцсэн гэж тодорхойлогдсон тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна. Үүнд:

- (а) зөвхөн нэгж үнийн гэрээнд, хэрэв нэр төрлийн нэгж үнэ нь нэгж үнийг тоо ширхэгээр үржүүлэхэд гарсан дүнгээс зөрвөл нэр төрлийн нэгж үнийг үндэслэн түүний нийт үнийг залруулна. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна;
- (б) нэр төрлийн нийт үнийн нийлбэр эсвэл ялгавар нь нийт үнээс зөрвөл нэр төрлийн нийт үнийн нийлбэр эсвэл ялгаврыг баримтлаж, нийт үнийг залруулна;
- (в) ажлын тоо хэмжээнд заасан нийт үнэ нь тендер ирүүлэх маягтад дурдсан тендерийн нийт үнээс зөрвөл ажлын тоо хэмжээнд заасан нийт үнийг баримтлаж, тендер ирүүлэх маягтад заасан тендерийн нийт үнийг залруулна.
- (г) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлсэн дүн нь арифметик алдаатай холбоотой байхаас бусад тохиолдолд үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзэх бөгөөд харин үсгээр илэрхийлсэн дүн нь арифметик алдаатай холбогдсон тохиолдолд дээрх (а) (б) ба (в) хэсэгт заасны дагуу тоогоор илэрхийлсэн дүнг баримтална.

32.2 Захиалагч хамгийн сайн үнэлэгдсэн тендерийн үнэд залруулга хийхээр байвал энэ талаар тухайн тендерт оролцогчид мэдэгдэж, хүлээн зөвшөөрсөн эсэхийг бичгээр баталгаажуулж авна.

32.3 Хэрэв хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн тендерт оролцогч нь тендерийн үнэд хийсэн арифметик алдааны залруулгыг хүлээн зөвшөөрөөгүй бол уг тендерээс татгалзан тендерийн баталгааг улсын орлого болгоно.

33. Давуу эрхийн зөрүү

33.1 Тендерийн үнэлгээнд давуу эрхийн зөрүүг тооцохгүй.

34. Тендерийг үнэлэх, харьцуулах

34.1 Захиалагч нь энэ зүйлд заасан шалгуур, аргачлалыг үнэлгээнд ашиглана. Өөр шалгуур, аргачлал ашиглахыг үл зөвшөөрнө.

34.2 Захиалагч тендерийг үнэлэхдээ тендерийн үнэд дараах байдлаар залруулга хийж, тендерийн харьцуулах үнийг тодорхойлно. Үүнд:

- (а) ТООЗ-ны 32.1-д заасны дагуу арифметик алдааг шалгаж тендерийн үнийг залруулах;
- (б) ажлын тоо хэмжээний нэгтгэл дэх нөхцөлт зардал болон магадлашгүй ажлын зардлыг тунг хасч, өдөр-ажлын зардлыг оруулан тооцсон тендерийн үнэ;
- (в) ТООЗ-ны 15.5-д заасны дагуу санал болгосон үнийн хөнгөлөлтийг тооцож тусгах;
- (г) ТООЗ-ны 31-д заасны дагуу тоогоор илэрхийлж болох жижиг зөрүүг тендерийн үнэд тусгах;
- (д) ТООЗ-ны 37-д заасны дагуу тендер нь хэт бага үнэтэй эсэхийг үнэлэх;
- (е) 3 дугаар бүлэг (Үнэлгээний ба чадварын шалгуур)-т дурдсан үнэлгээний хүчин зүйлсийг ашиглах.



34.3 Захиалагч нь аливаа өөрчлөлт, зөрүү ба хувилбарт тендерийг хүлээн зөвшөөрөх, эсхүл татгалзах эрхтэй. Захиалагч тендерийн баримт бичгийн шаардлагад заагаагүй давуу зүйлийг нэмэлтээр тусгасан өөрчлөлт, зөрүү, хувилбарт тендерийг тендерийн үнэлгээнд үл харгалзана.

34.4 Хэрэв энэхүү тендерийн баримт бичигт тендерт оролцогчийг ялгаатай гэрээнүүдийн хувьд тусад нь үнэ ирүүлэхийг, түүнчлэн хэд хэдэн гэрээ байгуулах эрхийг нэг тендерт оролцогчид олгохыг зөвшөөрсөн бол гэрээний хослолын хувьд хамгийн бага харьцуулах үнийг, тендер ирүүлэх маягтад санал болгосон аливаа хөнгөлөлтийг оролцуулан тодорхойлох аргачлалыг 3 дугаар бүлэг (Үнэлгээний ба чадварын шалгуур)-т заасан болно.

34.5 Захиалагч ТООЗ-ны 34.2-т заасны дагуу хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг тогтоохын тулд шаардлагад нийцсэн бүх тендерийг харьцуулна.

35. Тендерт оролцогчийн чадвар

35.1 Захиалагч нь шаардлагад нийцсэн, хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн тендерт оролцогч 3 дугаар бүлэг (Үнэлгээний ба чадварын шалгуур)-т заасан чадварын шалгуурыг хангаж байгаа эсэхийг шалгаж тодорхойлно.

35.2 Тендерт оролцогчийн чадварыг тодорхойлохдоо ТООЗ-ны 18.1-д заасны дагуу тендерт оролцогчийн ирүүлсэн чадварыг нотлох баримт болон ТООЗ-ны 28-д дурдсан шаардлагатай нэмэлт тодруулгад үндэслэнэ.

35.3 Хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн тендерт оролцогчийн чадварыг дахин магадлах нь түүнд гэрээ байгуулах эрх олгох урьдчилсан нөхцөл болно. Хэрэв шаардлага хангахгүй бол уг тендерээс татгалзаж, дараагийн сайн үнэлэгдсэн тендерт оролцогчийн чадварыг мөн адил зарчмаар магадлана.

36. Аливаа тендерийг хүлээн зөвшөөрөх, эсхүл аливаа эсхүл бүх тендерээс татгалзах захиалагчийн эрх

36.1 Захиалагч аливаа тендерийг хүлээн зөвшөөрөх эсхүл татгалзах, мөн тендер шалгаруулалтыг хүчингүй болгох, гэрээ байгуулах эрх олгохоос өмнөх аль нэг хугацаанд бүх тендерээс татгалзах эрхтэй бөгөөд үүнтэй холбоотойгоор тендерт оролцогчдын өмнө ямарваа нэг хариуцлага хүлээхгүй. Тендер шалгаруулалтыг хүчингүй болгосон тохиолдолд, ирүүлсэн бүх тендерийг, ялангуяа тендерийн баталгааг тендерт оролцогчдод нэн даруй буцаан олгоно.

37. Хэт бага үнэтэй тендер

37.1 Хэт бага үнэтэй тендер гэдэгт тендерийн үнэ нь тендерийн бусад бүрдэл зүйлсийн хамт хэт доогуур байгаа бөгөөд энэ нь тендерт оролцогч гэрээг санал болгосон үнээрээ хэрэгжүүлэх боломжтой эсэх талаар эргэлзээ төрүүлж байгаа тендерийг ойлгоно.



37.2 Санал болгож буй тендерийн үнэ нь хэт бага байх тохиолдолд захиалагч нь дор дурдсан 3 шатлалаар хянан үзнэ. Үүнд:

(а) хэт бага зардал болон нэгж үнийг инженерийн төсөв, шаардлага хангасан бусад тендер, сүүлийн үед гэрээний эрх олгогдсон ижил төстэй гэрээтэй харьцуулж тодорхойлно;

(б) тендерт оролцогчийн нөөц орц, үнэ тогтоосон аргачлал, нэмэгдэл зардал, магадлангүй ажлын зардал болон ангийн хувь зэргийг тодруулж дүн шинжилгээ хийнэ;

(в) уг тендерийг хүлээн зөвшөөрөх эсхүл татгалзах талаар шийднэ.

37.3 Дээд дурдсан ТӨӨЗ-ны 37.2 (б)-д заасантай холбогдуулан, захиалагч нь санал болгож буй арга зүй, ажил гүйцэтгэх хуваарь, эрсдлийн ба чиг үүргийн хуваарилалт зэрэгт уялдуулан тендерт оролцогчоос зардал ба нэгж үнийн дэлгэрэнгүй шинжилгээ гэх мэт санал болгосон тендерийн үнийн талаар тайлбарыг бичгээр ирүүлэхийг хүснэ. Энэ нь үйлдвэрлэлийн процессын үр өгөөж; үзүүлж буй үйлчилгээ, эсхүл барилга угсралтын арга барил; хэрэгжүүлэх техникийн шийдэл болон тендерт оролцогчийн хувьд санал болгож буй ажлыг гүйцэтгэхэд хэрэглэх тоног төхөөрөмж, үйлчилгээний хувьд тусгайлсан давуу нөхцөл байдал байгаа эсэх талаар мэдээлэл агуулж болно.

37.4 Тендерт оролцогчийн ирүүлсэн тайлбар, үнийн дэлгэрэнгүй шинжилгээг хянан үзсэний дараа захиалагч нь дараах арга хэмжээг хэрэгжүүлж болно. Үүнд:

(а) хэрэв бага үнэ ба зардлын талаар хангалттай ирүүлсэн нотолгоо нь тендерийн хэт бага үнэтэй гэж үзэхээргүй бол уг тендерийг хүлээн зөвшөөрөх;

(б) тендерийг хүлээн зөвшөөрөх, гэхдээ санхүүгийн алдагдлаас захиалагчийг хамгаалахад хүрэлцэхүйц түвшинд гүйцэтгэлийн баталгааны дүнг тендерт оролцогчийн зардлаар нэмэгдүүлэхийг шаардах. Гүйцэтгэлийн баталгааны дүн нь ихэнхдээ гэрээний үнийн 20 хувиас хэтрэхгүй байна;

(в) бага үнэтэй тендерийн хувьд ирүүлсэн нотолгоог хангалтгүй гэж үзвэл уг тендерээ татгалзах ба дараагийн сайн үнэлэгдсэн тендерийг хэрэв шаардлагатай бол нэгэн адил нягтална.

38.1 Захиалагчийн дүгнэснээр, хэрэв хамгийн бага харьцуулах тендерийн үнэ нь нилээд тэнцвэргүй эсхүл урьдчилан нэмж тооцсон зардалтай байх тохиолдолд, барилга угсралтын арга барил, ажил гүйцэтгэх хуваарьтай холбоотой үнэ, түүнчлэн түүхий эд материал, тоног төхөөрөмж, хөдөлмөрийн зардлын үнэлгээ, эх үүсвэрийн талаарх хоорондын уялдаа хамаарлыг баталгаажуулах зорилгоор захиалагч нь тендерт оролцогчоос үнийн дэлгэрэнгүй тооцоог ажлын тоо хэмжээнд заасан зарим нэг эсхүл бүх нэр төрлийн хувьд гаргаж ирүүлэхийг шаардаж болно.

38.2 Тендерт оролцогчийн ирүүлсэн мэдээлэл, үнийн дэлгэрэнгүй шинжилгээг хянан үзсэний дараа захиалагч нь дараах арга хэмжээг хэрэгжүүлж болно. Үүнд:

(а) тендерийг хүлээн зөвшөөрөх;

**38. Тэнцвэргүй,
эсхүл зардлыг
урьдчилан нэмж
тооцсон тендер**



39. Гэрээ байгуулах эрх олгох тухай илэрхийлэл бүхий мэдэгдэл

- (б) тендерийг хүлээн зөвшөөрөх, гэхдээ ТООЗ-ны 43.2-т зааснаар шалгарсан тендерт оролцогч үүргээ биелүүлээгүйн улмаас санхүүгийн алдагдлаас захиалагчийг хамгаалахад хүрэлцэхүйц түвшинд гүйцэтгэлийн баталгааны дүнг тендерт оролцогчийн зардлаар нэмэгдүүлэхийг шаардах; эсхүл
- (в) уг тендерээс татгалзах ба дараагийн сайн үнэлэгдсэн тендерийг нэгэн адил нягтална.

39.1 Хэрэв түр зогсоох нөхцөлийг ТШӨХ-д заасны дагуу хэрэглэх бол аливаа шалгараагүй оролцогчийн хувьд гэрээ байгуулах эрх олгох шийдвэрийн эсрэг гомдол гаргах боломж олгох үүднээс гэрээ байгуулах эрх олгох илэрхийлэл бүхий мэдэгдэл (гэрээ байгуулах эрхийг бодитоор олгохоос өмнө)-ийн дараа тодорхой хугацааг заах зорилгоор уг түр зогсоох хугацааг ТШӨХ-д оруулна.

Е. Гэрээ байгуулах эрх олгох

40. Гэрээ байгуулах эрх олгох шалгуур

40.1 Захиалагч тендерийн баримт бичгийн шаардлагад нийцсэн бөгөөд “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн тендер ирүүлсэн, гэрээг амжилттай хэрэгжүүлэх чадвартай хэмээн тодорхойлсон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгоно.

40.2 “Хамгийн сайн” гэж үнэлэгдсэн тендер ирүүлсэн тендерт оролцогч ТООЗ-ны 32-т заасны дагуу захиалагчийн залруулсан арифметик алдааг хүлээн зөвшөөрөөгүй, эсхүл бичгээр харну ирүүлээгүй бол захиалагч түүний тендерээс татгалзах бөгөөд 20.6(б)-д заасны дагуу түүний тендерийн баталгааг улсын орлого болгоно.

41. Гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл

41.1 Тендерийн хүчинтэй хугацаа дуусахаас өмнө, ТООЗ-ны 39.1-д заасан түр зогсоох хугацаа дуусгавар болмогц, эсхүл хэрэв шаардлагатай бол, уг түр зогсоох хугацаанд гарсан гомдлыг бүрэн шийдвэрлэсний дараа захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид тендер шалгарсан тухай гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийг 9 дүгээр бүлэг (Гэрээний маягт)-т заасан маягтыг ашиглан, бичгээр хүргүүлнэ.

41.2 Түр зогсоох хугацааг хэрэглээгүй тохиолдолд, гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл гармагц шалгараагүй тендерт оролцогч нь өөрийн тендерийн шалгараагүй үндэслэлийг тодруулахаар захиалагчид бичгээр тайлбар авах хүсэлт гаргаж болно. Захиалагч нь гэрээний эрх олгох тухай шийдвэрийг нийтэд зарлаж мэдээлсэний дараа тайлбар авахыг хүссэн тендерт оролцогчид тендер шалгараагүй үндэслэлийг бичгээр эсхүл тайлбар өгөх уулзалтын үед нэн дариу хариултыг өгнө.

41.3 Гэрээ албан ёсоор хэрэгжиж эхлэх хүртэл хугацаанд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь талуудын хооронд байгуулсан хэлцэл болно.



- 41.4 Хэрэв гэрээ байгуулах эрх олгосноос эсхүл түр зогсоох хугацааг хэрэглэж байгаа бол уг хугацааг дууссанаас хойш 2 долоо хоногийн дотор, эсхүл түр зогсоох хугацаанд аливаа гомдол гарсан тохиолдолд, гомдлыг шийдвэрлэсэн талаар АХБ-наас баталгаажсан хариуг хүлээн авмагц; захиалагч нь бүх тендерт оролцогчдод тендер шалгаруулалтын үр дүнг мэдэгдэнэ. Захиалагч Засгийн газрын худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим хуудсанд тендерийн нэр болон багцын дугаарыг дараах мэдээллийн хамт нийтэлнэ:
- а) тендер ирүүлсэн тендерт оролцогч бүрийн нэр;
 - б) тендерийн нээлтэд уншиж танилцуулсан тендерийн үнэ;
 - в) үнэлгээнд хамрагдсан тендер бүрийн нэр, үнэлэгдсэн үнэ;
 - г) шалгараагүй тендерт оролцогчийн нэр, тендерээс татгалзсан шалтгаан;
 - д) шалгарсан тендерт оролцогчийн нэр, санал болгосон үнэ, эрх олгогдсон гэрээний хугацаа ба срөнхий агуулга.
- 41.5 Шалгарсан тендерт оролцогч ТООЗ-ны 43-т заасны дагуу гүйцэтгэлийн баталгаа гарган, гэрээнд гарын үсэг зурсаны дараа захиалагч ТООЗ-ын 20.5-д заасан хугацаанд тендерийн баталгааг буцаах талаар бүх тендерт оролцогчдод мэдэгдэнэ.
- 42. Гэрээнд гарын үсэг зурах**
- 42.1 Захиалагч нь гэрээний маягтыг гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийн хамт шалгарсан тендерт оролцогчид илгээнэ.
- 42.2 Шалгарсан тендерт оролцогч нь гэрээний маягтыг хүлээн авсанаас хойш 28 хоногийн дотор гэрээнд гарын үсэг зурж захиалагчид хүргүүлнэ.
- 43. Гүйцэтгэлийн баталгаа**
- 43.1 Гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийг хүлээн авсанаас хойш 28 хоногийн дотор шалгарсан тендерт оролцогч нь гүйцэтгэлийн баталгааг ГЕН-ийн дагуу 9 дүгээр бүлэг (Гэрээний маягт)-т тусгагдсан гүйцэтгэлийн баталгааны маягтыг ашиглан ирүүлнэ.
- 43.2 Шалгарсан тендерт оролцогч ТООЗ-ны 43.1-д заасан шаардлагыг биелүүлээгүй нь гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгох болон тендерийн баталгааг улсын орлого болгох хангалттай үндэслэл болно. Ийм тохиолдолд захиалагч удаах “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн тендер ирүүлсэн бөгөөд гэрээг амжилттай хэрэгжүүлэх чадвартай хэмээн тодорхойлсон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 44. Тендер шалгаруулалттай холбоотой гомдол**
- 44.1 Энэхүү тендер шалгаруулалттай холбогдон гарсан гомдлыг шийдвэрлэх тухай горимыг ТШӨХ-д заасан болно.



2 дугаар бүлэг – Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт

Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтийг хэрэглэх заавар

Тендерийн баримт бичгийн 2 дугаар бүлэгт захиалагчийн шаардлагын дагуу шаардлагад нийцсэн тендерийг бэлтгэхэд тендерт оролцогчдод зайлигүй шаардлагатай мэдээллийг тусгасан болно.

Худалдан авах ажлын талаарх доор дурдсан тусгайлсан өгөгдөл нь Тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа (ТӨӨЗ)-ны холбогдох зүйл, заалтад нэмэлт мэдээлэл оруулах, эсхүл өөрчлөх зорилготой. ТШӨХ-ийг бэлтгэхэд туслах үүднээс бүх заалтууд нь ТӨӨЗ-ны холбогдох зүйл заалтын дугаартай ижилээр дугаарлагдсан болно.

Захиалагч ташуу хэлбэрээр бичигдсэн хэсэгт тусгайлсан мэдээллийг оруулж өгнө. Захиалагч тендерийн баримт бичгийг зурслах үедээ ташуу болон жижиг үсгээр бичигдсэн хэсгийг устгана. Эцсийн баримт бичигт хоосон зайг эсхүл сонголын аль алиныг тусгайхгүй.



А. Ерөнхий зүйл	
ТӨӨЗ 1.1	Тендерийн урилга (ТУ)-ын дугаар: CW-3-1
ТӨӨЗ 1.1	Захиалагч: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ТӨӨЗ 1.1	Нээлттэй өрсөлдөөнт тендер шалгаруулалт (НӨТШ)-ын нэр: Услалтын системийг шинэчлэн сайжруулах барилгын ажил Эрдэнэбүрэн дэд төсөл (Эрдэнэбүрэн, Ховд) НӨТШ-ын ялгах дугаар: CW-3-1
ТӨӨЗ 1.2	Ажлыг дуусгах огноо: 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр
ТӨӨЗ 1.3	Энэхүү НӨТШ-ыг бүрдүүлж байгаа багц бүрийн ялгах дугаар ба нэр: Байхгүй
ТӨӨЗ 2.1	Зээлдэгч: Монгол улс
ТӨӨЗ 2.1	Төслийн нэр: Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй төсөл (L3895/L3896/G9205-MON)
ТӨӨЗ 4.8	Ажил гүйцэтгэхэд шаардагдах тусгай зөвшөөрөл: “шаардлагатай”. Тусгай зөвшөөрлийн ялгах дугаар ба нэр: Барилга хот байгуулалтын сайдын 2018 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 11 дүгээр тушаалаар батлагдсан суурь нөхцөл, шаардлага: (Барилга хот байгуулалтын сайдын 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 147 дугаар тушаалаар батлагдсан суурь нөхцөл, шаардлагатай дүйцнэ) 1. БА 3.2 Усны барилга байгууламжийн угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил буюу түүнээс дээш ангилалд хамаарах тусгай зөвшөөрөл 2. БА 2.1 Цутгамал болон угсармал төмөр бетон, мод ба өрөгт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил) буюу түүнээс дээш ангилалд хамаарах тусгай зөвшөөрөл 3. БА 3.3 ба эсхүл түүнтэй дүйцэх 2.2.3. Ус хангамж, ариутгах татуургын гол (магистраль) шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт буюу түүнээс дээш ангилалд хамаарах тусгай зөвшөөрөл 4. БА 3.5 ба эсхүл түүнтэй дүйцэх 2.2.8. Цахилгаан дамжуулах шугам сүлжээ, дэд станц, түүний тоног төхөөрөмжийн угсралт буюу түүнээс дээш ангилалд хамаарах тусгай зөвшөөрөл 5. БА 8.1 ба эсхүл түүнтэй дүйцэх 2.1.1. Барилга байгууламжийн засвар, засал чимэглэл, интерьер, орчны тохижилтын ажил Эдгээр тусгай зөвшөөрлийг гадаадын тендерт оролцогчоос үл шаардана. Хэрэв гадаадын тендерт оролцогч тендерт оролцох бол хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөлтэй дотоодын тендерт оролцогчтой хамтран оролцож болно.
ТӨӨЗ 6.1	Түншлэлийн гишүүд дараах нэмэлт шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд: “байхгүй”
Б. Тендерийн баримт бичиг	
ТӨӨЗ 8.1	Зөвхөн <u>тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга авах зорилгоор</u> , tender.gov.mn цахимаар оруулна. Захиалагч тодруулга авах хүсэлтийг тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 өдрийн өмнө хүлээн авна.
ТӨӨЗ 8.4	Тендерийн өмнөх уулзалтыг зохион байгуулах эсэх: тийм Огноо: 2024 оны 5 дугаар сарын 02-ны өдөр Цаг: 11 цаг 00 минут, Улаанбаатарын цагаар Газар: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Энхтайвны өргөн чөлөө 18А/1, Хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбооны байр, 3 давхар, 306 тоот Захиалагч ажлын талбайтай танилцах ажлыг зохион байгуулах эсэх: “зохион байгуулахгүй”



В. Тендер бэлтгэх

ТӨӨЗ 11.1	Тендерийн албан хэл нь Монгол хэл байна.
ТӨӨЗ 11.2	Дагалдах баримт, хэвлэмэл материалыг Монгол хэл рүү орчуулсан байна.
ТӨӨЗ 12.1 (ж)	Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерийн хамт ирүүлнэ: 1. ТӨӨЗ 4.8-д дурьдсан бүх тусгай зөвшөөрлийг ирүүлнэ.
ТӨӨЗ 14.1	Хувилбарт тендер ирүүлэхийг “зөвшөөрөхгүй”
ТӨӨЗ 14.2	Ажил дуусгах хувилбарт хугацааг “зөвшөөрнө” Хэрэв ажил дуусгах хувилбарт хугацаа ирүүлэхийг зөвшөөрсөн бол үнэлгээний аргачлалыг 3 дугаар бүлэг (Үнэлгээний ба чадварын шалгуур)-т тусгана.
ТӨӨЗ 14.4	Хувилбарт техникийн шийдэл ирүүлэхийг гүйцэтгэх ажлын дараах бүрэлдэхүүн хэсэгт зөвшөөрнө: “байхгүй”
ТӨӨЗ 15.8	Тендерт оролцогчийн ирүүлсэн үнэ нь “тохируулга хийх үнэ”, Үнийн тохируулга хийх томъёо болон дэлгэрэнгүй тайлбарыг ГТН 56.1-д заасан. Тендерт оролцогч нь 4 дүгээр бүлэг (Тендерийн маягт)-ийн тохируулга хийх өгөгдлийн хүснэгтийг бөглөж ирүүлнэ.
ТӨӨЗ 17.1	КОВИД-19-өөс урьдчилан сэргийлэх болон түүнд хяналт тавих тухай засгийн газрын холбогдох дүрэм журам Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай МУ-ын хууль, олон улсын шилдэг туршлага бүхий Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага. 2020. КОВИД-19-тэй уялдан ажлын байранд авч хэрэгжүүлэх нийтийн эрүүл мэнд ба нийгмийн арга хэмжээнд анхаарах зүйлс. Женев. https://www.who.int/publications-detail/considerations-for-public-health-and-social-measures-in-the-workplace-in-the-context-of-covid-19] нийцүүлэн, КОВИД-19-д хамаарах эрүүл мэнд ба аюулгүй байдлын төлөвлөгөө (ЭМАБ-К19 төлөвлөгөө)-г техникийн саналд заавал тусгах ёстой. Захиалагч ЭМАБ-К19 төлөвлөгөөг хавсаргаагүй тендерээс шаардлага хангаагүй гэж үзэн татгалзаж болно. Хэрэв тендерт оролцогч тендерийн баримт бичигт захиалагчаас шаардсан мэдээллийн дагуу хангалттай мэдээлэлгүй ЭМАБ-К19 төлөвлөгөөг ирүүлсэн тохиолдолд захиалагч тендерт оролцогчоос нэмэлт мэдээлэл авах тухай тодруулгыг хүргүүлнэ. Тендерт оролцогч ийм хүсэлт авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан шаардсан мэдээллийг хүргүүлэх ёстой. Дурдсан хугацаанд хангалттай хариу ирүүлээгүй бол тухайн тендерээс татгалзана.
ТӨӨЗ 19.1	Тендер хүчинтэй байх хугацаа нь 90 өдөр байна.
ТӨӨЗ 20.1	Тендерийн баталгааг ирүүлэх “шаардлагатай”. Хэрэв шаардсан бол, тендерийн баталгааны хэмжээ ба валют:169,000,000 төгрөг.



ТӨӨЗ 20.3	Дор дурдсан нөхцөлийн дагуу, буцаах ба нэхэмжлэх нөхцөлт бус тендерийн баталгаа ирүүлээгүй аливаа тендерээс захиалагч шаардлага хангаагүй гэж үзэн татгалзана. Хэрэв тендерт оролцогчийн ирүүлсэн тендерийн баталгаа нь (i) маягт, хэмжээ ба/эсвэл хүчинтэй байх хугацаагаар зөрүүтэй байх, эсхүл (ii) тендерт оролцогчийн талаар тодорхой мэдээлэл агуулаагүй (хязгаарлалт заагаагүй, түншлэлийн нэрийг, эсхүл хэрэв түншлэл хараахан байгуулагдаагүй бол ирээдүйн түншлэлийн гишүүдийн нэрийг дурдаагүй) бол захиалагч нь тендерт оролцогчийг заасан 14 өдрийн дотор шаардлага хангасан тендерийн баталгаа ирүүлэхийг хүснэ. Шаардлага хангасан тендерийн баталгааг уг хүсэлтэд заасан хугацааны дотор ирүүлээгүй нь тухайн тендерээс татгалзах үндэслэл болно.
ТӨӨЗ 21.1	Тендерийн эх хувиас гадна ирүүлэх хуулбар хувийн тоо: Ашиглахгүй.
ТӨӨЗ 21.2	Тендерт оролцогчийг төлөөлөн гарын үсэг зурах эрхийн баталгаа нь дараах баримтаас бүрдэнэ: Тендерт оролцогчийн нэрийн өмнөөс гарын үсэг зурах этгээдийг тодорхойлсон тухай бүтэц зохион байгуулалтын баримт бичиг, удирдах зөвлөлийн шийдвэр, эсхүл түүнтэй дүйцэх баримт бичиг эсхүл төлөөлөх эрхийн итгэмжлэл. Хэрэв тендерт оролцогч түншлэлээр оролцох бол түншлэлийн бүх гишүүд энэ итгэмжлэлд гарын үсэг зурсан байх ёстой бөгөөд түншлэлийн нэрийн өмнөөс гарын үсэг зурах эрх бүхий этгээдийг нэрлэж баталгаажуулна. Хэрэв түншлэл байгуулагдаж амжаагүй бол гэрээний эрх авах үед түншлэл байгуулах илэрхийллийн тухай түншлэлийн бүх гишүүдээс ирүүлсэн баталгааг гаргаж өгнө.
ТӨӨЗ 21.2	Тендер оролцогч нь шаардлагад нийцсэн буюу хүлээн зөвшөөрөхүйц итгэмжлэлийг 14 өдрийн дотор ирүүлнэ.
Г. Тендер ирүүлэх	
ТӨӨЗ 22.1	Тендерт оролцогч тендерийг цахим хэрэгслээр дамжуулан ирүүлэх "шаардлагатай".
ТӨӨЗ 22.3 (б)	Захиалагчийн хаяг (зөвхөн тендер хүлээн авах зорилгоор): Тендерт оролцогчид төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (https://tender.gov.mn)-ээр тендерээ ирүүлнэ.
ТӨӨЗ 22.5	Хэрэв тендерт оролцогч тендерийг цахим хэрэгслээр дамжуулан ирүүлэхээр бол тендерийг цахим хэрэгслээр дамжуулан ирүүлэх дараах горимыг баримтлана. Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (https://tender.gov.mn)-ийг ашиглана.
ТӨӨЗ 23.1	Тендер хүлээн авах эцсийн хугацаа: Огноо: 2024 оны 5 дугаар сарын 20-ны өдөр Цаг: 10 цаг 00 минут, Цахим серверийн цагаар
Д. Тендерийг нээх, үнэлэх	
ТӨӨЗ 26.1	Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг тендерт оролцогч цахим системээр хүлээн авна. Тендерийн нээлт хийх огноо: 2024 оны 5 дугаар сарын 20-ны өдөр Тендерийн нээлт хийх цаг: 10 цаг 05 минут, Цахим серверийн цагаар



<p>ТӨӨЗ 39.1</p>	<p>Түр зогсоох нөхцөлийг хэрэглэнэ. Түр зогсоох хугацаа нь гэрээ байгуулах эрх олгох илэрхийлэл бүхий мэдэгдэл гарсан өдрөөс хойш ажлын 10 өдөр байна.</p> <p>Захиалагч, шалгарсан тендерг оролцогчид гэрээ байгуулах эрхийг түр зогсоох хугацаа дуусах үед олгох тухай илэрхийллийг тендер ирүүлсэн оролцогч бүрт түр зогсоох хугацаа эхэлсэн даруйд бичгээр мэдэгдэнэ. Уг мэдэгдлийг 9 дүгээр бүлэг (Гэрээний маягт)-т заасан хэлбэрээр бэлтгэх ба дараах мэдээллийг агуулсан байна. Тухайлбал:</p> <p>(а) тендер ирүүлсэн оролцогч бүрийн нэр;</p> <p>(б) тендерийн нээлтэд зарлагдсан тендерийн үнэ;</p> <p>(в) үнэлгээнд хамрагдсан тендерийн нэр болон үнэлэгдсэн үнэ;</p> <p>(г) шалгараагүй тендерг оролцогчийн нэр болон тендерээс тагталзсан үндэслэл;</p> <p>(д) шалгарсан оролцогчийн нэр, санал болгосон үнэ, эрх олгож буй гэрээний хугацаа болон цар хүрээний талаар хураангуй мэдээлэл; мөн</p> <p>(е) шалгараагүй тендерг оролцогчид илгээсэн мэдэгдэлд энэ заалтын (д)-д заасны дагуу түүний тендерээс тагталзсан үндэслэлийг дурдахдаа үнээс бусад мэдээллийг агуулаагүй бол холбогдох үндэслэл бүхий тайлбарыг тусгах зэрэг болно.</p>
<p>Е. Гэрээ байгуулах эрх олгох</p>	
<p>ТӨӨЗ 44.1</p>	<p>Тендер шалгаруулалттай холбоотой гомдлыг зохицуулах горимыг АХБ-ны Зээлдэгчдэд зориулсан Худалдан авах ажиллагааны журам (7 дугаар Хавсралт)-д тусгав. Тендерг оролцогч энэ горимын дагуу гомдлоо дараах хаягт хандан бичгээр гаргана:</p> <p>Хэнд: Т. Жамбалцэрэн</p> <p>Албан тушаал: Төрийн нарийн бичгийн дарга</p> <p>Захиалагч: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам</p> <p>Цахим хаяг: jambaltseren@mofa.gov.mn</p>



3 дугаар бүлэг – Үнэлгээний ба чадварын шалгуур

Агуулга

1. ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР

- 1.1 Техникийн санал шаардлагад нийцэж байгаа эсэх
- 1.2 Олон гэрээ эсвэл багц
- 1.3 Ажил дуусгах хугацаа
- 1.4 Техникийн хувилбарт шийдэл
- 1.5 Тоолж хэмжигдэх жижиг зөрүү, алдаа ба орхигдуулсан зүйлс
- 1.6 КОВИД-19-д хамаарах эрүүл мэнд ба аюулгүй байдлын төлөвлөгөө

2. ЧАДВАРЫН ШАЛГУУР

2.1 Эрх бүхий байдал

- 2.1.1 Улсын харъяалал
- 2.1.2 Ашиг сонирхлын зөрчил
- 2.1.3 АХБ-ны эрх бүхий байдал
- 2.1.4 Төрийн өмчигт хуулийн этгээд
- 2.1.5 Нэгдсэн Үндэстний Байгууллагын эрх бүхий байдал

2.2 Хэрэгжүүлээгүй гэрээний талаарх мэдээлэл

- 2.2.1 Хэрэгжүүлээгүй гэрээний талаарх мэдээлэл
- 2.2.2 Шүүх ба арбитрын маргаан

2.3 Санхүүгийн шаардлага

- 2.3.1 Санхүүгийн үзүүлэлт
- 2.3.2 Барилгын ажлын жилийн дундаж борлуулалт
- 2.3.3 Санхүүгийн нөөц хөрөнгийн шаардлага

2.4 Барилгын ажлын туршлага

- 2.4.1 Төрөл ба хэмжээгээр төстэй гэрээний туршлага
- 2.4.2 Үндсэн үйл ажиллагааны барилгын ажлын туршлага



1. ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР

ТӨӨЗ-ны 34.2 (а)-(д) заалтуудад тусгагдсан шалгуураас гадна дараах шалгуурыг ашиглана:

1.1 Техникийн санал шаардлагад нийцэж байгаа эсэх

Техникийн саналын үнэлэхдээ 6 дугаар бүлэг (Тодорхойлолт ба бусад шаардлага)-ийн шаардлагад бүрэн нийцсэн ажлын аргачлал, хуваарь, материал татан авалтын эх үүсвэрт хамаарах техникийн саналын дагуу тухайн гэрээг хэрэгжүүлэхэд шаардагдах гол тоног төхөөрөмж, ажилтнуудын талаарх тендерт оролцогчийн техникийн чадавхийн үнэлгээг харгалзана.

6 дугаар бүлэг (Тодорхойлолт ба бусад шаардлага)-т тодорхойлсон тоног төхөөрөмж, ажилтнуудад тавигдах шаардлагыг хангаагүй байх нь срөнхийдөө тендерээс татгалзах үндэслэл болохгүй бөгөөд ийнхүү шаардлага хангаагүй зүйлийг гэрээ байгуулах эрх олгохын өмнө тендерийг үнэлж залруулга хийх явцаа тодруулна.

1.2 Олон гэрээ эсвэл багц- Хэрэглэхгүй.

1.3 Ажил дуусгах хугацаа

Ажил дуусгах хувилбарт хугацааг доор дурьдсаны дагуу үнэлнэ:

6 дугаар бүлэг (Тодорхойлолт ба бусад шаардлага)-т заасан ажил эхлэхээс ажил дуусгах хүртэл хугацаа нь 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр байна. Энэ хугацаанаас хойш ажлыг дуусгахгаар санал ирүүлсэн тохиолдолд тохируулгын хэмжээ нь дээрх хугацаанаас хэтэрсэн хоног тутамд тендерийн үнийн 0,05 хувьтай тэнцэнэ. Ажил дуусгах хугацааг дээрх хугацаанаас 45 өдрөөр хэтрүүлсэн саналтай тендерээс татгалзана. Дээрх хугацаанаас өмнө ажил дуусгах саналд давуу эрхийг тооцохгүй.

1.4 Техникийн хувилбарт нийдэл: Хэрэглэхгүй.

1.5 Тоолж хэмжигдэх жижиг зөрүү, алдаа, орхигдуулсан зүйлс

Тоолж хэмжигдэх жижиг зөрүү, алдаа, мөн/эсхүл орхигдуулсан зүйлсийн өртгийг доор дурьдсаны дагуу тооцно:

ТӨӨЗ 31.3-т заасны дагуу тоолж хэмжигдэх жижиг зөрүү эсхүл орхигдуулсан зүйлсийн зардлыг үнэлнэ. Захиалагч нь тендерийг шударгаар харьцуулах нөхцөлийг хангах зорилгоор аливаа жижиг зөрүү ба орхигдуулсан зүйлсийн зардлын талаар өөрийн гэсэн үнэлгээг хийнэ.

Тендерийг тэгш шударгаар харьцуулахын тулд жижиг орхигдуулсан зүйлс эсхүл тусгалгүй үлдээсэн ажлын зардлыг тендерийн үнэ дээр нэмж тооцно. Үнийн тохируулгыг бусад шаардлага хангасан тендерүүдийн ирүүлсэн холбогдох үнийн саналуудыг харгалзан, хэрэгжүүлэгч агентлаг газар, шилжүүлэгч, зөвлөх эсхүл тендер үнэлгээний хорооны хийсэн зардлын бодит тооцоололд үндэслэн хийнэ. Үнийн тохируулахдаа тухайн орхигдуулсан ажлын зах зээлийн бодит үнийг баримтлана. Хамгийн түгээмэл ашиглагддаг арга нь бусад тендерт оролцогчдын тухайн ажил нэр төрлийн ажилд ирүүлсэн хамгийн өндөр үнийн саналтай тэнцэх үнийг хэрэглэх явдал юм.



1.6 КОВИД-19-д хамаарах эрүүл мэнд ба аюулгүй байдлын төлөвлөгөө

Захиалагч, техникийн санал нь шаардлагад нийцэж байгаа эсэхийг үнэлэхдээ техникийн саналд хавсаргасан, КОВИД-19-д хамаарах эрүүл мэнд ба аюулгүй байдлын төлөвлөгөө (“төлөвлөгөө”)-ний шинж чанарыг харгалзан үзнэ.

Тендерт оролцогч нь энэ төлөвлөгөөнд КОВИД-19-өөс урьдчилан сэргийлэх болон түүнд хяналт тавихтай холбоотойгоор ажлын байранд авч хэрэгжүүлэх эрүүл мэнд ба аюулгүй байдлын арга хэмжээг тусгаж харуулах ба уг арга хэмжээнд хувийн хамгааллын хэрэгслийн шаардлага, ажлын талбайг байгуулах, сургалт зохион байгуулах, шинэ ажилтныг ажилд авах ба дайчлах, тоног төхөөрөмж ба байгууламжийг цэвэрлэх ба түүнчлэн талбайн ажлын үйл ажиллагааг явуулах, ажлын талбайд түр ирсэн зочдын эрүүл мэнд ба аюулгүй байдлыг бүртгэх, эрүүл мэнд ба аюулгүй байдлын төлөвлөгөөг хянах, тайлагнах үед аюул эрсдлийн удирдлагын бусад арга хэмжээ оруулна. Энэ төлөвлөгөө нь тухайн гэрээний барилгын ажлын холбогдох зорилгод нийцсэн байхаас гадна КОВИД-19-өөс урьдчилан сэргийлэх болон түүнд хяналт тавих, мөн ажлын байрны аюулгүй байдлын шаардлагын талаарх засгийн газрын холбогдох дүрэм журам, эсвэл ийм журам байхгүй бол олон улсын шилдэг туршлага бүхий журамтай Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага, 2020. КОВИД-19-тэй уялдан ажлын байранд авч хэрэгжүүлэх нийтийн эрүүл мэнд ба нийгмийн арга хэмжээнд анхаарах зүйлс. Женев. <https://www.who.int/publications-detail/considerations-for-public-health-and-social-measures-in-the-workplace-in-the-context-of-covid-19>. Түүнчлэн, КОВИД-19-д хамаарах эрүүл мэнд ба аюулгүй байдал, олон улсын шилдэг туршлагын талаар АХБ-ны Төгтгөртэй хөгжил, уур амьсгалын газраас өгсөн зөвлөмжийг дурдаж болно. уялдсан байх ёстой.



2. ЧАДВАРЫН ШАЛГУУР

2.1 Эрх бүхий байдал

Шалгуур	Хангах шаардлага			Баримт бичиг
	Дангаар оролцогч этгээд	Түншлэл		
Бүх гишүүд хамтдаа		Гишүүн бүр	Нэг гишүүн	

2.1.1 Улсын харьяалал

ТӨӨЗ 4.2-г заасан улсын харьяалалтай байх	шаардлагыг заавал хангах	шаардлагыг заавал хангах	шаардлагыг заавал хангах	үл хамаарах	ЭРХ-1; ЭРХ-2 маягтуудыг хавсралтын хамт ашиглах
---	--------------------------	--------------------------	--------------------------	-------------	---

2.1.2 Ашиг сонирхлын зөрчил

ТӨӨЗ 4.3-г заасны дагуу ашиг сонирхлын зөрчилгүй байх	шаардлагыг заавал хангах	шаардлагыг заавал хангах	шаардлагыг заавал хангах	үл хамаарах	Тендер маягт ирүүлэх
---	--------------------------	--------------------------	--------------------------	-------------	----------------------

2.1.3 АХБ-ны эрх бүхий байдал

ТӨӨЗ 4.4-г заасны дагуу, эрх бүхий бус хэмээн АХБ-наас зарлагдаагүй байх	шаардлагыг заавал хангах	шаардлагыг заавал хангах	шаардлагыг заавал хангах	үл хамаарах	Тендер маягт ирүүлэх
--	--------------------------	--------------------------	--------------------------	-------------	----------------------

2.1.4 Төрийн өмчит хуулийн этгээд

Тендерт оролцогч ТӨӨЗ 4.5-д заасан нөхцөл шаардлагыг хангасан байх	шаардлагыг заавал хангах	шаардлагыг заавал хангах	шаардлагыг заавал хангах	үл хамаарах	ЭРХ-1; ЭРХ-2 маягтуудыг хавсралтын хамт ашиглах
--	--------------------------	--------------------------	--------------------------	-------------	---

2.1.5 НҮБ-ын эрх бүхий байдал

ТӨӨЗ 4.8-д заасны дагуу НҮБ-ын аюулгүй зөвлөлийн шийдвэр эсвэл захиалагчийн улсын хуулийн хүрээнд хасагдаагүй байх	шаардлагыг заавал хангах	шаардлагыг заавал хангах	шаардлагыг заавал хангах	үл хамаарах	Тендер маягт ирүүлэх
--	--------------------------	--------------------------	--------------------------	-------------	----------------------



2.2 Хэрэгжүүлээгүй гэрээний талаарх мэдээлэл

2.2.1 Хэрэгжүүлээгүй гэрээний талаарх мэдээлэл

Шалгуур	Хангах шаардлага			Баримт бичиг ирүүлэх шаардлага	
	Дангаар оролцогч этгээд	Түншлэл			
Шаардлага		Бүх гишүүд хамтдаа	Гишүүн бүр	Нэг гишүүн	Баримт бичиг ирүүлэх шаардлага
2021 оны I дүгээр сарын I-ний өдрөөс хойш гүйцэтгэгчийн буруугаас гэрээний үүргээ биелүүлээгүй ^a тохиолдол гарч байгаагүй болно.	шаардлагыг заавал хангах	шаардлагыг заавал хангах	шаардлагыг заавал хангах ^b	үл хамаарах	ГЭР-I маягт

^a Захиалагчийн тодорхойлоноор, гэрээний үүргээ биелүүлээгүй гэдэгт (i) тухайн гэрээний маргаан шийдвэрлэх механизм дагуу гүйцэтгэгчээс хамааралтайгаар гэрээний үүрэг биелэгдээгүй; болон (ii) гэрээнд маргаан үүссэн бөгөөд гүйцэтгэгч буруутай нь тогтоогдсон бүх гэрээнүүдийг оруулна. Гэрээний үүргээ биелүүлээгүй гэдэгт маргаан шийдвэрлэх механизм дагуу захиалагчийн шийдвэрийг үгүйсгэн цуцалсан гэрээг оруулахгүй.

^b Түншлэлийн гишүүнээр оролцож байгаа тендэрт оролцогчийн гүйцэтгэсэн гэрээнд энэ шаардлагыг мөн авч баримтлана.

2.2.2 Шүүх ба арбитрын маргаан

Шүүх ба арбитрын маргааны шалгуурыг хэрэглэнэ.

Шалгуур	Хангах шаардлага			Баримт бичиг ирүүлэх шаардлага	
	Дангаар оролцогч этгээд	Түншлэл			
Шаардлага		Бүх гишүүд хамтдаа	Гишүүн бүр	Нэг гишүүн	Баримт бичиг ирүүлэх шаардлага
(Хэрэв байгаа бол) тендэрт оролцогчид хамаарах хүлээгдэж буй бүх шүүхийн зарга, арбитрын маргааныг тендэрт оролцогчийн эсрэг эгсэлэн шийдвэрлэгдсэн гэж үзэх бөгөөд нийт дүн нь тендэрт оролцогчийн цэвэр хөрөнгийн 50 хувиас илүүгүй байна. Цэвэр хөрөнгийг нийт актив хөрөнгө ба нийт өр төлбөрийн зөрүүгээр тооцно.	шаардлагыг заавал хангах	үл хамаарах	шаардлагыг заавал хангах	үл хамаарах	1. ГЭР – I маягт 2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт



2.3 Санхүүгийн шаардлага

2.3.1 Санхүүгийн үзүүлэлт (Сүүлийн 3 жил-2021, 2022, 2023)

Шалгуур	Хангах шаардлага			Баримт бичиг	
	Дангаар оролцогч этгээд	Түншлэл			
Шаардлага		Бүх гишүүд хамтдаа	Гишүүн бүр	Нэг гишүүн	Баримт бичиг ирүүлэх шаардлага
Тендерт оролцогчийн одоогийн санхүүгийн чадавхийг харуулах үүднээс сүүлийн 3 жилийн аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан, эсхүл тендерт оролцогчийн харьяа орны хуулиар аудитаар баталгаажуулахыг үл шаардсан бол захиалагчийн зөвшөөрөх бусад хэлбэрийн санхүүгийн тайланг илгээнэ. Тендерт оролцогчийн сүүлийн жилийн цэвэр хөрөнгийн доод хэмжээ нь нийт актив хөрөнгө ба нийт өр төлбөрийн зөрүүгээр тооцогдох ба энэ зөрүү нь хамгийн багадаа ашигтай байвал зохино.	шаардлагыг заавал хангах	үл хамраах	шаардлагыг заавал хангах	үл хамраах	1. САН-1 маягтыг хавсралтуудын хамт 2. Сүүлийн 3 жилийн аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан

2.3.2 Барилгын ажлын жилийн дундаж борлуулалт (Сүүлийн 3 жил-2021, 2022, 2023)

Шалгуур	Хангах шаардлага			Баримт бичиг	
	Дангаар оролцогч этгээд	Түншлэл			
Шаардлага		Бүх гишүүд хамтдаа	Гишүүн бүр	Нэг гишүүн	Баримт бичиг ирүүлэх шаардлага
Сүүлийн 3 жилд хэрэгжиж байгаа эсхүл хэрэгжиж дууссан гэрээт ажлын хүрээнд хийгдсэн нийт баталгаат төлбөрийн дүнгээр тооцож гаргасан барилгын ажлын жилийн дундаж борлуулалтын доод хэмжээ 6,751,380,000 төгрөг	шаардлагыг заавал хангах	шаардлагыг заавал хангах	шаардлагын 25 хувийг заавал хангах	шаардлагын 40 хувийг заавал хангах	САН-2 маягт



2.3.3 Санхүүгийн нөөц хөрөнгийн шаардлага

Шалгуур	Хангах шаардлага				Баримт бичиг прүүлэх шаардлага
	Дангаар оролцогч этгэд	Түншлэл			
Шаардлага		Бүх гишүүд хамтдаа	Гишүүн бүр	Нэг гишүүн	
Ганц оролцогч бол: САН-3 маягтад заасан санхүүгийн нөөц хөрөнгө нь САН-4 маягтад дурдсан, одоо хэрэгжиж буй гэрээний үүргийн дүнг оруулаагүй хэмжээгээр 562,615,000 төгрөг бүхий энэхүү гэрээний нийт шаардлагыг хангах эсхүл давуулан хангах боломжтой эсэхийг тендер оролцогч нотлон харуулах ёстой	шаардлагыг заавал хангах	үл хамаарах	үл хамаарах	үл хамаарах	САН-3 ба САН-4 маягтууд
Түншлэл бол: (1) САН-3 маягтад заасан санхүүгийн нөөц хөрөнгө нь САН-4 маягтад дурдсан одоо хэрэгжиж буй гэрээний үүргийн дүнг оруулаагүй хэмжээгээр уг гэрээний нийт шаардлагын 40 хувийг хангах эсхүл давуулан хангах боломжтой эсэхийг нэг гишүүн нотлон харуулах ёстой МӨН	үл хамаарах	үл хамаарах	үл хамаарах	шаардлагыг заавал хангах	САН-3 ба САН-4 маягтууд
(2) САН-3 маягтад заасан санхүүгийн нөөц хөрөнгө нь САН-4 маягтад дурдсан одоо хэрэгжиж буй гэрээний үүргийн дүнг оруулаагүй хэмжээгээр уг гэрээний нийт шаардлагын 25 хувийг хангах эсхүл давуулан хангах боломжтой эсэхийг гишүүн бүр нотлон харуулах ёстой МӨН	үл хамаарах	үл хамаарах	шаардлагыг заавал хангах	үл хамаарах	САН-3 ба САН-4 маягтууд
(3) САН-3 маягтад заасан санхүүгийн нөөц хөрөнгө нь САН-4 маягтад дурдсан одоо хэрэгжиж буй гэрээний үүргийн дүнг оруулаагүй хэмжээгээр 562,615,000 төгрөг бүхий энэхүү гэрээний нийт шаардлагыг хангах эсхүл давуулан хангах боломжтой эсэхийг түншлэл нотлон харуулах ёстой	үл хамаарах	шаардлагыг заавал хангах	үл хамаарах	үл хамаарах	САН-3 ба САН-4 маягтууд



2.4 Барилгын ажлын туршлага (Сүүлийн 3 жил-2021, 2022, 2023)

2.4.1 Төрөл ба хэмжээгээр төстэй гэрээний туршлага

Шалгуур	Хангах шаардлага			Баримт бичиг	
	Дангаар оролцогч этгээд	Түншлэл			Баримт бичиг ирүүлэх шаардлага
		Бүх гишүүд хамтдаа	Гишүүн бүр	Нэг гишүүн	
<p>Сүүлийн 3 жилд амжилттай эхэл үндсэнд нь гүйцэтгэж дуусгасан, мөн санал болгож буй ажилтай нжил төстэй нэлээс доошгүй гэрээг ажилд оролцсон байх. Ингэхдээ тендерт оролцогчийн тухайн ажилд оролцсон ажлын үнэлгээ нь 5,064,885,000 төгрөгөөс доошгүй байх.</p> <p>Тендерт оролцогчийн гүйцэтгэсэн ажил гэдгийг үерийн хамгаалалтын далан, суваг шуудуу, усан сан, хөв цөөрөм, цэвэр усны болон усан хангамж салбар шугам, өргөх насос станцын барилга байгууламж, усалтын системийн угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил, цугтамал болон угсармал төмөр бетон бүтээц зэрэг усны барилга байгууламжийн барилга угсралт гэж ойлгоно.</p>	шаардлагыг заавал хангах	үл хамраарх	үл хамраарх ^б	шаардлагыг заавал хангах	<p>1. ТУР-1 маягт</p> <p>2. Ажил гүйцэтгэсэн гэрээнуудийн хуулбар, улсын техникийн комиссын хүлээж авсан акт, захиалагчийн гөдөрхөйлөлт хавсаргаж ирүүлнэ;</p>



2.4.2 Үндсэн үйл ажиллагааны барилгын ажлын туршлага

Энэ шалгуурыг туслан гүйцэтгэгчээр хангуулж болно. Захиалагч тендерт оролцогчоос туслан гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг шаардаж авна. Туслан гүйцэтгэгч гэдэг нь үндсэн гүйцэтгэгчийн хийж чадахгүй, нарийн мэргэжлийн үйл ажиллагааг эрхлэн явуулдаг мэргэшсэн аж ахуйн нэгжийг хэлнэ.

Шалгуур	Хангах шаардлага			Баримт бичиг ирүүлэх шаардлага	
	Дангаар оролцогч этгээд	Түншлэл			
Шаардлага		Бүх гишүүд хамтдаа	Гишүүн бүр	Нэг гишүүн	Баримт бичиг ирүүлэх шаардлага
2.4.1-д заасан хугацаанд гүйцэтгэсэн дээрх эсвэл бусад гэрээний тухайд баримтлах үндсэн үйл ажиллагааны барилгын ажлын туршлагын доод хэмжээ:	шаардлагыг заавал хангах	шаардлагыг заавал хангах ^а	үл хамаарах	үл хамаарах	1. ТУР – 1 маягт 2. Ажил гүйцэтгэсэн гэрээнүүдийн хуулбар, улсын/техникийн комиссын хүлээж авсан акт, захиалагчийн тодорхойлолт хавсаргаж ирүүлнэ.
Доод тал нь 1 (нэг) усны барилга байгууламж угсралт, өргөтгөл шинэчлэлийн ажил хийсэн байх					
Доод тал нь 1 (нэг) цутгамал болон угсармал төмөр бетон бүтэцэн барилга угсралтын ажил хийсэн байх					

^а Тендерт оролцогч түншлэлийн хэлбэрээр оролцох тохиолдолд хэрэв тендерт оролцогч өөрөө (түүний туслан гүйцэтгэгч бус) ийм үйл ажиллагааг хийж гүйцэтгэх бол дөр хаяж түншлэлийн нэг гишүүн заавал үндсэн үйл ажиллагааны туршлагатай байх ёстой.



4 дүгээр бүлэг – Тендерийн маягт

Энэ бүлэг нь тендерт оролцогчоос бэлтгэж, тендерийн хамт ирүүлсэн маягтуудаас бүрдэнэ.

Агуулга

Тендер ирүүлэх маягт

Ажлын тоо хэмжээ (Нэгж үнийн гэрээ)

Тохируулга хийх өгөгдлийн хүснэгт

Тендерийн баталгаа

Техникийн санал

Ажилтнууд

АЖИ-1 маягт: Санал болгож буй ажилтнууд

АЖИ-2 маягт: Санал болгож буй ажилтны товч намтар

ТОН маягт: Тоног төхөөрөмж

Ажлын талбайн зохион байгуулалт

Ажлын аргачлал

Бэлтгэл хангах хуваарь

Барилгын ажлын хуваарь

КОВИД-19-д хамаарах эрүүл мэнд ба аюулгүй байдлын менежментийн төлөвлөгөө

Тендерт оролцогчийн чадвар

ЭРХ-1 маягт: Тендерт оролцогчийн мэдээллийн хуудас

ЭРХ-2 маягт: Түншлэлийн мэдээллийн хуудас

ГЭР-1 маягт: Хэрэгжүүлээгүй гэрээний талаарх мэдээлэл

САН-1 маягт: Санхүүгийн үзүүлэлт

САН-2 маягт: Барилгын ажлын жилийн дундаж борлуулалт

САН-3 маягт: Санхүүгийн нөөц хөрөнгийн байдал

САН-4 маягт: Одоо хэрэгжиж буй гэрээний санхүүгийн шаардлага

ТУР-1 маягт: Төрөл ба хэмжээгээр төстэй гэрээ

ТУР-2 маягт: Үндсэн үйл ажиллагааны барилгын ажлын туршлага



Тендер ирүүлэх маягт

Тэмдэглэл

Тендерт оролцогч нь өөрийн бэлнхээг ашиглан тендер ирүүлэх маягтыг бүрэн гүйцээд бөглөж, албан ёсны нэр, хаягийг тодорхой бичигдэж байна.

Огноо:

НӨТШ-ын дугаар:

Тендерийн урилгын дугаар:

Хэнд: [Захиалагчийн бүтэн нэрийг оруулах]

Бид тендер шалгаруулалтад оролцох албан хүсэлт гарган, дараах мэдэгдлийг хүргүүлж байна:

- (а) Бид тендерийн баримт бичиг, болон ТӨӨЗ 9-д заасны дагуу гаргасан тендерийн баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийг бүрэн судалж, аливаа болзолт нөхцөл байхгүй болохоо ойлгосон болно;
- (б) Бид тендерийн баримт бичгийн шаардлагад бүрэн нийцсэн дараах ажлыг гүйцэтгэхээр санал гаргаж байна: [ажлын гэрийг оруулах]
- (в) доорх (г) хэсэгт санал болгосон үнийн хөнгөлөлтийг оруулаагүй тендерийн нийт үнэ нь:

Тендерт оролцогч энэ хүснэгтэд тийм тендерийн үнийг нэхж үнийн гэрээ байгуулах бол ажлын тоо хэмжээгээ оруулна. Энэхүү тендерийн маягтад тендерийн нийт үнийг хаагааргүй тохиолдолд үү тендерээс шалгалгах үндэстэл болж болно.

- (г) Санал болгож буй үнийн хөнгөлөлт, түүнийг хэрэглэх аргачлал: [үнийн хөнгөлөлтийн хувь хэмжээ эсвэл үнийн дүн хэрэг аширлагатай бол хөнгөлөлтийг хэрэглэх аргачлалыг оруулах];
- (д) Манай тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш [ТӨӨХ 19.1-д заасан тендер хүчинтэй байх хугацааг оруулах] хоногийн хугацаанд хүчинтэй байх ба уг хугацааг дуусахаас өмнө тендерт шалгарсан тохиолдолд мөн адил хүчинтэй хэвээр байна.
- (е) Хэрэв манай тендер шалгарсан тохиолдолд бид гүйцэтгэлийн баталгааг тендерийн баримт бичигт заасны дагуу гаргуулан ирүүлнэ;
- (ё) Бид, гэрээний аль нэг хэсгийн туслан гүйцэтгэгч эсхүл нийлүүлэгчийг оролцуулан ТӨӨЗ-ны 4.2-т заасны дагуу эрх бүхий орны иргэншилтэй болно;
- (ж) Бид, гэрээний аль нэг хэсгийн туслан гүйцэтгэгч эсхүл нийлүүлэгчийг оролцуулан ТӨӨЗ-ны 4.3-т заасны дагуу ямарваа нэгэн сонирхлын зөрчилгүй болно.
- (з) Бид энэхүү тендер шалгаруулалтад ТӨӨЗ-ны 14-т заасны дагуу хувилбарт санал ирүүлэхээс бусад тохиолдолд ТӨӨЗ-ны 4.3 (д)-д заасны дагуу лангаараа болон түншлэлийн гишүүнээр нэгээс дээш тендер ирүүлээгүй болно.
- (и) Манай компани, түншлэлийн гишүүд, хоршил, толгой компани, салбар нэгжүүд, түүнчлэн гэрээний аль нэг хэсгийн туслан гүйцэтгэгч эсхүл нийлүүлэгч нь Азийн хөгжлийн банкнаас түр түдгэлзүүлсэн эсвэл хассан эсвэл Азийн хөгжлийн банк ба бусад хөгжлийн банкны² хооронд байгуулсан тендер шалгаруулалтад оролцохыг хориглох шийдвэрийг хамтран хэрэгжүүлэх тухай хэлэлцээрийн дагуу Азийн хөгжлийн банкнаас хассан аливаа байгууллага, хувь хүний харъяалалд эсхүл хяналтанд байдаггүй бөгөөд хамааралгүй болно.
- (й) Захиалагчийн улс, аливаа олон улсын байгууллага ба бусад хандивлагч байгууллага нь манай компани, түншлэлийн гишүүд, хоршил, толгой компани, салбар нэгжүүд, түүнчлэн гэрээний аль нэг хэсгийн туслан гүйцэтгэгч эсхүл нийлүүлэгчийг одоогоор эсхүл өмнө нь хэзээ ч түр хугацаанд эрхийг түтгэлзүүлж, хасч, эрх бүхий бус гэж зарлаж, хар жагсаалтанд оруулж байгаагүй болно.

² Эдгээр байгууллагад Африкийн хөгжлийн банк, Европын сэргээн босголт, хөгжлийн банк, Америк хоорондын хөгжлийн банк болон Дэлхийн банк орно. Хэлэлцээрийн 9 дүгээр зүйлд заасны дагуу бусад олон улсын санхүүгийн байгууллагууд нь энэ хэлэлцээрийн бүх оролцогч байгууллагуудтай зөвшицөн, дүрмийг дагаж мөрдөх захидалд зохих маягт (хэлэлцээрийн Б хавсралт)-ын дагуу гарын үсэг зурсан тохиолдолд нэгдэн орж болно. Тухайн олон улсын санхүүгийн байгууллага нь уг хэлэлцээрийг даган мөрдсөнөөр тухайн хэлэлцээрийн оролцогч гишүүн байгууллага болно. Тендер оролцогч нь энэ тухай мэдээллийг www.adb.org/integrity цахим хуудсаар орж үзэх боломжтой.



Хэрэв ийнхүү түр хугацаанд эрхийг түтгэлзүүлж, хасч, эрх бүхий бус гэж зарлаж, хар жагсаалтанд оруулж байсан бол энэ тухай (түншлэлийн гишүүн бүр, холбоод, толгой компани, салбар нэгжүүд, туслан гүйцэтгэгч ба/эсвэл нийлүүлэгчийг оролцуулан) дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү:

- (i) Байгууллагын нэр: _____
- (ii) Тендерт оролцох эрхээ хасуулсан, эрх бүхий бус гэж зарлагдсан, эсхүл хар жагсаалтанд орсон хугацаа [эдгэх болон дуусах өдрийг оруулах]: _____
- (iii) Тендерт оролцох эрхээ хасуулсан, эрх бүхий бус гэж зарлагдсан, эсхүл хар жагсаалтанд орсон үндэслэл: _____

(к) Манай компани, түншлэлийн гишүүд, хоршил, толгой компани, салбар нэгжүүд, туслан гүйцэтгэгч эсхүл нийлүүлэгчийн үндсэн ажилтнууд ба захирлууд нь аливаа эрүүгийн гэмт хэрэг (хүнд болон хөнгөн) эсвэл хорих ял шийтгэл эдгэх дүрэм шийдвэрийг биелүүлээгүй/зөрчсөний улмаас [ял эдэлж эсхүл шийтгүүлж] байгаагүй болно.

Хэрэв ийнхүү ял эдэлж, шийтгүүлж байсан бол дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү:

- (i) Гэмт хэрэг/зөрчлийн агуулга: _____
- (ii) Шүүхийн харьяалал: _____
- (iii) Шийдвэр [тэмцэж, гэм буруусгүйн улмаас чөлөөлөгдсөн; шийтгэгдсэн; ял эдэлсэн/ ял шийтгэлийн хугацаа]: _____
- (iv) Бусад холбогдох дэлгэрэнгүй мэдээлэл [хаж асно үү]: _____

(л) Хэрэв манай компани, түншлэлийн гишүүд, хоршил, толгой компани, салбар нэгжүүд, туслан гүйцэтгэгч эсхүл нийлүүлэгч нь АХБ, бусад олон талт хөгжлийн банк, захиалагчийн улс, олон улсын байгууллага болон бусад хандивлагч байгууллагатай хамтран ажиллах эрхийг түр хугацаанд түтгэлзүүлсэн, зогсоосон, хориглосон эсхүл эрх бүхий бус болсон, мөн манай аль нэг үндсэн ажилтан болон захирал нь аливаа эрүүгийн гэмт хэрэг эсвэл хорих ял шийтгэл эдгэх дүрэм шийдвэрийг биелүүлээгүй/зөрчсөний улмаас [ял эдэлж эсхүл шийтгүүлж] байсан бол энэ тухай АХБ-д мэдэгдэх үүрэгтэй болохыг бид ойлгож байна.

(м) Манай компани, түншлэлийн гишүүд, хоршил, толгой компани, салбар нэгжүүд, туслан гүйцэтгэгч эсхүл нийлүүлэгч нь Нэгдсэн Үндэсний Байгууллагын Дүрмийн 7 дугаар бүлгийн хүрээнд Нэгдсэн Үндэсний Байгууллагын Аюулгүйн зөвлөлөөс гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд захиалагчийн улс руу бараа экспортлох эсхүл захиалагчийн улсаас аливаа төлбөр хүлээн авахыг хориглосон аль нэг улсын харьяалалгүй болно.

(н) [Бид төрийн өмчит хуулийн этгээд биш болно] / [Бид ТООЗ-ны 4.5-д заасан шаардлагыг хангасан төрийн өмчит хуулийн этгээд мөн].³

(о) Бид тендер шалгаруулалт эсхүл гэрээ⁴ хэрэгжүүлэхтэй холбогдуулан дор дурдсан шимтгэл, урамшуулалт эсвэл шимтгэлийг төлсөн, эсхүл төлнө:

Хүлээн авагч	Хаяг	Шалтгаан	Хэмжээ
.....
.....

(ө) Албан ёсны гэрээг байгуулах ба хэрэгжүүлэх хүртэл энэхүү тендер, таны бичгээр ирүүлсэн зөвшөөрөл, мөн гэрээний эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн гэрээ болохыг бид ойлгож байна.

(п) Та хамгийн сайн гэж үнэлэгдсэн тендер эсхүл хүлээн авах аливаа бусад тендерийг зөвшөөрөх ёсгүй болохыг бид ойлгож байна.

(р) Манай данс, бүртгэл, тендерийн санааг үрүүлэхтэй холбоотой баримт бичгийг хянан шалгах, АХБ-наас томилсон аудитын байгууллагаар тэдгээрийг хянуулах талаар АХБ эсвэл түүний төлөөлөгчдөд зөвшөөрөхийг бид ойлгож байна.

(с) Хэрэв манай тендер шалгарсан тохиолдолд бид үндсэн тоног төхөөрөмж ба ажилтнуудыг 6 дугаар бүлэг (Тодорхойлолт ба бусад шаардлага) болон өөрийн техникийн саналд заасны дагуу эсхүл захиалагчтай өөрөөр тохиролцсоны ёсоор бэлтгэн ажиллуулахаа амлаж байна.

(т) Санаатайгаар эсхүл санамсаргүйгээр төөрөгдүүлэх эсхүл төөрөгдүүлэхийг оролдох аливаа худал мэдүүлэг нь тендерээ шууд татгалзах, эсхүл гэрээ байгуулах эрх олгогдсон бол гэрээг цуцлах үндэслэл болох ба АХБ-ны Авилгатай тэмцэх бодлого (1998, цаашид нэмж өөрчлөх) болон Шударга

³ Хоёр сонголтөөс аль тохирохыг хэрэглэнэ.

⁴ Хэрэв ямар ч төлбөр хийгдээгүй эсвэл хийгдэхгүй бол "үгүй" гэж заах.



байдлын зарчмууд ба журам (2015, цаашид нэмж өөрчлөх)-ын дагуу зөрчлийг арилгах арга хэмжээг авч болохыг бид ойлгож байна.

Нэр: *[Тендерт гарын үсэг зурах хүний бүтэн нэрийг оруулах]*

Тендерт гарын үсэг зурах хууль ёсны эрх бүхий хүний албан тушаал: *[албан тушаалыг оруулах]*
.....

Гарын үсэг *[нэр ба албан тушаалыг нь дээр дурдсан хүний гарын үсэг]*

Тендерт дараах этгээдийг төлөөлөн гарын үсэг зурж байна: *[Тендерт оролцогчийн бүтэн нэр]*

Огноо: *[Тендерт гарын үсэг зурсан өгнөөг оруулах]*

АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ

[Нэгж үнийн гэрээ]

Ажлын тоо хэмжээг бэлтгэх заавар

Зорилго

Ажлын тоо хэмжээ нь дараах зорилгыг агуулна.

(а) Саналыг үр ашигтай, үнэн зөв бэлтгэх бололцоог бүрдүүлэх зорилгоор гүйцэтгэх ажлын тоо хэмжээний талаар хангалттай мэдээлэл өгөх;

(б) Гэрээ байгуулсан бэл гүйцэтгэх ажлын үе шатны үнэлгээнд ашиглахын тулд ажлын тоо хэмжээний дэлгэрэнгүй үнийг заах.

Дээрх зорилгод хүрэхийн тулд ажлын тоо хэмжээнд ажлыг нэр төрлөөр ангилан, нарийн дэлгэрэнгүй гаргах шаардлагатай ба ингэснээр өөр өөр ангиллын ажлыг хооронд нь, эсвэл ижил төрлийн боловч өөр өөр байршилд эсвэл зардлыг ялгаатай байдлаар үүсгэж болзошгүй бусад нөхцөлд хийгдэх ажлыг өөр хооронд нь ялгах боломжийг бүрдүүлнэ. Эдгээр шаардлагын улмаас ажлын тоо хэмжээг бүтэц, агуулгын хувьд аль болох энгийн бөгөөд товч байлгах нь зүйтэй.

Агуулга

Ажлын тоо хэмжээ нь дараах үндсэн бүлэгт хуваагдана. Үүнд:

(а) Оршил

(б) Ажлын нэр төрөл (хэсгүүдэд ангилагдсан),

(в) Өдөр-ажлын хувиарь

(г) Дүгнэлт

Оршил

Оршил хэсэгт нэгж үнийн задаргааг харуулах ба ажлын тоо хэмжээг бэлтгэх явцад сонгосон болон аль нэг хэсгийн ажлыг хэмжихэд хэрэглэх хэмжилтийн аргачлалыг заасан байх шаардлагатай.

Хад

Ажилд газар улах, өрөмдөх, эсвэл жолоодох ажлууд бэлтгэн тохиолдолд хэрэв техникийн тодорхойлолтод тусгайлан заагаагүй бол оршил хэсэгт хадны тухай дэлгэрэнгүй тодорхойлолтыг (сэрээний хэрэгжилтийн үед үргэлж маргаантай эсдэн байдаг) нарийн заах шаардлагатай ба уг тодорхойлолтыг ажлыг хэмжих болон төлбөр хийхэд ашиглана.

Ажлын нэр төрөл

Ажлын тоо хэмжээнд нэр төрлийг ажлын шинж чанар, байршил, хүртээмж, цагийн хувиарь зэргээс гадна барилга угсралтын арга барил, ажлын үе шат эсвэл зардлын хувьд ялгаатай байдал үүсгэж болох бусад онцлог шинжээр ялган бүлгүүдэд хуваах шаардлагатай. Ажлын бүх хэсэгт нийтлэг байх ерөнхий нэр төрлийг ажлын тоо хэмжээнд тусдаа бүлэг болгож болно. Хэрэв үнийн тахируулгын тольбоннуудыг хэрэглэж байгаа бол тэдгээрийг ажлын тоо хэмжээнд зохих бүлэгт заасан байна.

Тоо хэмжээ

Гэрээнд өөрөөр заагаагүй бол тоо хэмжээ нь зураг төслөөс салсан тооцох ба нэмэлт, хасаат, эсхүл хорьголд хөнгөлөлт алдахгүй. Тоо хэмжээг аль тахирамжтойгоор дээш нь эсвэл доош нь бүхэлдэх ба бодит бус нарийвчлалаас зайлсхийх хэрэгтэй.

Хэмжих нэгж

Захиалагчийн орны үндэсний бусад нэгж тусгайлан зааснаас бусад тохиолдолд дараах хэмжих нэгж болон товчлолыг ашиглана.

Нэгж	Товчлол	Нэгж	Товчлол
куб метр	м ³	метр тонн (1,000 кг)	тонн
гектар	га	миллиметр	мм
цаг	цаг	сар	сар
килограмм	кг	дугаар	дугаар
киловатт	киловатт	квадрат метр	м ²
нийт үнэ	нийт үнэ	квадрат миллиметр	мм ²
метр	м	долоо хоног	7хоног

Газрын гадаргуу ба газар ухах

Ажил эхлүүлэх гадаргуу нь анхны гадаргуугаас өөр тохиолдолд газар ухах, өрөмдөх, жолоодлогын ажил шаардагдах нэр төрөл бүрийн агуулга хэсэгт ажил эхлүүлэх гадаргууг тодорхойлж заана. Ухсан гадаргуу нь эцсийн гадаргуугаас ялгаатай тохиолдолд ухахт шаардагдах нэр төрөл бүрийн агуулга хэсэгт ухсан гадаргууг нарийн тодорхойлно. Ажлын гүйцэтгэлийн хэмжээг ажил эхлүүлэх гадаргуугаас ухсан гадаргуу хүртэл хэмжинэ.

Өдөр-ажлын хуваарь

Ажлын тоо хэмжээнд заагдсан нэр төрлөөс гадуур, бөгөөд урьдчилан төлөвлөнгүй ажил гарах магадлал харьцангуй өндөр тохиолдолд өдөр-ажлын хуваарийг хөтлөнө. Захиалагчийн зүгээс тендерт оролцогчийн тооцсон нээж үнийн бодит байдлыг шалгах үүднээс өдөр-ажлын хуваарь нь:

(а) Тендерт оролцогчийн зүгээс өдөр-ажлын суурь нээж үнийг, өдөр-ажлыг үндэслэн гүйцэтгэсэн ажлын төлбөрийг төлөх нөхцөлийн талаарх мэдэгдлийн хамт тооцож оруулсан явз бүрийн ангиллын ижиллэх хүч, материал, гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжийн жагсаалт болон;

(б) Гүйцэтгэгчийн ашиг, шууд бус зардал, хянах болон бусад зардал бүхий ажиглах хүч, материал, байгуулалтад шаардлагатай өдөр-ажлын суурь үнийн нийлбэр дүн бүрт тендерт оролцогчоос тооцож гаргасан хувь хэмжээг багтаана.

Нөхцөлт тоо хэмжээ ба зардал

Ажлын тоо хэтрэх өндөр хүтээлт бүхий аливаа ажлын төрөл эсхүл ангиллын магадлагшгүй ажлын тоог ажлын тоо хэмжээнд тусгахдаа "нөхцөлт тоо хэмжээ" эсвэл "нөхцөлт нэр төрөл" гэж онцлон тодруулах ба тухайн ажлын төрөл эсхүл ангиллын хэмжээг ажил хэвийн гүйцэтгэх үеийн тоо хэмжээнээс хэтрүүлэхгүй байна. Түүнчлэн, магадлагшгүй ажлын (ажлын тоо хэтрэх) биет хэмжээг ажлын тоо хэмжээний нэгтгэлд "нөхцөлт зардал" гэсэн нэрээр багтааж тусгана. Үүнтэй адилаар, үнийн болзошгүй осолтод зориулсан магадлагшгүй ажлын нөхөн олговрыг ажлын тоо хэмжээний нэгтгэлд "нөхцөлт зардал" гэсэн байдлаар тусгана. Эдгээр нөхцөлт зардлыг багтаан тусгаж нэгдсэн байдлаар батлуулснаар хоёрим хэрэгцээ шаардлага гарч болох тохиолдол бүрд нэмэлт зөвшөөрөл хүсэх шаардлагагүй болно.

Санал болгож буй туслан гүйцэтгэгчийн гүйцэтгэх тусгай ажлын, эсвэл нийлүүлэх тусгай барааны төсөвт өртгийг ажлын тоо хэмжээний холбогдох хэсэгт товч тайлбарын хамт нөхцөлт зардал хэмээн тусгана. Захиалагч нь хоёрим үндсэн эсхүл ерөнхий гүйцэтгэгчийн туслан гүйцэтгэгчээр ажиглах мэргэжилтнийг тусад нь шалгаруулж авна. Ерөнхий гүйцэтгэгчийн хувьд шалгарсан тендерт оролцогчоос мэргэжилтэн эсхүл туслан гүйцэтгэгчийн шаардлагад нийцүүлэх зорилгоор гаргах материаллаг бааз, тав тух, оролцоо зэргийн тухайд үндсэн тендерт оролцогдын дунд өрсөлдөөнийг хангахын тулд үүнтэй хамааралтай нөхцөлт зардлыг бодит зарцуулалтаар нь нөхцөлт зардлаас төлөх хувь хэмжээг харгалзан, ажлын тоо хэмжээнд тусгасан ажлын нэр төрөлтэй уялдуулна.

Нэгтгэл

Нэгтгэл хэсэг нь өдөр-ажил, биет (тоо хэмжээний) магадлагшгүй ажил болон үнийн болзошгүй осолттой холбоотой нөхцөлт зардал гэх мэт хайсэн ажлын тоо хэмжээний бие даасан хэсгүүдийг нэгтгэсэн хүснэгтийг агуулна.



Ажлын тоо хэмжээ (загвар жишээ)

А. Оршил

1. Ажлын тоо хэмжээг тендерт оролцогчдоод өгөх зааварчилгаа, гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, техникийн тодорхойлолт ба зураг төсөлгэй холбож ойлгоно.
2. Ажлын тоо хэмжээнд өгөгдсөн тоо хэмжээ нь ойролцоогоор тооцож урьдчилан гаргасан тоо хэмжээ байх бөгөөд сонгон шалгаруулалтын ерөнхий суурь тооцоо нь болж өгнө. Төлбөр нь захиалсан болон гүйцэтгэсэн ажлын бодит тоо хэмжээг гүйцэтгэгч хэмжиж төслийн менежерээр хянуулан батлуулсан тоо хэмжээнд үндэслэн, ажлын тоо хэмжээний дэлгэрэнгүй үнэд тусгагдсан тендерийн саналын нэгж үнэ ба өртөгөөр тооцож хийгдэнэ. Шаардлагатай тохиолдолд гэрээний заалтын дагуу төслийн менежер тухайн үнэ хөлсийг тодорхойлж болно.
3. Гэрээнд өөрөөр заагаагүй бол ажлын тоо хэмжээний дэлгэрэнгүй үнэд тусгагдсан тендерийн саналын нэгж үнэ, өртөг нь барилга угсралтын тоног төхөөрөмж, ажиллах хүч, хяналт, материал, засвар үйлчилгээ, даатгал, ашиг, татвар болон хураамж, гэрээнд тусгасан үндсэн эрсдэл, үүрэг ба хариуцлагыг хамрана.
4. Ажлын тоо хэмжээг тодорхой заасан эсэхээс үл хамааран, ажлын тоо хэмжээний дэлгэрэнгүй үнэд тусгагдсан нэр төрөл бүрт нэгж үнэ өргийг бөглөсөн байна. Гүйцэтгэгчийн бөглөөгүй орхисон нэгж үнэ, өртгийг ажлын тоо хэмжээний бусад нэгж үнэ ба өртөгт шингээсэн гэж үзнэ. Ажлын тоо хэмжээнд тусгасан тоо ширхэг, нэгж үнийг шивж оруулсан байх ба гараар бичих бол дармал үсгээр бичнэ. Уг шаардлагаас өөр хэлбэрээр ирсэн ажлын тоо хэмжээг шаардлага хангаагүй гэж үзэн татгалзаж болно.
5. Гэрээнд заасан нийт зардал нь ажлын тоо хэмжээнд дурдсан ажлын нэр төрлүүдэд багтсан байх ба ямарваа тусгагдаагүй үлдсэн ажлын нэр төрлийн зардлыг бусад холбогдох нэр төрлийн ажлын нэгж үнэ өртөгт шингээсэн гэж үзнэ.
6. Ажил ба материалын ерөнхий зааварчилгаа болон тайлбарыг ажлын тоо хэмжээнд давтан бичих, нэгтгэх шаардлагагүй. Ажлын тоо хэмжээний дэлгэрэнгүй үнийн ажил тус бүрийн нэр төрөлд үнийн мэдээлэл оруулахаас өмнө гэрээний баримт бичгийн холбогдох хэсгүүдийн тайлбар хийгдсэн байх шаардлагатай.
7. Ажлын тоо хэмжээнд тусгагдсан нөхцөл зардал нь гэрээний нөхцөлийн дагуу төслийн менежерийн чиглэл, сонголтын хүрээнд бүтнээр эсвэл хагаслан зарцуулагдана.
8. Төлбөр хийх зорилгоор гүйцэтгэж дууссан ажлыг хэмжих аргачлал нь *[стандарт арга зүйн зааварчилгааны нэрийг эсвэл хэрэглэх аргачлалын дэлгэрэнгүй тайлбарыг оруулж бичих. Ажлын тоо хэмжээг хэмжих аргачлалыг ажлын тоо хэмжээний оршил хэсэгт маш тодорхой тусгаж, газар ухаа ажлын модон бэхэлгээ хийх зардлыг тусгах гэх мэт жишээ тайлбарыг оруулна. Энэ талаар үндэсний маш олон стандартууд байдаг ба ийм заавруудын нэг нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын Барилгын инженерүүдийн институтээс гаргасан хэмжит хийх тухай инженерчлэлийн стандарт аргачлал болно.]*
9. Захиалагч арифметик алдааг дараах байдлаар залруулна. Тухайлбал:
 - (а) нэгж үнэ ба нийт үнэ (нэгж үнийг тоо хэмжээгээр үржүүлж гаргасан)-ийн хооронд зөрүүтэй бол нэгж үнийг баримтлан, нийт үнэд залруулга хийх ба хэрэв захиалагчийн дүгнэснээр нэгж үнэд аравтын орны таслалыг буруу байрлуулсан болох нь илэрхий байвал нэгж үнийг засварлан нийт үнийг хэвээр үлдээнэ.
 - (б) нийт үнэ ба үе шатны ажлын үнийн нийлбэрийн хооронд зөрүүтэй бол үе шатны ажлын үнийн нийлбэрийг баримтлан нийт үнэд залруулга хийнэ.
 - (в) ажлын тоо хэмжээний нэгтгэлд заасан тендерийн үнэ нь тендер ирүүлэх маягтын (в)-д заасан тендерийн үнээс зөрүүтэй байвал ажлын тоо хэмжээний нэгтгэлд заасан тендерийн үнийг баримтлан, тендерийн маягтын (в)-д дурдсан үнийг залруулна.
 - (г) үг ба тоон илэрхийллийн хооронд зөрүүтэй бол үгээр илэрхийлэгдсэнийг баримтлан, тоон илэрхийлэлд залруулга хийх ба хэрэв үгээр илэрхийлэгдсэн дүн арифметик алдаатай тохиолдолд тоогоор илэрхийлэгдсэн дүнг дээрх (а), (б) болон (в)-д дурдсан аргачлалыг үндэслэн баримтлана.
10. Хад гэдэгт төслийн менежерийн үзсэнээр тэсэлгээ хийх, эсвэл төмөр шаантаг ба лантуу ашиглах, эсвэл даралтад өрмөөр зайлуулан шилжүүлэх шаардлагатай, түүнчлэн дор хаяж 150 морины хүчин чадал бүхий хойноо хөтлөгчтэй, хүнд даацын трактор дангаараа тасдаж авах боломжгүй бүх материалыг хамруулна.



В. Ажлын нэр төрөл

1. Ажлын тоо хэмжээ нь ихэнх тохиолдолд ажлын шинж чанар ба цаг хугацаанаас хамаарч ангилагдсан дараах хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- 1 дүгээр тооцоо – Үндсэн ажил
 - 2 дугаар тооцоо – Газар шорооны ажил
 - 3 дугаар тооцоо – Дамжуулах хоолой ба гүүр
- Ажлын тоо хэмжээний нэгтгэл

2. Тендерт оролцогч нь ажлын тоо хэмжээнд үнийг зөвхөн төгрөгөөр тооцно.

1 дүгээр тооцоо: Үндсэн ажил

Нэр төрлийн дугаар	Агуулга	Нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Дүн
113	Төслийн менежерийн ажлын байр	сар	24		
122	Түүр замын хөдөлгөөний зохицуулалт, засвар үйлчилгээ	сар	24		
132	Ажил дуусахад ажлын талбайг цэвэрлэх	нийт үнэ	1		
141	Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх	нийт үнэ	1		
1 дүгээр тооцооны дүн					
Нэгтгэл хүснэгтэд бичих дүн					

2 дугаар тооцоо: Газар шорооны ажил

Нэр төрлийн дугаар	Агуулга	Нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Дүн
201	Хөрснийг дээд тал нь 25 см гүн ухах, дахин ашиглах зорилгоор цгад тал нь 1 км ашиглагдсан газарт зооворлох	м ³	15,000		
202	Хөрснийг дээд тал нь 25-50 см гүн ухах	м ³	258,000		
206	Ухсан нүх эсвэл зөвшөөрсөн цооног нүхнээс шороог ухаж гаргах, 1 км хүртэл зөөвөрлөх, хадгалах, хэлбэржүүлэх, ба дүүргэхийн тулд нягтруулах	м ³	80,000		
2 дугаар тооцооны дүн					
Нэгтгэл хүснэгтэд бичих дүн					



3 дугаар тооцоо: Дамжуулах хоолой ба гүүр

Нэр төрлийн дугаар	Агуулга	Нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Дүн
301	Халнаас бусад бүх газрыг суурь давхараас фундаментын гадна тал хүртэл 5 м гүн ухах ба цэвэрлэх	м ²	35,000		
311	Дашын баганын Б ангиллын бетон цутгах	м ³	20,000		
318	20 мм диаметртэй зөөлөн ган арматур бэхлэх	тонн	370		
3 дугаар тооцооны дүн					
Нэгтгэл хүснэгтэд бичих дүн					

Нөхцөлт зардал

Тооцооны дугаар	Нэр төрөл	Агуулга	Дүн
			1,250,000
2	2.8	Шахуургын тоног төхөөрөмж нийлүүлэх ба угсрах	3,500,000
3	3.32	Агааржуулалтын систем нэвтрүүлэх	4,750,000
Нийт нөхцөлт зардал			4,750,000
Нэгтгэл хүснэгтэд бичих дүн			

Ажлын тоо хэмжээний нэгтгэл хүснэгт

Агуулга	Хуудас	Дүн
1 дүгээр тооцоо: Үндсэн ажил		
2 дугаар тооцоо: Газар шорооны ажил		
3 дугаар тооцоо: Дамжуулах хоолой ба гүүр		
Ажлын тоо хэмжээний дүн	(А)	
Нөхцөлт зардал	(Б)	4,750,000
Нөхцөлт зардлыг оруулсан ажлын тоо хэмжээний дүн (А+Б)	(В)	
Магадвалгүй ажлын нөхцөлт зардал	(Г)	
Тендер ирүүлэх мангдал бичигдэх тендерийн үнэ (В+Г)	(Д)	



АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭНИЙ НЭГТГЭЛ ХҮСНЭГТ

№	Ажлын нэр	Дүн
1	АЖИЛ №1 Бэлтгэл ажил	-
2	АЖИЛ №2 Талбайн цэвэрлэгээ	-
3	АЖИЛ №3 Гидротехникийн барилгын ажил	-
4	АЖИЛ №4 Шугам сүлжээний угсралт, ойн зурвасын усалгааны шугам сүлжээний ажил	-
5	АЖИЛ №5 Бороожуулагч машин угсралт суурилуулалтын ажил	-
70. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, Техникийн аюулгүй ажиллагааны дүрэм, Барилгын материалын үйлдвэрийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны үлгэрчилсэн дүрэм, Ажлын байрны зааварчилгаа өгөх аргачилсан зөвлөмж, Барилгын ажлын явцад цахилгааны өндөр хүчдэлийн дүрмийг 6-р бүлгийн Техникийн үзүүлэлт хэсгийн 1.4 дахь заалтанд оруулсан болно.



Бусад шаардлагууд

71. Гүйцэтгэгч нь ажлын зураг, зураг өөрчилсөн зураг, инженер геологийн дүгнэлт, техникийн тодорхойлолт ба шаардлага, ажлын график, талбайн журнал, барилга угсралтын ажлын БНБД, ХАБЭА-н журам гэх мэт Захиалагч/ Төслийн удирдах нэгжээс ирүүлсэн бичиг баримтыг барилгын талбай дээрх байрандаа эмх цэгцтэй хадгалж бэлэн байлгана.
72. Гүйцэтгэгч нь үе шатны ажил бүрт хэмжилт хийж фото зургаар баталгаажуулан, захиалагч, зохиогчийн хяналтыг хийлгүүлж, ил далд ажлын акт үйлдэн баталгаажуулсан байна. Гүйцэтгэгч нь импортын материал худалдан авсан тохиолдолд сертификат, паспорт, лабораторийн шинжилгээний дүнг хавсаргана. Үндэсний үйлдвэрийн материал сонгон авбал сертификат, лабораторийн шинжилгээний дүнг хавсаргана. Мөн орон нутгаас хэрэглэх элс, хайрганы шинжилгээний дүн, бетон цутгалтын ажлаас авсан сорилын шоог зохих журмын дагуу авч лабораторийн дүгнэлт гаргуулж засварын ажлын бичиг баримтад хавсаргасан байна.
73. Усралтын системийн тоног төхөөрөмжийн худалдан авалт, угсралтын суурилуулалт, тохируулга, усжуулалтын системийн туршилт, үзлэг хийж гэрээгээр хүлээсэн хугацаанд ашиглалтанд оруулж улсын комисст хүлээлгэн өгнө.
74. Усралтын системийг ашиглалтанд орсны дараа чанарын баталгаат хугацаанд (1 жил) усралтын системийг шинэчлэн сайжруулах, засвар үйлчилгээ хийж эвдрэл гэмтлийг арилгах ажлыг дараагийн 2 жилд гүйцэтгэгч хариуцан хийж гүйцэтгэнэ.



4. АЖИЛТНУУДЫН ШААРДЛАГА

75. Энэхүү услалтын системийн барилга угсралт, тоног төхөөрөмж нийлүүлэлт суурилуулалтын ажил нь олон төрлийн ажиллагаа хамарсан гэрээт ажил бөгөөд 2027 оны I-р улиралд дуусгахаар төлөвлөж байгаа учраас ажлын цар хүрээ, дуусах хугацаатай уялдуулан дараах мэргэжилтнүүдийг ажиллуулах шаардлагатай.
76. Гүйцэтгэгч нь эмэгтэйчүүдэд ээлтэй ажлын байр бүрдүүлэхэд мөн Жендерийн үйл ажиллагааны болон Нийгмийн хөгжлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд ТХН-д туслалцаа үзүүлнэ (i) гэрээт ажилчидын байрших түр байр нь эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан тохь тухтай орчин нөхцлөөр хангах; (ii) ажилчдын эрүүл мэндийн асуудалд анхаарал хандуулан түр байрших кэмп дээр эмнэлгийн байрыг байгуулан, осол аваар болон анхан шатны тусламж үзүүлэх эм, эмнэлгийн хэрэгцээг хангах.
77. ИТА-нуудын хамгийн багадаа 50% тендерт оролцогч компанийн үндсэн ажилтан байх бөгөөд тус ажилтнууд нь Нийгмийн даатгалын лавлагаагаа ирүүлнэ. Үндсэн ажилтан биш бол хамтран ажиллах гэрээг тус тус байгуулан ирүүлнэ.
78. Тендерт оролцогч 4 дүгээр бүлэг (Тендер шалгаруулалтын маягт)-ийн АЖИ-1, АЖИ-2 маягтыг ашиглан, дараах шаардлагыг хангаж чадах ажилтнуудтай байгааг нотлон харуулна:

№	Ажлын байрны нэр	Тоо	Нийт ажлын туршлага, жилээр	Ижил төстэй ажлын туршлага, жилээр
1	Төслийн ерөнхий инженер (дор хаяж усны барилгын мэргэшсэн эсхүл зөвлөх инженерийн зэрэгтэй байх)	1	10≤	5≤
2	Барилгын инженер	1	5≤	3≤
3	Усны барилга байгууламжийн инженер	2	5≤	3≤
4	Механик инженер	1	5≤	3≤
5	Геодезийн инженер	1	5≤	3≤
6	Ус хангамж ариутгах татуургын инженер	1	5≤	3≤
7	Тоног төхөөрөмжийн инженер	1	5≤	3≤
8	Гидромеханик инженер	1	5≤	3≤
9	Автоматикийн инженер	1	5≤	3≤
10	Эрүүл мэнд, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны инженер	2	5≤	3≤
11	Барилгын техникч	1	3≤	1≤
12	Байгаль орчны мэргэжилтэн	1	5≤	3≤
13	Төслийн админ-бичиг хэрэг	1	2≤	2≤
14	Цахилгааны инженер	1	5≤	3≤
15	Цахилгааны техникч	1	3≤	1≤
16	Бетон арматурчин	1	5≤	3≤
	Нийт	18		

Тэмдэглэл: Усны барилга угсралтын инженер нь усны барилга байгууламж, засвар үйлчилгээний чиглэлээр мэргэшсэн зэрэгтэй байх.



5. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ШААРДЛАГА

79. Тоног төхөөрөмжийн хамгийн багадаа 50% тендерт оролцогч компанийн үндсэн тоног төхөөрөмж байх бөгөөд тус тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн гэрчилгээг ирүүлнэ. Өөрийн эзэмшлийн тээврийн хэрэгсэл биш бол түрээсийн гэрээг тус тус байгуулан ирүүлнэ.
80. Тендерт оролцогч 4 дүгээр бүлэг (Тендер шалгаруулалтын маягт)-ийн ТОН маягыг ашиглан, дор дурдсан үндсэн тоног төхөөрөмжийг жагсааж бичнэ:

№.	Тоног төхөөрөмжийн төрөл ба үзүүлэлтүүд	Шаардагдах тоо
1	Экскаватор 0.8 м3	2≤
2	Ачигч, 3 м3 /Ковш	2≤
3	Кран, 5 тонн буюу түүнээс дээш	2≤
4	Ачааны машин 15 тн	2≤
5	Өөрөө буулгагч ачааны машин,	2≤
6	Юүлэх насос, хүчин чадал Q=11.9 л/с	1≤
7	Юүлэх насос, хүчин чадал Q=25.0 л/с	1≤
8	Гар нягтруулагч	3≤
9	Шугам хоолой суурилуулах багаж хэрэгслүүд	2≤
10	Бетон зуурагч (0,33 м ³) буюу түүнээс дээш	2≤
11	Генератор, 5-10 кВ	2≤
12	Цахилгаан гагнуурын аппарат, иж бүрдэл	1≤
13	HDPE хоолой гагнах аппарат	2-3≤
14	Хийн цохилтот алх, гагнуур	1≤
15	Хийн компрессор	1-2≤
16	Усны машин	1≤
17	Электрон теодолит, нивилер,	1≤
18	Хэмжилтийн ган лентүүд	1≤
19	Бетоны бат бэхийг шалгах гар багаж	1≤
20	Авто грейдер	1≤
21	Хүнд жингийн доргиурт индүү	1≤
22	Бага оврын доргиурт нягтруулагч	1≤
23	Арматур таслагч, хом матагч, арматур матагч гэх мэт иж бүрдэл	1 (тус бүр) ≤
24	Барилгын ба газар шорооны ажлын гар багаж, хэрэгслүүд	Хүрэлцээтэй тоогор

Тэмдэглэгээ: Тоног төхөөрөмжид тавигдаж байгаа энэхүү ерөнхий шаардлагыг техникийн тодорхойлолтод тусгасан, эдгээр шаардлагууд нь хамгийн бага шаардлага бөгөөд гүйцэтгэгчийн барилга усралтад ашиглагдах тоног төхөөрөмжүүд үүгээр хязгаарлагдахгүй болно.



7 дугаар бүлэг – Гэрээний ерөнхий НӨХЦӨЛ

Гэрээний ерөнхий нөхцөлийн заавар

Гэрээний ерөнхий нөхцөл (ГЕН) нь Гэрээний тусгай нөхцөл (ГТН) болон түүнд заасан бусад баримт бичгийн хамт гэрээний талуудын эрх үүргийг тодорхойлно.

ГЕН-ийг нэгж үнийн гэрээнд хэрэглэх бөгөөд зуулт тайлбарыг өөрчлөн нийт үнийн гэрээнд ашиглаж болно.

7 дугаар бүлэг (Гэрээний ерөнхий нөхцөл)-ийн заалтуудыг өөрчлөхгүйгээр мөрдөх ба эдгээр өөрчлөлтийг Гэрээний тусгай нөхцөлд тусгана.



Гарчиг

А. Ерөнхий заалт

1. Нэр томьёо
2. Тайлбарлах
3. Гэрээний хэл ба хууль
4. Гэрээ
5. Гэрээг шилжүүлэх
6. Баримт бичгийг хадгалж хамгаалах, хангах
7. Нууцлал бүхий мэдээлэл
8. Хуулийн шаардлага хангах
9. Хамтаар ба дангаар хүлээх хариуцлага
10. Төслийн менежерийн шийдвэр
11. Төслийн менежерийн үүрэг хариуцлагыг шилжүүлэх
12. Харилцаа
13. Ажил туслан гүйцэтгүүлэх
14. Бусад гүйцэтгэгч
15. Ажилтнууд
16. Захиалагч, гүйцэтгэгчийн эрсдэл
17. Захиалагчийн эрсдэл
18. Гүйцэтгэгчийн эрсдэл
19. Даатгал
20. Ажлын талбайн судалгааны гайлан
21. Тусгай нөхцөлийн тухай асуулга
22. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх
23. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөрт багтаан дуусгах ажил
24. Төслийн менежерээр батлуулах
25. Аюулгүй байдлын горим
26. Олдвор
27. Ажлын талбайг эзэмших
28. Ажлын талбайд нэвтрэн орох
29. Зааварчилгаа
30. Маргаан таслагчийг томилох
31. Маргаан шийдвэрлэх горим

Б. Ажилтан ба хөдөлмөр

32. Албадан хөдөлмөр
33. Хүүхдийн хөдөлмөр
34. Ажилчдын холбоо
35. Үл ялгаварлах ба тэгш боломж

В. Хугацааны хяналт

36. Ажлын хөтөлбөр
37. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдрийг сунгах
38. Ажлыг хурдасгах
39. Төслийн менежер ажлыг хойшлуулах
40. Ажлын уулзалт
41. Урьдчилан анхааруулах

Г. Чанарын хяналт

42. Зөрчил гологдлыг илрүүлэх
43. Туршилт
44. Зөрчил гологдлыг арилгах
45. Зөрчил гологдлыг арилгахгүй байх

Д. Зардлын хяналт

46. Ажлын тоо хэмжээ



47. Ажлын тоо хэмжээг өөрчлөх
48. Өөрчлөлт
49. Өөрчлөлтийн төлбөр
50. Бэлэн мөнгөний урсгалын урьдчилсан тооцоо
51. Төлбөрийн мэдэгдэл
52. Төлбөр
53. Нөхөн төлбөр хийх нөхцөл
54. Татвар
55. Мөнгөн тэмдэгт
56. Үнийн тохируулга
57. Барьцаа мөнгө
58. Алданги
59. Урамшуулал
60. Урьдчилгаа төлбөр
61. Гүйцэтгэлийн баталгаа
62. Өдөр-ажил
63. Засварын зардал

Е. Давагдашгүй хүчин зүйл

64. Давагдашгүй хүчин зүйлийн тодорхойлолт
65. Давагдашгүй хүчин зүйлийг мэдэгдэх
66. Ажил хоцролтыг багасгах үүрэг
67. Давагдашгүй хүчин зүйлийн үр дагавар
68. Давагдашгүй хүчин зүйл туслан гүйцэтгэгчид нөлөөлөх нь
69. Сайн дураар гэрээ цуцлах, төлбөр төлөх, үүргээс чөлөөлөх
70. Гүйцэтгэлээс чөлөөлөх

Ё. Гэрээг дуусгах

71. Ажил дуусгах
72. Хүлээн авах
73. Эцсийн төлбөр
74. Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлага
75. Гэрээг цуцлах
76. Залилан ба авлига
77. Гэрээг цуцлахад хийх төлбөр
78. Өмч
79. Гүйцэтгэлээс чөлөөлөх
80. АХБ-ны зээлийг зогсоох
81. Эрх бүхий нөхцөл



Гэрээний ерөнхий нөхцөл

А. Ерөнхий заалт

1. Нэр томьёо

1.1 Тодорхойлсон нэр томьёог тод үсгээр бичив.

Ажил гэж ГТН-д тодорхойлсоны дагуу гүйцэтгэгчийн барьж угсран, захиалагчид хүлээлгэн өгөх зорилгоор гэрээнд заасан ажлыг хэлнэ.

Ажил дуусгах өдөр гэж ГЕН-ийн 71.1 [Ажил дуусгах]-д заасны дагуу төслийн менежерээр гэрчлүүлсний үндсэн дээр ажлыг гүйцэтгэж дуусгахаар тогтоосон өдрийг хэлнэ.

Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр гэж гүйцэтгэгч ажлыг дуусгахаар төлөвлөсөн өдрийг хэлнэ. Энэ өдрийг зөвхөн төслийн менежер хугацаа сунгах, эсхүл хурдасгах захиалга өгөх замаар шинэчлэн тогтоож болно.

Ажил эхлэх өдөр гэж ГТН-д заасны дагуу гүйцэтгэгч ажил гүйцэтгэж эхлэх өдрийг хэлнэ. Энэ өдөр нь ажлын талбайг эзэмших өдөртэй заавал давхцахгүй байж болно.

Ажлын талбай гэж ГТН-д тодорхойлсон газрыг хэлнэ.

Ажлын талбайн судалгааны тайлан гэж ажлын талбай дах гадаргуу, хөрс, цаг уурын нөхцлийн талаарх бодит байдлыг дурдаж тайлбарласан бөгөөд тендерийн баримт бичигт тусгагдсан тайланг хэлнэ.

Ажлын тоо хэмжээ гэж гүйцэтгэгчээс ажлын тоо хэмжээний мэдээлэл, жагсаалт, нэгж үнэ ба үнийг тусгаж тендерийн хамт ирүүлсэн хуваарийг хэлнэ.

АХБ гэдэг нь Азийн хөгжлийн банкыг хэлнэ.

Байгууламж гэж механик, цахилгаан, хими, эсхүл биологийн үйл ажиллагаа бүхий хэсэг ажлыг хэлнэ.

Гүйцэтгэгч гэж захиалагчийн хүлээн авсан тендерийг ирүүлсэн этгээдийг хэлнэ.

Гэрээ гэж ажил гүйцэтгэх, дуусгах, засвар үйлчилгээ явуулахын тулд захиалагч ба гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээг хэлнэ. Гэрээ нь ГЕН-ийн 2.3-г дурдсан баримт бичгээс бүрдэнэ.

Гэрээний анхны үнэ гэж гэрээ байгуулах эрх олгох тухай захиалагчийн мэдэгдэлд дурдсан гэрээний үнийг хэлнэ.

Гэрээний үнэ гэж гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэлд дурдсан, гэрээний дагуу цаашид өөрчилж тохируулсан үнийг хэлнэ.

Захиалагч гэж ажил хийлгэхээр гүйцэтгэгчийг хөлслөн ажиллуулж буй этгээдийг хэлнэ.

Зөрчил гөлөгдол гэж гэрээний дагуу хийгдээгүй аливаа ажлыг хэлнэ.



Зөрчил гологдол арилгасан тухай мэдэгдэл гэж гүйцэтгэгч зөрчил гологдлыг арилгасныг үндэслэн төслийн менежерийн гаргасан баталгааг хэлнэ.

Зураг төсөл гэж гэрээг гүйцэтгэхтэй холбоотойгоор төслийн менежерийн гаргасан, эсвэл баталсан тооцоо, бусад мэдээллийг хэлнэ.

Маргаан таслагч гэж ГЕН-ийн 30.1 [Маргаан таслагчийг томилох]-г заасныг үндэслэн аливаа маргааныг эхэн үед нь шийдвэрлүүлэхээр захиалагч, гүйцэтгэгч нарын хамтран томилсон этгээдийг хэлнэ.

Материал гэж ажлын зорилгоор гүйцэтгэгчийн ашиглах бүх төрлийн барилгын материал, түүхий эд, хийц, бүтээгдхүүн, эд анги болон бусад зүйлсийг хэлнэ.

Нөхөн төлбөр хийх нөхцөл гэж энэхүү ГЕН-ийн 53 [Нөхөн төлбөр хийх нөхцөл]-г тодорхойлсон нөхцлүүдийг хэлнэ.

Өдөр гэж хуанлийн өдрийг, сар гэж хуанлийн сарыг тус тус хэлнэ.

Өдөр-ажил гэж дагалдах материал ба байгууламжийн төлбөрөөс гадна гүйцэтгэгчийн ажилтнууд ба тоног төхөөрөмжийн ажилласан хугацаанд үндэслэн хийгдэх төлбөртэй уялдаа бүхий төрөл бүрийн ажлын орц хэмжээг хэлнэ.

Өөрчлөлт гэж ажилд өөрчлөлт оруулах талаар төслийн менежерийн өгсөн зааварчилгааг хэлнэ.

Тендер гэж гүйцэтгэгчээс захиалагчид ирүүлсэн иж бүрдэл тендерийн баримт бичгийг хэлнэ.

Тодорхойлолт гэж гэрээнд заасан ажлын тодорхойлолт бөгөөд түүнд төслийн менежерийн оруулсан болон баталсан нэмэлт, өөрчлөлтүүд мөн хамаарна.

Тоног төхөөрөмж гэж ажил гүйцэтгэх зорилгоор ажлын талбайд түр хугацаагаар гүйцэтгэгчийн авчирсан машин механизм, тээврийн хэрэгслийг хэлнэ.

Төслийн менежер гэж ажлын гүйцэтгэлд хяналт тавьж гэрээний удирдлагыг хэрэгжүүлэх үүрэгтэй, ГТН-д дурдсан этгээд (эсхүл төслийн менежерийн оронд ажиллуулахаар захиалагчийн томилж, гүйцэтгэгчид мэдэгдсэн этгээд)-ийг хэлнэ.

Туслан гүйцэтгэгч гэж гэрээнд тусгагдсан ажлын тодорхой хэсгийг хийхээр гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан этгээдийг хэлнэ.

Туслах ажил гэж барилгын ажлыг гүйцэтгэх, суурилуулах шаардлагатай улмаас гүйцэтгэгчийн төлөвлөж, барьж, суурилуулж, зайлуулсан ажлыг хэлнэ.

Чанарын баталгааг хугацаа (Ашиглалтад зүгшрүүлэн тохируулах хугацаа) гэж ГЕН-д заасан бөгөөд ажил дууссан өдрөөс эхлэн тоологдох хугацааг хэлнэ. Энэ хугацаанд илэрсэн зөрчил гологдлыг гүйцэтгэгч арилгах үүрэгтэй.



- 2. Тайлбарлах**
- 2.1 Энэхүү ГЕН-д ганц тоогоор илэрхийлсэн үг нь олон тоог, эр хүйсээр тэмдэглэсэн утга нь эм эсхүл саармаг хүйсийг буюу харилцан адил утгыг илэрхийлнэ. Гарчигт гол ач холбогдол өгөхгүй. Тусгайлан тодорхойлоогүй бол, үг хэллэг нь гэрээнд баримтлах хэлэнд тогтсон ердийн нийтлэг утгыг илэрхийлнэ. Төслийн менежер ГЕН-тэй холбоотойгоор гаргасан асуулгын хариу тодруулгыг хийсэн удирдамж, зааврыг гаргана.
- 2.2 Хэрэв ГТН-д ажлыг үе шатаар буюу хэсэгчлэн гүйцэтгэж дуусгахаар заасан бол ГЕН-д тодорхойлсон ажил, ажил дуусгах өдөр, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр гэсэн нэр томъёонууд нь нийт ажлын хэсэг бүрт хамаарна.
- 2.3 Гэрээний бүрдэл хэсэг болох баримт бичгийг тайлбарлахдаа доор дурдсан дарааллыг мөрдөнө:
- (а) Гэрээ,
 (б) Хүлээн зөвшөөрсөн тухай мэдэгдэл,
 (в) Тендер ирүүлэх маягт,
 (г) Гэрээний тусгай нөхцөл,
 (д) Тендерийн баримт бичгийн 5 дугаар бүлэгт заасан эрх бүхий орнуудын жагсаалт,
 (е) Гэрээний ерөнхий нөхцөл,
 (ё) Тодорхойлолт,
 (ж) Ажлын зураг,
 (з) Үйл ажиллагааны эцсийн хуваарь ба ажлын тоо хэмжээ, болон
 (и) ГТН-д гэрээний бүрдэл хэсэг болохоор заасан өөр бусад баримт бичиг.
- 3. Гэрээний хэл ба хууль**
- 3.1 Гэрээний хэл ба гэрээнд баримтлах хуулийг ГТН-д тусгана.
- 4. Гэрээ**
- 4.1 ГТН-д өөрөөр заагаагүй бол, гүйцэтгэгчийг гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл хүлээн авснаас хойш 28 хоногт багтаан талууд гэрээг байгуулна. Гэрээг 9 дүгээр бүлгийн гэрээний маягтанд үндэслэн байгуулна. Энэхүү гэрээг байгуулахтай холбоотойгоор үүсэх улсын тэмдэгтийн хураамж, мөн (хэрэв байгаа бол) хуулиар тогтоосон өөр бусад адилтгах хураамж, шимтгэлийн зардлыг захиалагч хариуцна.
- 5. Гэрээг шилжүүлэх**
- 5.1 Гэрээний аль нэг тал нь гэрээг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн, эсхүл гэрээтэй холбоотойгоор буюу гэрээний хүрээнд үүсэх аливаа ашиг тус эсвэл сонирхолыг бусдад шилжүүлэхийг хориглоно. Гэхдээ, гэрээний аль нэг тал нь:
- (а) гэрээний нөгөө талтай урьдчилж тохиролцсоны дагуу, гагцхүү нөгөө талын гаргасан ганцаарчилсан шийдвэрийг үндэслэн, гэрээг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн шилжүүлж болно;
 (б) гэрээний дагуу хүлээн авах ёстой, эсхүл цаашид хүлээн авах аливаа мөнгөн хөрөнгийн эрхээ банк эсхүл санхүүгийн байгууллагын баталгаа хэлбэрээр бусдад шилжүүлж болно.
- 6. Баримт бичгээр хангах, хадгалж хамгаалах**
- 6.1 Тодорхойлолт, ажлын зураг нь захиалагчийн хяналт, эзэмшил, хамгаалалтад байна. Гэрээнд өөрөөр заагаагүй бол, гэрээ ба ажлын зураг тус бүрийн хоёр хувь хуулбарыг гүйцэтгэгчид олгох бөгөөд гүйцэтгэгч өөрийн зардалаар нэмэлт хувь хуулбарыг хийж эсхүл хийлгүүлэхээр хүсэлт гаргаж болно.
- 6.2 Гүйцэтгэгчийн баримт бичгийн бүрдэл тус бүр нь захиалагчид хүлээлгэн өгснөөс бусад тохиолдолд буюу хүлээлгэн өгөх хүртэл



гүйцэтгэгчийн хяналт, эзэмшил, хамгаалалтад байна. Гэрээнд өөрөөр заагаагүй бол, гүйцэтгэгч нь өөрийн баримт бичгийн бүрдэл тус бүрийн зургаан хувь хуулбарыг инженерт гаргаж өгнө.

6.3 Гүйцэтгэгч нь ажлын талбайд гэрээ, тодорхойлолтод тусгагдсан хэвлэмэл материалууд, (хэрэв байгаа бол) гүйцэтгэгчийн баримт бичиг, ажлын зураг, өөрчлөлт, мөн гэрээний дагуу үйлдэгдсэн өөр бусад захидал харилцааны хуулбар хувийг байршуулан хадгална. Захиалагчийн ажилтан нь тэдгээр бүх баримт бичигтэй зохистой аль ч үед танилцах эрхтэй.

6.4 Хэрэв гэрээний аль нэг тал ажил гүйцэтгэхэд ашиглах зорилгоор бэлтгэн боловсруулсан тодорхой баримт бичигт ямар нэг алдаа эсвэл зөрчил гологдол байгааг олж мэдсэн бол тэрхүү алдаа эсвэл зөрчил гологдлын талаар нөгөө талд нэн даруй мэдэгдэнэ.

7. Нууцлал бүхий мэдээлэл

7.1 Гүйцэтгэгчийн ба захиалагчийн ажилтнууд нь гүйцэтгэгч гэрээний шаардлагыг ханган ажиллаж байгаа эсэхийг нягтлан шалгаж, улмаар гэрээг зохистой хэлбэрээр хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэхэд зохих ёсоор шаардагдах аливаа нууц болон бусад бүх мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй.

7.2 Талууд гэрээгээр хүлээсэн өөрсдийн үүргээ биелүүлэх, эсхүл холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн ажиллах зайлшгүй шаардлага гарснаас бусад тохиолдолд гэрээний бүх мэдээлэлд хандахдаа тэдгээрийг хаалттай бөгөөд нууцлал бүхий хэмээн ойлгоно. Аль нэг тал нөгөө талын бэлтгэсэн боловсруулсан, ажилтай холбоотой аливаа мэдээллийг түүнтэй урьдчилан тохиролцолгүйгээр нийтэд дэлгэх буюу задруулахыг хориглоно. Гэхдээ гүйцэтгэгч нь нийтийн хүртээл болсон аливаа мэдээлэл, эсхүл өөр төсөлд өрсөлдөх зорилгоор өөрийн ажлын ур чадварыг илтгэн харуулахад шаардагдах өөр бусад мэдээллийг задруулах эрхтэй.

7.3 Дээр дурдсанаас үл хамааран, гүйцэтгэгч нь өөрийн туслан гүйцэтгэгч нарт гэрээний дагуу хийгдэх ажлыг гүйцэтгэхэд шаардагдах хэмжээнд захиалагчаас хүлээн авсан аливаа баримт бичиг, өгөгдөл, бусад мэдээллийг туслан гүйцэтгэгч нарт өгөх бөгөөд энэ тохиолдолд гүйцэтгэгч энэхүү заалтын дагуу өөрийн хүлээсэнтэй адил нууцлал хадгалах үүрэг баталгааг туслан гүйцэтгэгч нараас гаргуулж авна.

8. Хуулийн шаардлага хангах

8.1 Гүйцэтгэгч нь гэрээг хэрэгжүүлэхдээ холбогдох хуулиудын шаардлагыг хангаж ажиллана.

8.2 ГТН-д өөрөөр заагаагүй бол:

(а) Захиалагч нь засгийн газрын байгууллагаас (1) эдгээр байгууллага нь захиалагчийг өөрийн нэрээр холбогдох зөвшөөрөл авахыг шаардаж байгаа, мөн (2) гэрээг хэрэгжүүлэхэд, ялангуяа гүйцэтгэгч болон захиалагчийн аль аль нь гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэхэд шаардагдах аливаа зөвшөөрөл, баталгаа, мөн/эсхүл тусгай зөвшөөрлийг авч, холбогдох төлбөрийг хариуцах үүрэгтэй.

(б) Гүйцэтгэгч нь засгийн газрын байгууллагаас (1) эдгээр байгууллага нь гүйцэтгэгчийг өөрийн нэрээр холбогдох зөвшөөрөл авахыг шаардаж байгаа, мөн (2) гэрээг хэрэгжүүлэхэд, ялангуяа гүйцэтгэгч ба туслан гүйцэтгэгчийн ажилтнуудын хэрэгцээнд авах виза, гүйцэтгэгчийн аливаа импортоор оруулж ирсэн тоног төхөөрөмжийг нэвтрүүлэхэд зайлшгүй шаардагдах аливаа зөвшөөрөл, баталгаа, мөн/эсхүл тусгай зөвшөөрлийг авч, холбогдох төлбөрийг хариуцах үүрэгтэй. Гүйцэтгэгч нь мөн энэхүү 8.2(а)-д заасны дагуу



захиалагчийн хариуцахаар тогтоосноос бусад, түүнчлэн гэрээг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардагдах бусад аливаа зөвшөөрөл, баталгаа, мөн/эсхүл тусгай зөвшөөрлийг авах үүрэгтэй. Гүйцэтгэгч нь 8.1-д заасан үүргийг зөрчилгүйгээр захиалагч эсхүл түүний ажиллах хүчин, түүнчлэн туслан гүйцэтгэгч, түүний ажилтнуудын холбогдох хууль тогтоомж зөрчсөнтэй холбоотойгоор буюу зөрчсөний улмаас учирсан аливаа хариуцлага, зөрчил гологдол, шаардлага, мөнгөн торгууль, шийтгэл, аливаа төрлийн зардал зэргээс захиалагчийг чөлөөлөх буюу хохиролгүй болгоно.

- 9. Хамтаар ба дангаар хүлээх хариуцлага**
- 9.1 Хэрэв гүйцэтгэгч нь хоёр буюу түүнээс дээш этгээдээс бүрдсэн түншлэл, консорциум, эсхүл нэгдэл байгаа тохиолдолд ийм бүх этгээд нь ГТН-д өөрөөр заагаагүй бол гэрээний заалтуудыг ханган биелүүлэх үүргийг захиалагчийн өмнө хамтаар болон дангаар хүлээх үүрэгтэй бөгөөд түншлэл, консорциум, эсхүл нэгдлийг баталгаажуулах үүднээс тэдгээр этгээдээс нэгийг нь эрх бүхий удирдах этгээдээр томилно. Түншлэл, консорциум, эсхүл нэгдлийн бүтэц, бүрэлдэхүүнийг захиалагчаас урьдчилан өгсөн зөвшөөрөлгүйгээр өөрчлөхийг хориглоно.
- 10. Төслийн менежерийн шийдвэр**
- 10.1 Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг толоолон төслийн менежер шийдвэрлэнэ.
- 11. Төслийн менежерийн үүрэг хариуцлагыг шилжүүлэх**
- 11.1 Төслийн менежер нь гүйцэтгэгчид мэдэгдсэнээр хариуцсан үүрэг хариуцлагыг бусад этгээдэд шилжүүлж болох ба үүнийг хүчингүй болгохдоо мөн гүйцэтгэгчид мэдэгдэнэ.
- 12. Харилцаа**
- 12.1 Гэрээний ерөнхий нөхцлийн талаарх талуудын харилцаа нь зөвхөн бичгээр үйлдэгдсэн тохиолдолд хүчинтэй байна. Бичгээр гаргасан мэдэгдэл нь нөгөө тал хүлээн авснаар хүчинтэй болно.
- 13. Ажил туслан гүйцэтгүүлэх**
- 13.1 Гүйцэтгэгч төслийн менежерийн зөвшөөрснөөр ажлыг туслан гүйцэтгүүлж болно. Гэхдээ захиалагчийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр гэрээнд заасан ажлыг бусад шилжүүлэн даалгаж болохгүй. Ажлыг туслан гүйцэтгүүлснээр гүйцэтгэгчийн үүрэг хариуцлага өөрчлөгдөх ёсгүй.
- 14. Бусад гүйцэтгэгч**
- 14.1 Гүйцэтгэгч нь ажлын талбайг ГТН-д шаардсаны дагуу бусад гүйцэтгэгчдийн хуваарьт заасан хугацааг үндэслэн бусад гүйцэтгэгч, төрийн байгууллага, нийтийн аж ахуй, үйлчилгээний газар болон захиалагчтай хамтран ашиглаж ажиллах үүрэгтэй. Гүйцэтгэгч нь тэдгээр этгээдийг уг хуваарьт заасны дагуу ажлын хэрэгсэл, үйлчилгээгээр хангана. Захиалагч нь бусад гүйцэтгэгчдийн хуваарийг өөрчилж болох бөгөөд үүнийг гүйцэтгэгчид мэдэгдэнэ.
- 15. Ажилтнууд**
- 15.1 Гүйцэтгэгч ГТН-ийн дагуу үндсэн ажилтны хуваарьт заасан ажил үүргийг гүйцэтгэх үндсэн ажилтныг, эсхүл төслийн менежерийн зөвшөөрсөн бусад ажилтныг ажиллуулна. Төслийн менежер нь үндсэн ажилтныг солих тухай аливаа хүсэлтийг зөвхөн санал болгож буй ажилтны чадвар нь дээрх хуваарьт заасан ажилтны чадвартай ижил, эсхүл түүнээс илүү байгаа нөхцөлд зөвшөөрч батлана.
- 15.2 Хэрэв төслийн менежер гүйцэтгэгчийн аль нэг ажилтныг цаашид ажиллуулахгүй байх талаар үндэслэл бүхий саналыг гүйцэтгэгчид тавьсан бол гүйцэтгэгч тухайн ажилтанг 7 хоногийн дотор ажлын талбайгаас чөлөөлж, түүнийг цаашид гэрээний дагуу гүйцэтгэх ажилд оролцуулахгүй.



- 15.3 Хэрэв гүйцэтгэгчийн аль нэг ажилтанг ажил гүйцэтгэх явцдаа авлига, залилан мэхлэх, үгсэн хуйвалдах, дарамт шахалт үзүүлэх, саад учруулах үйлдэл эсхүл шударга бус байдлын бусад зөрчилд холбогдсон гэж захиалагч, төслийн менежер эсхүл гүйцэтгэгч өөрөө үзсэн бол тухайн ажилтанг дээрх 15.2 дахь заалтад нийцүүлэн ажлаас чөлөөлнө.
16. **Захиалагч, гүйцэтгэгчийн эрсдэл**
- 16.1 Захиалагч нь энэхүү гэрээнд тодорхойлогдсон захиалагчийн хүлээх эрсдлийг хүлээнэ. Гүйцэтгэгч нь энэхүү гэрээнд тодорхойлогдсон гүйцэтгэгчийн хүлээх эрсдлийг хүлээнэ.
17. **Захиалагчийн эрсдэл**
- 17.1 Ажил эхлэх өдрөөс зөрчил гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргах хүртэл хугацаанд захиалагч дараах эрсдлийг хүлээнэ:
- (a) Дараах шалтгааны улмаас ажилтан бэртэх, нас барах, эсхүл эд хөрөнгөд хохирол учруулснаас үүсэх (ажил, байгууламж, материал, тоног төхөөрөмж үл хамаарах) эрсдэл:
 - (i) ажлын зайлшгүй үр дүнхийг улмаас, ажлын талбайг ажилд буюу ажлын зорилгоор ашиглах эсхүл эзэмших явцад; эсвэл
 - (ii) захиалагч, эсхүл түүний хөлслөн ажилдуулж буй эсвэл гэрээгээр ажиллуулж буй гүйцэтгэгчээс бусад этгээдийн хариуцлагагүй, хууль ёсны үүргээ зөрчсөн, эсхүл түүнд олгогдсон эрхийг буруу эдэлсний улмаас үүдэн гарсан.
 - (b) Захиалагчийн гэм буруугаас, эсхүл захиалагчийн зураг төслийн алдаанаас, эсхүл ажил гүйцэтгэгдэх оронд шууд нөлөөлөх гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас ажил, байгууламж, материал болон тоног төхөөрөмжийг гэмтээх эрсдэл.
- 17.2 Ажил дууссан өдрөөс зөрчил гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргасан өдөр хүртэл хугацаанд ажил, байгууламж, материал алдагдах, эвдэрч гэмтэх эрсдэл нь доор дурдсанаас бусад тохиолдолд захиалагчийн хүлээх эрсдэл болно:
- (a) ажил дуусах өдөрт арилгаж чадаагүй байгаа зөрчил гологдол;
 - (b) захиалагчийн хүлээх эрсдэлд хамаарахгүй бөгөөд ажил дуусах өдрөөс өмнө бий болсон нөхцөл; эсвэл
 - (в) ажил дууссан өдрөөс хойш ажлын талбай дээр гүйцэтгэгчийн явуулсан үйл ажиллагаа.
18. **Гүйцэтгэгчийн эрсдэл**
- 18.1 Ажил эхлэсэн өдрөөс зөрчил гологдол арилгах тухай мэдэгдэл гаргасан өдөр хүртэл хугацаанд хүн бэртэх, нас барах, түүнчлэн эд хөрөнгө (ажил, байгууламж, материал, тоног төхөөрөмжийг оролцуулах бөгөөд эдгээрээр хязгаарлахгүй) алдагдах, эвдэрч гэмтэхээс үүдэн гарсан бөгөөд захиалагчийн хүлээх эрсдлээс бусад эрсдлийг гүйцэтгэгч хүлээнэ.
19. **Даатгал**
- 19.1 Гүйцэтгэгч нь гүйцэтгэгчийн хүлээх эрсдэлд хамаарах доор дурдсан тохиолдолд ажил эхлэсэн өдрөөс зөрчил гологдол арилгах хугацаа дууссан өдөр хүртэл хугацааг хамарсан даатгалыг гүйцэтгэгч ба захиалагчийн хамтарсан нэрээр ГТН-д заасан дүнгээр хийлгэнэ:
- (a) ажил, байгууламж болон материал алдагдах, эвдэрч гэмтэх;
 - (b) тоног төхөөрөмж алдагдах, эвдэрч гэмтэх;
 - (в) гэрээний хэрэгжилтэй холбоотойгоор эд хөрөнгө (ажил, байгууламж, материал, тоног төхөөрөмжөөс бусад) алдагдах, эвдэрч гэмтэх; болон
 - (г) хүн бэртэх, эсхүл нас барах.



- 19.2 Гүйцэтгэгч нь даатгалын гэрээ, гэрчилгээг төслийн менежерт хүргүүлэх ба төслийн менежер ажил эхлэх өдрөөс өмнө тэдгээрийг хянаж батална. Эдгээр бүх даатгалыг дээрх 19.1-д заасан хохирлыг арилгахад зориулж ГТН-д заасан хэмжээгээр хийлгэнэ.
- 19.3 Хэрэв гүйцэтгэгч шаардлагатай даатгалын гэрээ, гэрчилгээг ирүүлдээгүй бол захиалагч даатгалын гэрээг байгуулж, даатгалын төлбөрийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авна. Хэрэв захиалагчаас гүйцэтгэгчид төлөх төлбөргүй бол даатгалын төлбөр нь гүйцэтгэгчээс захиалагчид төлөх өр болно.
- 19.4 Даатгалын нөхцлийг төслийн менежерийн зөвшөөрөлгүйгээр өөрчилж болохгүй.
- 19.5 Хоёр тал даатгалын гэрээний бүх нөхцлийг биелүүлнэ.
- 20. Ажлын талбайн судалгааны тайлан** 20.1 Гүйцэтгэгч тендер бэлтгэхдээ ГТН-д дурдсан ажлын талбайн судалгааны тайлан болон тендерт оролцогчид зориулсан бусад нэмэлт мэдээллийг ашиглана.
- 21. Тусгай нөхцлийн тухай асуулга** 21.1 ГТН-ийн талаар гаргасан асуулгад төслийн менежер тодруулга хийж, тайлбар өгнө. Ийм тодруулгаар гэрээний нөхцлийг өөрчлөхгүй.
- 22. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх** 22.1 Гүйцэтгэгч ажлыг тодорхойлолт ба зурагт нийцүүлэн гүйцэтгэнэ.
- 23. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөрт багтаан дуусгах ажил** 23.1 Гүйцэтгэгч ажил эхлэх өдөрт ажлыг эхлүүлэн, гүйцэтгэгчээс гаргаж, тухай бүр төслийн менежерээс шинэчлэн баталсан ажлын хөтөлбөрт нийцүүлэн ажлыг гүйцэтгэх ба ажил дуусгахаар төлөвлөсөн өдөрт багтаан дуусгана.
- 24. Төслийн менежерээр батлуулах** 24.1 Гүйцэтгэгч санал болгож буй туслах ажлын тодорхойлолт ба зураг төслийг төслийн менежерт хүргүүлэх ба эдгээр нь ажлын тодорхойлолт, зураг төсөлд нийцсэн тохиолдолд төслийн менежер түүнийг батална.
- 24.2 Гүйцэтгэгч нь туслах ажлын зураг төслийг хариуцна.
- 24.3 Төслийн менежерээр туслах ажлын зураг төслийг батлуулах нь туслах ажлын зураг төсөлтэй холбоотой гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг өөрчлөхгүй.
- 24.4 Шаардлагатай тохиолдолд гүйцэтгэгч туслах ажлын зураг төсөлд холбогдох байгууллагын зөвшөөрөл авна.
- 24.5 Түр эсвэл үндсэн ажлыг гүйцэтгэх зорилгоор гүйцэтгэгчийн бэлтгэсэн бүх зургийг ажил эхлэхээс өмнө төслийн менежер батална.
- 25. Аюулгүй байдлын горим** 25.1 Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хариуцна.
- 25.2 Гүйцэтгэгч барьж байгаа барилга, байгууламжаа болзошгүй болон давагдашгүй зүйлээс хамгаалах, мөн түүнээс урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээг авах үүрэгтэй. Гүйцэтгэгч барилга, байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм журам, дүгнэлт шийдвэрийг хүлээн авч биелүүлнэ.
- 26. Олдвор** 26.1 Ажлын талбайд санамсаргүй олж илрүүлсэн түүх дурсгалын болон бусад үнэт эд зүйлс нь Монгол улсын өмч болно⁷. Гүйцэтгэгч нь олдворыг төслийн менежерт мэдэгдэж, энэ талаар түүний зааварчилгааг биелүүлнэ.
- 27. Ажлын талбайг эзэмших** 27.1 Захиалагч барилга барих эдэлбэр газрын болон барилгын талбайд орсон бүх төрлийн барилга, байгууламж, инженерийн шугам сүлжээ, авто болон төмөр замыг буулгах, зөөх, шилжүүлэх, хөдөлгөөнийг

⁷ Төслийн менежер нь олж илрүүлсэн түүх дурсгалын болон бусад үнэт эд зүйлсийг зохих журмын дагуу холбогдох байгууллагад шилжүүлнэ.



- зогсоох зөвшөөрөл, уг барилгын цахилгаан, дулаан, цэвэр, бохир усан хангамж, уур, телефон, радио холбооны инженерийн шугам сүлжээнд холбох эх үүсвэрийг тодорхойлсон тодорхойлолт, зураг төсөл, барилгын ажил эхлэх зөвшөөрөл, улаан шугам тавьсан акт, бусад холбогдох баримт бичгийг хүлээлгэн өгч ажлын талбайн бүх хэсгийг гүйцэтгэгчид ашиглуулна.
- 27.2 Хэрэв аль нэг хэсгийг ГТН-д заасан хугацаанд ашиглуулж эхлээгүй бол холбогдох ажлыг эхлүүлэхэд захиалагчыг саад болсонд тооцох ба үүнтэй холбогдон гарах нөхөн төлбөрийг гүйцэтгэгчид гаргана.
- 28. Ажлын талбайд нэвтрэн орох**
- 28.1 Гүйцэтгэгч нь төслийн менежер ба түүний эрх олгосон аливаа этгээдийг ажлын талбайд болон гэрээний ажилтай холбоотой ажил хийгдэж буй, эсхүл хийхээр төлөвлөж буй аливаа газарт нэвтрүүлэх үүрэгтэй.
- 29. Зааварчилгаа**
- 29.1 Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй.
- 29.2 Гүйцэтгэгч нь өөрийн данс, бүртгэл тооцоо болон тендерийг ирүүлэх, гэрээний гүйцэтгэлтэй холбоотой бусад баримт бичгийг хянан шалгах, АХБ-наас томилсон аудитын байцаагчаар тэдгээрийг хянуулах эрхийг АХБ-нд зөвшөөрөх ёстой. Гүйцэтгэгч гэрээтэй холбоотой бүх баримт бичиг, бүртгэл тооцоог ажил дууссанаас хойш гурван (3) жилийн хугацаанд хадгална. Гүйцэтгэгч авлига, залилан мэхлэх, үгсэн хуйвалдах, дарамт шахалт үзүүлэх эсхүл саад учруулах үйлдэл болон шударга байдлыг зөрчих зэрэгт хамаарах мөрдөн шалгах ажиллагаанд шаардагдах аливаа баримт бичгийг гарган өгч, гэрээний талаар мэдлэгтэй өөрийн ажилтан эсхүл төлөөлөгч нарт АХБ-наас тавьсан асуулгад хариу өгөхийг даалган шаардах үүрэгтэй.
- 30. Маргаан таслагчийг томилох**
- 30.1 Захиалагч, гүйцэтгэгч нар маргаан таслагчийг захиалагчаас гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл гарсны дараа хамтран томилно. Захиалагч хэрэв гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэлд маргаан таслагчийг томилохыг зөвшөөрөөгүй бол тэрээр ГТН-д заасны дагуу томилох эрх бүхий байгууллагад хандан маргаан таслагчийг ийм хүсэлт гаргаснаас хойш 14 хоногийн дотор томилж өгөхийг хүснэ.
- 30.2 Хэрэв маргаан таслагч ажлаас чөлөөлөгдсөн эсхүл нас барсан эсхүл маргаан таслагчийг гэрээнд заасан үүргээ гүйцэтгэж чадахгүй байна гэж захиалагч, гүйцэтгэгч нар үзэж байгаа бол тэд маргаан таслагчийг шингээр хамтран томилно. Хэрэв захиалагч, гүйцэтгэгч нар маргаан таслагчийг 30 хоногийн дотор харилцан тохиролцон томилж чадахгүй бол томилох эрх бүхий байгууллага аль нэг талын хүсэлтийн дагуу хүсэлт хүлээн авсанаас хойш 14 хоногийн дотор маргаан таслагчийг томилно.
- 31. Маргаан шийдвэрлэх горим**
- 31.1 Хэрэв гүйцэтгэгч төслийн менежерийн шийдвэрийг гэрээнд заасан түүний эрх хэмжээнээс хэтэрсэн эсхүл түүний шийдвэр нь буруу байсан гэж үзэж байгаа бол төслийн менежерээс шийдвэр гарсан тухай мэдэгдэл хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор шийдвэрийн талаар гомдлоо маргаан таслагчид гаргана.
- 31.2 Маргаан таслагч нь гомдол хүлээн авснаас хойш 28 хоногийн дотор шийдвэрээ бичгээр гаргана.
- 31.3 Маргаан таслагчийн ажлын хөлсийг ГТН-д заасан цагний тарифаар, ГТН-д заасан нөхөн олгох зардлын хамт төлөх бөгөөд зардлыг маргаан таслагчийн шийдвэр үр дүнд хүрсэн эсэхээс үл хамааран захиалагч, гүйцэтгэгч нар тэнцүү хуваан төлнө. Аль ч тал маргаан таслагчийн шийдвэрийг бичгээр гарснаас хойш 28 хоногийн дотор шүүхэд гомдлоо гаргаж болно. Хэрэв талууд 28 хоногийн дотор шүүхэд гомдлоо гаргахгүй бол маргаан таслагчийн шийдвэр эцсийн байх бөгөөд талууд уг шийдвэрийг заавал биелүүлнэ.



31.4 Шүүхийн ажиллагааг холбогдох байгууллагаас тогтоосон шүүхийн журмын дагуу ГТН-д заасан газарт явуулна.

Б. Ажилтан ба хөдөлмөр

32. Албадан хөдөлмөр

32.1 Гүйцэтгэгч нь хүч хэрэглэх эсхүл шийтгэл хүдээлгэхээр заналхийлж аливаа этгээдээр сайн дурын үндсэн дээр бус гүйцэтгүүлсэн ямарваа нэг ажил эсхүл үйлчилгээ бүхий албадан хөдөлмөр хийлгэхийг хориглоно. Үүнд боолын хөдөлмөр, хамжлагат ёсны хөдөлмөр гэх зэрэг аливаа сайн дурын бус буюу албадлагын шинжтэй хөдөлмөр эрхлэлт, эсхүл түүнтэй адилтгах бусад хөдөлмөр эрхлэлт хамаарна.

33. Хүүхдийн хөдөлмөр

33.1 Гүйцэтгэгч ашиг хайсан, хүүхдийн боловсролд аюул учруулахуйц эсхүл түүнд сөргөөр нөлөөлөх, хүүхдийн эрүүл мэнд, бие махбодь, оюун ухаан, сэтгэл санаа, ёс суртахуун болон нийгмийн хөгжилд хор хөнөөл үзүүлэх зорилгоор хүүхдээр хөдөлмөр эрхлүүлэхийг хориглоно. Үндэсний хууль тогтоомжид насанд хүрээгүй этгээдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар тодорхой зохицуулалт тусгагдсан тохиолдолд, гүйцэтгэгч нь тэдгээр холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөх үүрэгтэй. 18 насанд хүрээгүй хүүхдүүдээр аюултай нохцол бүхий хөдөлмөр эрхлүүлэхийг хориглоно.

34. Ажилчдын холбоо

34.1 Хөндлөнгийн нөлөөлөлгүйгээр, өөрсдийн хүсэл сонирхлын дагуу ажилчдын холбоо байгууллага үүсгэн байгуулах, түүнд нэгдэн орох, мөн хамтын хэлэлцээр хийх эрхийг хууль тогтоомжоор олгосон тохиолдолд, гүйцэтгэгч тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдөх үүрэгтэй. Ажилчдын холбоо байгууллагыг хууль тогтоомжоор бүхэлд нь хориглосон бол гүйцэтгэгч нь өөрийн ажиллах хүчнийг гомдол саналаа илэрхийлэх, ажиллах орчин болон хөдөлмөр эрхлэлтийн бусад нөхцөлтэй холбоотойгоор өөрсдийн эрхийг хамгаалах өөр бусад арга хэлбэрийг авч хэрэгжүүлэх боломжоор хангах үүрэгтэй. Дээр дурдсан тохиолдлын аль алиных нь хувьд, хууль тогтоомжид тодорхой зохицуулалт тусгагдаагүй бол гүйцэтгэгч өөрийн ажилтнуудыг өөрийн хүсэл сонирхлын дагуу ажилчдын холбоо байгууллага үүсгэн байгуулах эсхүл түүнд нэгдэн орох, мөн тэдний хамтын хэлэлцээр хийх сонирхлыг нь мохоохыг хориглох бөгөөд түүнчлэн, ийм холбоо байгууллага ба хамтын хэлэлцээрт нэгдэн орох, эсхүл нэгдэн орохыг эрмэлзэж буй ажилтныг ялгаварлан гадуурхах эсхүл тэдгээрийн эсрэг хариу арга хэмжээ авахыг хориглоно. Гүйцэтгэгч нь ажилчдын ийм төлөөлөл байгууллагатай хамтран ажиллах үүрэгтэй. Ажилчдын холбоо байгууллага нь ажиллах хүчийг бүрдүүлж буй ажилчдыг шударгаар төлөөлнө.

35. Үл ялгаварлах ба тэгш боломж

35.1 Гүйцэтгэгч ажлын зайлшгүй шаардлагуудтай хамааралгүйгээр хувь хүний онцлог шинжид үндэслэн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой аливаа шийдвэр гаргахыг хориглоно. Гүйцэтгэгч тэгш боломж олгох, шударгаар хандах зарчимд суурилсан хөдөлмөрийн харилцааг удирдлага болгох ба ажилтныг ажилд сонгон шалгаруулах, ажилд авах, нөхөн олговор (палин хөлс, нэмэгдэл зэрэг) тогтоон олгох, ажиллах орчин болон хөдөлмөр эрхлэлтийн бусад нөхцлөөр хангах, сургалтанд хамруулах, албан тушаал дэвшүүлэх, хөдөлмөрийн харилцааг дуусгавар болгох эсхүл өндөр насны тэтгэвэрт гаргах, сахилгын



арга хэмжээ авах зэрэг хөдөлмөрийн харилцаанд хамаарах асуудлуудад хандахдаа ялгаварлахыг хориглоно. Хууль тогтоомжоор хөдөлмөрийн харилцаанд ялгаварлахыг хориглосон тохиолдолд гүйцэтгэгч тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдөх үүрэг хүлээнэ. Хууль тогтоомжид хөдөлмөрийн харилцаанд ялгаварлахыг хориглосон тодорхой зохицуулалт тусгагдаагүй бол гүйцэтгэгч энэ заалтад тусгагдсан шаардлагуудыг хангаж ажиллах үүрэг хүлээнэ. Урьд өмнө гарсан ялгаварлалыг арилгахаар авсан хамгаалалтын тусгай арга хэмжээ эсхүл дэмжлэг туслалцаа, эсхүл тодорхой ажилд зайлшгүй тавигдах шаардлагуудыг удирдлага болгон тухайн ажилд хэн нэгэн этгээдийг сонгон шалгаруулсан явдал зэргийг ялгаварлал гэж үзэхгүй.

В. Хугацааны хяналт

- 36. Ажлын хөтөлбөр**
- 36.1 Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, ГТН-д заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.
- 36.2 Ажлын хөтөлбөрийг тодотгохдоо үйл ажиллагаа бүрийн явц, үр дүн, тэдгээрийн үлдэж буй ажлыг гүйцэтгэх хугацаанд үзүүлэх нөлөө болон үйл ажиллагааны дараалалд оруулсан аливаа өөрчлөлтийг тусгана.
- 36.3 Гүйцэтгэгч нь тодотгосон ажлын хөтөлбөрийг ГТН-д заасан хугацаанд төслийн менежерт батлуулахаар хүргүүлнэ. Хэрэв гүйцэтгэгч тодотгосон ажлын хөтөлбөрийг энэ хугацаанд хүргүүлээгүй бол төслийн менежер ГТН-д заасан дүнг дараагийн гүйцэтгэлийн төлбөрөөс хасч гүйцэтгэгч ажлын хөтөлбөр ирүүлсний дараа хийгдэх төлбөр хүргэл саатуулж болно.
- 36.4 Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлт болон нөхөн төлбөр хийх нөхцөлтийн нөлөөг тусгана.
- 37. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдрийг сунгах**
- 37.1 Хэрэв нөхөн төлбөр хийх нөхцөл үүссэн, эсхүл өөрчлөлтийн улмаас гүйцэтгэгч нэмэлт зардал гаргалгүйгээр ажил дуусгахаар төлөвлөсөн өдөрт багтаан ажил дуусгах боломжгүй болсон бол төслийн менежер ажил дуусгахаар төлөвлөсөн өдрийг сунгана.
- 37.2 Гүйцэтгэгч үүссэн нөхөн төлбөр хийх нөхцөл, эсхүл өөрчлөлтийн үр дагаврын талаар зохих шийдвэр гаргахыг хүсч, холбогдох мэдээллийг ирүүлснээс хойш 21 хоногийн дотор төслийн менежер нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрийг сунгах эсэх, сунгах бол ямар хугацаагаар сунгах тухай шийдвэр гаргана. Хэрэв гүйцэтгэгч хугацаа хоцорсныг урьдчилан анхааруулаагүй, эсхүл хугацаа хоцролтыг арилгах асуудлаар хамтран ажиллаж чадаагүй бол үүнийг ажил дуусгахаар төлөвлөсөн өдрийг шинээр тогтооход харгалзан үзэхгүй.
- 38. Ажлыг хурдасгах**
- 38.1 Хэрэв захиалагч гүйцэтгэгчийг ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс өмнө ажлыг дуусгахыг хүссэн тохиолдолд төслийн менежер ажлыг хурдасгахад шаардагдах үнийн саналыг гүйцэтгэгчээс хүлээн авна. Хэрэв захиалагч уг саналыг хүлээн зөвшөөрвөл ажил дуусгахаар төлөвлөсөн өдрийг саналын дагуу өөрчлөх бөгөөд захиалагч, гүйцэтгэгчийн аль аль нь өөрчлөлтийг батална.



- 38.2 Хурдасгахтай холбоотой гүйцэтгэгчийн үнийн саналыг захиалагч хүлээн зөвшөөрсөн бол саналыг гэрээний үнэд тусгах бөгөөд үүнийг оорчлолт гэж үзнэ.
- 39. Төслийн менежер ажлыг хойшлуулах** 39.1 Төслийн менежер ажлын аль нэг үйл ажиллагааны эхлэл, эсхүл явцыг хойшлуулах зааварчилгааг гүйцэтгэгчид өгч болно.
- 40. Ажлын уулзалт** 40.1 Төслийн менежер эсвэл гүйцэтгэгч нь нөгөө талаасаа ажлын уулзалтад оролцохыг шаардах эрхтэй. Ажлын уулзалтад үлдсэн ажлын төлөвлөгөөг хянан үзэж, урьдчилан анхааруулах горимын дагуу асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 40.2 Төслийн менежер ажлын уулзалтын тэмдэглэлийг үйлдэж, уг тэмдэглэлийн хувийг уулзалтад оролцсон хүмүүст болон захиалагчид хүргүүлнэ. Төслийн менежер хийгдэх арга хэмжээнд талуудын хүлээх үүрэг хариуцлагыг уг ажлын уулзалтан дээр, эсхүл түүний дараа шийдвэрлэж, энэ тухай ажлын уулзалтад оролцсон бүх этгээдэд бичгээр мэдэгдэнэ.
- 41. Урьдчилан анхааруулах** 41.1 Гүйцэтгэгч ажлын чанарт сөргөөр нөлөөлөх, гэрээний үнийг өсгөх, эсхүл ажил дуусгах хугацааг хоцроож болзошгүй нөхцөл байдлын талаар төслийн менежерт аль болох эртхэн анхааруулах үүрэгтэй. Төслийн менежер үүсч болзошгүй нөхцөл байдал нь гэрээний үнэ ба ажил дуусгах аар төлөвлөсөн өдөрт хэрхэн нөлөөлж болох талаарх мэдээллийг гүйцэтгэгчээс шаардах эрхтэй. Гүйцэтгэгч уг мэдээллийг аль болох богино хугацаанд ирүүлнэ.
- 41.2 Гүйцэтгэгч эдгээр нөхцөл байдлын үр дагаврыг хэрхэн арилгах, эсхүл багасгах талаар санал гаргаж төслийн менежерийн гаргасан зааварчилгааг хэрэгжүүлэхдээ түүнтэй хамтран ажиллана.

Г. Чанарын хяналт

- 42. Зөрчил гологдлыг илрүүлэх** 42.1 Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн аливаа зөрчил гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Ийм шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил гологдлыг хайж олох, зөрчил гологдолтой байж болзошгүй гэж үзсэн аливаа ажлыг илрүүлэх, шалгаж турших талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.
- 43. Туршилт** 43.1 Хэрэв төслийн менежер аливаа ажил зөрчил гологдолтой эсэхийг шалгах зорилгоор тодорхойлолтод заагаагүй шалгалт туршилт явуулах зааварчилгааг гүйцэтгэгчид өгч, түүгээр зөрчил гологдол илэрсэн бол гүйцэтгэгч шалгалт туршилт явуулсан зардлыг төлнө. Хэрэв зөрчил гологдол илрээгүй бол шалгалт туршилт нь нөхөн төлбөр хийх нөхцөлд тооцогдоно.
- 44. Зөрчил гологдлыг арилгах** 44.1 Төслийн менежер ГТН-д заасан ашиглалтад зүгшрүүлэн тохируулах хугацаа⁸ дуусахаас өмнө зөрчил гологдол арилгуулах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Ашиглалтад зүгшрүүлэн тохируулах хугацааг зөрчил гологдол эсхүл хохирлыг арилгахад шаардагдах бүх ажлыг дуусгах хүртэл сунгана.

⁸ Ашиглалтад зүгшрүүлэн тохируулах хугацааг тогтооходоо Барилгын тухай хуулийг баримтална.



- 44.2 Зөрчил гологдол арилгасан тухай мэдэгдлийг хүлээн авсан даруйд гүйцэтгэгч уг зөрчил гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
45. Зөрчил гологдлыг арилгахгүй байх 45.1 Хэрэв гүйцэтгэгч зөрчил гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил гологдлыг арилгахад шаардагдах зардлын хэмжээг тооцох ба гүйцэтгэгч үүнийг төлнө.

Д. Зардлын хяналт

46. Ажлын тоо хэмжээ 46.1 Нэгж үнийн гэрээг хэрэглэж байгаа тохиолдолд, ажлын тоо хэмжээ нь гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэх үнэлэгдсэн нэр төрлийн ажлаас бүрдэнэ. Гэрээний үнийг тооцож гаргахад ажлын тоо хэмжээг ашиглана. Ажлын тоо хэмжээнд тусгагдсан нэр төрөл бүрийн нэгж үнээр хийж гүйцэтгэсэн ажлын тоо ширхэгт үндэслэн гүйцэтгэгчид төлбөрийг хийж гүйцэтгэнэ.
- 46.2 Нийт үнийн гэрээг хэрэглэж байгаа тохиолдолд, үе шатны ажлын хуваарь нь гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэх ажлын үнэлэгдсэн үе шатны ажлаас бүрдэнэ. Үе шатны ажлын гүйцэтгэлийг хянаж шалгасны үндсэн дээр гүйцэтгэгчийн төлбөрийг хийх ба үе шатны ажлын гүйцэтгэлийг хянаж шалгахад үе шатны ажлын хуваарийг ашиглана. Хэрэв ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбай дахь материалын нийлүүлэлтийг үе шатны ажлын хуваарь дээр тусад нь гаргаж харуулна.
47. Ажлын тоо хэмжээг өөрчлөх 47.1 Нэгж үнийн гэрээг хэрэглэж байгаа тохиолдолд:
- (а) Хэрэв гүйцэтгэсэн ажлын эцсийн тоо хэмжээ нь ажлын тоо хэмжээнд тусгагдсан тухайн нэр төрлийн ажлын тоо хэмжээнээс 25-аас илүү хувиар зөрж, үүнээс шалтгаалсан өөрчлөлт нь гэрээний анхны үнээс 1 хувиар хэтэрвэл төслийн менежер энэхүү өөрчлөлтийн дагуу нэгж үнийг тохируулна.
 - (б) Хэрэв ажлын тоо хэмжээ өөрчлөгдсөний улмаас гэрээний анхны үнэ 15-аас илүү хувиар өсөхөөр бол захиалагч урьдчилан баталснаас бусад тохиолдолд төслийн менежер нэгж үнийг үл тохируулна.
 - (в) Гүйцэтгэгч нь ажлын тоо хэмжээнд тусгагдсан аливаа зардлын нэгж үнийн дэлгэрэнгүй задаргааг төслийн менежер шаардсаны дагуу гаргаж өгнө.
- 47.2 Нийт үнийн гэрээг хэрэглэж байгаа тохиолдолд, гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт ийм өөрчлөлт оруулахдаа үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
48. Өөрчлөлт 48.1 Бүх өөрчлөлтийг гүйцэтгэгчээс боловруулж тодотгосон хөтөлбөр, ажлын хуваарьт тусгана.
49. Өөрчлөлтийн төлбөр 49.1 Төслийн менежер шаардсан бол гүйцэтгэгч өөрчлөлтөөр хийгдэх ажлын үнийн саналыг түүнд гаргаж өгнө. Төслийн менежер үнийн саналыг авсанаас хойш 7 хоногийн дотор, эсхүл төслийн менежерийн



- тогтоосон, түүнээс урт хугацаанд болон өөрчлөлтийг батлахаас өмнө үнийн саналыг хянана.
- 49.2 Хэрэв төслийн менежер нь гүйцэтгэгчийн гаргасан үнийн саналыг үндэслэлгүй гэж үзвэл гүйцэтгэгчийн зардалд уг өөрчлөлт хэрхэн нөлөөлөх талаарх өөрийн тооцоонд үндэслэн гэрээний үнийг өөрчлөн, уг өөрчлөлтийг баталж болно.
- 49.3 Хэрэв төслийн менежер ажилд яаралтай өөрчлөлт оруулах, ажлыг хугацаа хоцроолгүй гүйцэтгэх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд гүйцэтгэгчээс үнийн санал авахгүйгээр, энэ өөрчлөлтийг нөхөн төлбөр хийх нөхцөл гэж үзнэ.
- 49.4 Гүйцэтгэгч урьдчилан анхааруулснаар гаргахгүй байх боломжтой байсан зардалд нэмэлт төлбөр нэхэмжлэх эрхгүй.
- 50. Бэлэн мөнгөний урсгалын урьдчилсан тооцоо**
- 50.1 Ажлын хөтөлбөрийг, эсхүл үе шатны ажлын хуваарийг тодотгосон тохиолдолд гүйцэтгэгч төслийн менежерт бэлэн мөнгөний урсгалын урьдчилсан тооцоог шинэчлэн гаргаж өгнө. Бэлэн мөнгөний урсгалын урьдчилсан тооцоог гэрээнд заасан мөнгөн тэмдэгтийн төрөл, ханшаар хийнэ.
- 51. Төлбөрийн мэдэгдэл**
- 51.1 Гүйцэтгэгч нь хийгдсэн ажлын гүйцэтгэлийн тайланг сар бүр төслийн менежерт гаргаж өгөх бөгөөд түүнд нэхэмжилсэн дүн нь нийт гарсан зардлаас, өмнө нь нэхэмжилсэн дүнг хассан хэмжээтэй байна.
- 51.2 Төслийн менежер гүйцэтгэгчийн ирүүлсэн сарын ажлын тайланг шалгаж, түүнд төлөх төлбөрийн дүнг тодорхойлж батална.
- 51.3 Гүйцэтгэсэн ажлын төлбөрт дараах зардлыг багтаана:
- (а) Нэгж үнийн гэрээг хэрэглэж байгаа тохиолдолд, ажлын тоо хэмжээнд заасан, бүрэн хийж гүйцэтгэсэн ажлын үнэ; эсвэл
 - (б) Нийт үнийн гэрээг хэрэглэж байгаа тохиолдолд, үе шатны ажлын хуваарьт заасан бүрэн хийж гүйцэтгэсэн ажлын үнэ.
- 51.4 Өмнөх төлбөрийн мэдэгдэлд хамрагдсан зардлыг дахин нэхэмжилсэн бол төслийн менежер түүнийг төлбөр хийх дүнгээс хасна.
- 52. Төлбөр**
- 52.1 Урьдчилгаа төлбөр ба барьцаа хөрөнгийг хасах замаар төлбөрийг өөрчлөнө. Захиалагч нь төслийн менежерийн баталсан дүнг ГТН-д заасан өдөрт багтаан гүйцэтгэгчид төлнө. Хэрэв захиалагч төлбөрийг хугацаанд нь хийгээгүй бол хугацаа хоцруулсан төлбөрт ногдох торгуулийг дараагийн төлбөр хийхдээ хамт төлнө. Торгуулийг төлбөрийн мөнгөн тэмдэгт тус бүрийн арилжааны зээлийн хүүгийн тухайн үеийн ханшийг баримтлан, төлбөр хийх ёстой өдрөөс төлбөрийг хийсэн өдөр хүртэлх хугацаанд тооцно.
- 52.2 Хэрэв сүүлд ирүүлсэн мэдэгдлээр, эсхүл маргаан таслагч буюу шүүхийн шийдвэрийн улмаас өмнөх мэдэгдэлд заагдсан дүн нэмэгдсэн бол хугацаа хоцорсон төлбөрт ногдох торгуулийг энэ зүйлд заасны дагуу гүйцэтгэгчид төлнө. Торгуулийг нэмэгдсэн дүнг маргаангүйгээр баталгаажуулсан өдрөөс эхэлж тооцно.
- 52.3 Гэрээнд өөрөөр заагаагүй бол, бүх төлбөр, суутгалыг гэрээний үнийг бүрдүүлэх мөнгөн тэмдэгтийн хувь хэмжээгээр тооцож төлөх буюу суутгана.



52.4 Нэгж болон нийт үнийг тусгаагүй ажлын нэр төрөлд захиалагч төлбөр хийхгүй бөгөөд тэдгээрийг гэрээнд заасан бусад нэгж болон нийт үнэд орсон гэж үзнэ.

53. Нөхөн төлбөр хийх нөхцөл

53.1 Дор дурдсан нөхцлүүд нь нөхөн төлбөр хийх нөхцөл болно:

- (a) Захиалагч ГЕН-ийн 27.1-д заасан ажлын талбайг ашиглуулах хугацаанд багтаж ажлын талбайн аль нэг хэсгийг ашиглах боломжийг гүйцэтгэгчид олгоогүй.
- (б) Захиалагч бусад гүйцэтгэгчийн гэрээний дагуу хийх ажилд нөлөөлөхүйц өөрчлөлтийг гүйцэтгэгчийн хуваарьт оруулсан.
- (в) Төслийн менежер ажлыг хойшлуулах шийдвэр гаргасан, эсхүл ажлыг хугацаанд нь гүйцэтгэхэд шаардагдах зураг, тодорхойлолт, зааварчилгаа зэргийг гаргаж өгөөгүй.
- (г) Төслийн менежер нь ажлын далд хэсгийг нээх, эсхүл нэмэлт шалгалт туршилт явуулах зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн ба үүгээр зөрчил гологдол илрээгүй бол.
- (д) Төслийн менежер нь ажлыг туслан гүйцэтгүүлэхийг үндэслэлгүйгээр батлаагүй.
- (e) Хөрсний нөхцөл нь тендерт оролцогчдод өгсөн мэдээлэл (ажлын талбайн судалгааны тайланг оролцуулан), нийтэд зарласан мэдээлэл болон ажлын талбайн хөрсний шинжилгээгээр гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл өгөхөөс өмнө төсөөлж байснаас ихээхэн зөрүүтэй байгаа.
- (ē) Төслийн менежер, захиалагчийн үйл ажиллагааны улмаас бий болсон урьдчилан таамаглах боломжгүй нөхцөл байдлыг арилгах, аюулгүй байдал, эсхүл бусад үндэслэлээр шаардагдсан нэмэлт ажил гүйцэтгэх талаар зааварчилгааг өгсөн.
- (ж) Бусад гүйцэтгэгч, засаг захиргаа, нийтийн аж ахуй, үйлчилгээний газар, эсхүл захиалагч нь гэрээнд заасан хугацаа, бусад нөхцлийн дагуу ажиллаагүйн улмаас гүйцэтгэгч нь хугацаа алдсан, эсхүл нэмэлт зардал гаргасан.
- (з) Урьдчилгаа төлбөрийг хугацаанд нь хийгээгүй.
- (и) Захиалагчийн аливаа эрсдэл нь гүйцэтгэгчид нөлөөлсөн.
- (k) Төслийн менежер нь ажил дууссан тухай мэдэгдлийг үндэслэлгүйгээр хугацаа хоцроож гаргасан.
- (л) гэрээнд заасан эсхүл төслийн менежерийн тодорхойлсон нөхөн төлбөр хийх бусад нөхцөлийг хэрэглэнэ.

53.2 Хэрэв нөхөн төлбөр хийх нөхцөл нь нэмэлт зардал гаргахад хүргэсэн, эсхүл ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс өмнө дуусгах ажлыг зогсоосон бол гэрээний үнийг өсгөх болон/эсхүл ажил дуусгахаар төлөвлөсөн өдрийг сунгана. Төслийн менежер нь гэрээний үнийг хэрхэн нэмэгдүүлэх, ажил дуусгахаар төлөвлөсөн өдрийг ямар хугацаагаар сунгах эсэх асуудлыг шийдвэртэнэ.



- 53.3 Гүйцэтгэгчийн төлөвлөсөн зардалд нөхөн төлбөр хийх нөхцөл хэрхэн нөлөөлж буйг харуулсан тооцоо мэдээллийг гүйцэтгэгчээс ирүүлсэн даруйд, төслийн менежер түүнийг үнэлж, гэрээний үнийг тохируулна. Хэрэв гүйцэтгэгчийн тооцоог үндэслэлгүй гэж үзвэл төслийн менежер өөрийн тооцоонд үндэслэн гэрээний үнийг тохируулна. Ингэхдээ гүйцэтгэгч уг нөхцөлд бүтээлч, шуурхай арга хэмжээ авна гэж тооцно.
- 53.4 Урьдчилан анхааруулаагүй, эсхүл төслийн менежертэй хамтран ажиллаагүйн улмаас захиалагчийн сонирхол хөндөгдсөн бол гүйцэтгэгчид нөхөн төлбөр төлөхгүй.
- 54. Татвар** 54.1 Хэрэв тендер ирүүлэхээс 28 хоногийн өмнөх өдрөөс ажил дууссан тухай сүүдчийн мэдэгдэл гаргасан өдрийн хооронд аливаа татвар, хураамж өөрчлөгдсөн бол төслийн менежер гэрээний үнийг тохируулна. Гүйцэтгэгчийн төлөх татварын зөрүүгээр хийгдэх энэхүү тохируулга нь гэрээний үнэд өмнө нь тусгагдаагүй, эсхүл ГЕН-ийн 56.1 дэх заалтанд хамаараагүй байна.
- 55. Мөнгөн тэмдэгт** 55.1 Төлбөрийг монгол төгрөгөөр хийнэ.
- 56. Үнийн тохируулга** 56.1 Зөвхөн ГТН-д заасан нөхцөлд ажлын орцын зардлын өсөлтийг тусгах зорилгоор үнийн тохируулга хийнэ. Тохируулгыг хэрэглэхдээ төлбөрийн мэдэгдлийн нийт дүнгээс урьдчилгаа төлбөрийг хассан дүнгийн төлбөр хийх гэрээний мөнгөн тэмдэгт тус бүрт хэрэглэх дор дурдсан томъёог ашиглана.

$$P_c = A_c + B_c \times Im_c / Io_c$$

үүнд:

P_c - гэрээний үнийн "с" мөнгөн тэмдэгтээр төлөгдөх хэсэгт хийх үнийн тохируулгын үзүүлэлт.

A_c ба B_c - гэрээний үнийн "с" мөнгөн тэмдэгтээр төлөгдөх хэсгийн үл тохируулах болон тохируулах хувийн жинг үзүүлэх, ГТН-д заасан итгэлцүүр⁹;

Im_c - нэхэмжилж буй сарын эцсийн өдрийн, "с" мөнгөн тэмдэгтийн индекс;

Io_c - тендерийг нээх өдрийн, "с" мөнгөн тэмдэгтийн индекс

- 56.2 Хэрэв индексийн дүн нь түүнийг тооцоонд ашигласнаас хойш өөрчлөгдсөн бол тооцоог залруулж, дараагийн төлбөрийн мэдэгдэлд тохируулга хийнэ. Индексийн дүнг тооцохдоо үнийн өсөлтийн улмаас гарсан зардлын бүх өөрчлөлтийг энд харгалзсан гэж үзнэ.
- 57. Барьцаа мөнгө** 57.1 Захиалагчийн гүйцэтгэгчид шилжүүлэх төлбөр тутмаас ГТН-д заасан тодорхой хувийг¹⁰ нийт ажлыг дуусгах хүртэл хугацаанд барьцаалж үлдээнэ.
- 57.2 Ажлыг дуусгасан тухай мэдэгдлийг гаргаснаар, барьцаалсан үнийн дүнгийн 50 хувийг гүйцэтгэгчид буцаан төлөх бөгөөд үлдсэн хэсгийг чанарын баталгаат хугацаа дууссаны дараа, энэ хугацаа дуусахаас

⁹ A_c ба B_c – гэсэн хоёр итгэлцүүрийн нийлбэр нь мөнгөн тэмдэгт бүрийн томъёонд 1 (нэг) байна. Энэ хоёр итгэлцүүр нь ихэвчлэн ихэнх мөнгөн тэмдэгтийн хувьд ижил байдаг. Төлбөрийн үл тохируулах хэсгийн A_c итгэлцүүр нь тогтмол өртөг зардал болон бусад үл тохируулах элементийг тусгасан тоо хэмжээ (ихэвчлэн 0.15) болно. Мөнгөн тэмдэгт бүрийн тохируулгын дүнг гэрээний үнэд нэмнэ.

¹⁰ Барьцаа хөрөнгийн дүн 5 орчим хувь байх бөгөөд ямар ч тохиолдолд 10 хувиас хэтрэх бөгүй.



өмнө бүх зөрчил гологдлыг арилгасан тухай төслийн менежерээс гүйцэтгэгчид явуулсан мэдэгдлийг үндэслэн төлнө.

57.3 Нийт ажлыг бүрэн гүйцэтгэж дуусмагц, гүйцэтгэгч барьцаа мөнгийг “шаардсан даруйд олгох” нөхцөлтэй банкны батлан даалгаар сольж өгнө.

58. Алданги

58.1 Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон өдөр тутамд ГТН-д заасан хувь хэмжээгээр алданги¹¹ төлнө. Алдангийн нийт дүн ГТН-д заасан хэмжээнээс хэтэрч үл болно. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алдангийн төлбөр нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагад үл нөлөөлнө.

58.2 Хэрэв алданги төлснөөс хойш ажил дуусгахаар төлөвлөсөн өдрийг сунгасан бол төслийн менежер гүйцэтгэгчийн илүү төлсөн алдангийг дараагийн төлбөрийн мэдэгдэлд тооцох замаар залруулна. Илүү төлсөн алдангид алдангийн төлбөр хийсэн өдрөөс алдангийг буцаан төлсөн өдөр хүртэлх хугацааны хүүг ГЕН-ийн 52.1-д заасан хувиар тооцож гүйцэтгэгчид төлнө.

59. Урамшуулал

59.1 Ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс өмнө дууссан хоног тутамд (ажил хурдасгасны төлөө гүйцэтгэгчид төлбөр төлсөн өдрийг хасч) ГТН-д хуанлийн өдрөөр тооцож заасан хувь хэмжээгээр гүйцэтгэгчид урамшуулал¹² олгоно. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр болоогүй боловч гүйцэтгэгч ажлыг бүрэн дуусгасан бол төслийн менежер энэ тухай мэдэгдэл гаргана.

60. Урьдчилгаа төлбөр

60.1 Захиалагч ГТН-д заасан дүнтэй урьдчилгаа төлбөрийг ГТН-д заасан хугацаанд гүйцэтгэгчид төлөх ба ингэхдээ урьдчилгаа төлбөрийн дүнтэй тэнцүү, ижил мөнгөн тэмдэгтэй, шаардсан маягтыг ашиглан, захиалагчийн хүлээн зөвшөөрөхүйц банкнаас үл маргах нөхцөлтэйгээр гаргасан банкны батлан даалтыг үндэслэнэ. Гэхдээ энэ батлан даалтын дүн нь гүйцэтгэгчийн эргэж төлөгдсөн урьдчилгаа төлбөрийн хэмжээгээр буурч байх ёстой. Урьдчилгаа төлбөрт хүүг тооцож ногдуулахгүй.

60.2 Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөрийг зөвхөн гэрээг гүйцэтгэхэд шаардагдах тоног төхөөрөмж, байгууламж, материал болон ажил эхлүүлэхтэй холбогдсон зардалд зарцуулна. Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөрийг энэ зорилгод ашигласныг нотлохын тулд нэхэмжлэх болон бусад баримтын хувийг төслийн менежерт ирүүлнэ.

60.3 Урьдчилгаа төлбөр нь хийгдсэн үе шатны ажлын дагуу гүйцэтгэгчид төлөх төлбөрийн хэмжээнээс холбогдох дүнг суутгах замаар эргэж төлөгдөнө. Хийгдсэн ажлын үнэ, өөрчлөлт, үнийн тохируулга, нөхөн төлбөр хийх нөхцөл, урамшуулал болон алдангийн дүнг тооцохдоо урьдчилгаа төлбөр, эсхүл түүний эргэж төлөгдсөн байдлыг харгалзахгүй.

61. Гүйцэтгэлийн баталгаа

61.1 Гүйцэтгэлийн баталгааг гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэлд заасан хугацаанаас хоцроолгүйгээр гаргах бөгөөд, ГТН-д заасан дүн, маягт, захиалагчийн хүлээн зөвшөөрөх банкаар, төлөгдөх гэрээний үнийн мөнгөн тэмдэгтээр гарган, захиалагчид ирүүлнэ. Гүйцэтгэлийн

¹¹ Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5 ба 10 хувийн хооронд байх ба түүнээс хэтрэх ёсгүй.

¹² Ажлыг дуусгахаар төлөвлөсөн өдрөөс өмнө дуусгах нь захиалагчид ашигтай бол энэ заалтыг үлдээх ба бусад нөхцөлд буюу ихэнх тохиолдолд хасна. Урамшууллын хэмжээ нь ихэвчлэн алдангийн хэмжээтэй ижил байна.



баталгаа нь ажил дууссан тухай мэдэгдэл гарсан өдрөөс хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

62. Өдөр-ажил

- 62.1 Зөвхөн төслийн менежер нэмэлт ажилд зориулан урьдчилан бичгээр заавар гаргасан тохиолдолд, гүйцэтгэгчийн тендерт дурдсан өдөр-ажлын нэгж үнийг жижиг нэмэлт ажилд, шаардлагатай бол ашиглаж тооцно.
- 62.2 Гүйцэтгэгч өдөр-ажил хэмээн төлөгдөх бүх ажлын талаар төслийн менежерийн баталсан маягтын дагуу тэмдэглэл хөтөлнө. Бөглөсөн маягт бүрийг төслийн менежер ажил гүйцэтгэснээс хойш 2 хоногийн дотор шалгаж батална.
- 62.3 Гарын үсэг зурагдсан өдөр-ажлын маягтын дагуу гүйцэтгэгчид төлбөрийг хийнэ.

63. Засварын зардал

- 63.1 Ажил эхлэх өдрөөс чанарын баталгаат хугаанаа дуусах хүртэл хугацаанд гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас, эсхүл дутуу орхисноос үүдэн гарсан гэрээний ажилтай холбоотой ажил боловч материалд учирсан алдагдал, эвдрэл гэмтлийг гүйцэтгэгч өөрийн зардлаар засварлана.

Е. Давагдашгүй хүчин зүйл

64. Давагдашгүй хүчин зүйлийн тодорхойлолт

- 64.1 Энэ зүйлд “давагдашгүй хүчин зүйл” гэдэгт дараах шинж бүхий онцлог үйл явдал буюу нөхцөл байдлыг хамруулан ойлгоно:

(а) Талуудын хяналтаас гадуур шинжтэй байсан,

(б) Тухайн тал гэрээ байгуулахаас өмнө зохих ёсоор урьдчилан бэлтгэх боломжгүй байсан,

(в) Тухайн хүчин зүйл нэгэнт бий болсон үед тухайн тал түүнээс зохих ёсоор зайлсхийх эсхүл даван туулах боломжгүй байсан,

(г) Нөгөө талаас хамааралтай бус байсан.

- 64.2 Давагдашгүй хүчин зүйлээд дээрх (а)-(г) хэсэгт дурдсан шинжийг хангасан тохиолдолд дор дурдсан онцгой үйл явдал буюу нөхцөл байдлууд хамаарч болох бөгөөд зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй:

(а) Дайн, байлдаан (дайн зарлагдсан, эсвэл зарлагдаагүй ч), халдлага, гадаадын дайсагнасан үйл ажиллагаа,

(б) Бослого, алан хядлага, гүйцэтгэгчийн ажилтнаас бусад этгээдийн хийсэн саад хориг, хувьсгал, эсэргүү бослого, цэрэг зэвсгийн эсхүл будаан эзлэх түрэмгийлэл, эсхүл иргэний дайн,

(в) Гүйцэтгэгчийн ажилтнаас бусад этгээдээс гаргасан хэв журмын зөрчил, үймээн самуун, эмх замбараагүй байдал, ажил хаялт эсхүл ажлын байрыг түр хлаах ажиллагаа,

(г) Гүйцэтгэгч зэр зэвсэг, тэсрэх бодис, цацраг туяа эсхүл цацраг идэвхт бодисыг хэрэглэснээс бусад тохиолдолд дайны зэр зэвсэг, тэсрэх бодис, цахилгаан цэнэгт цацраг туяа эсхүл идэвхт бодисоос үүсэх хор нөлөө,

(д) Газар хөдлөлт, хар салхи, далайн салхи эсхүл галт уулын идэвхжил гэх зэрэг байгалийн онц аюултай үзэгдлүүд.



- 65. Давагдашгүй хүчин зүйлийг мэдэгдэх**
- 65.1 Хэрэв аль нэг тал гэрээгээр хүлээсэн үндсэн үүргээ давагдашгүй хүчин зүйлийн улмаас биелүүлж чадахгүй болсон эсвэл чадахгүй болох бол нөгөө талдаа давагдашгүй хүчний шинжтэй үйл явдал, нөхцөл байдлыг мэдэгдэж, гүйцэтгэх боломжгүй болсон эсвэл боломжгүй болох үүрэгт ажил буюу үүргийн гүйцэтгэлийг тодорхойлон заана. Тухайн давагдашгүй хүчний шинжтэй үйл явдал буюу нөхцөл байдал үүссэн талаар тухайн тал мэдсэнээс эсхүл мэдвэл зохих ёстой байсан хугацаанаас хойш 14 хоногт багтаан мэдэгдлийг хүргүүлднэ.
- 65.2 Тухайн тал давагдашгүй хүчин зүйлийн улмаас үүргээ гүйцэтгэх чадахгүй болсон бол мэдэгдэл хүргүүлснээрээ уг үүрэгт ажлыг гүйцэтгэхээс чөлөөлөгдөнө.
- 65.3 Энэхүү заалтын бусад хэсгээс үл хамааран, давагдашгүй хүчин зүйлийг аль нэг тал гэрээний дагуу нөгөө талд төлөх төлбөрийн үүрэгт үл хэрэглэнэ.
- 66. Ажил хоцролтыг багасгах үүрэг**
- 66.1 Талууд давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээг хэрэгжүүлэхэд үүсэх аливаа ажил хоцролтыг багасгахын тулд зохих арга хэмжээг цаг тутам авч ажиллах ёстой.
- 66.2 Аль нэг тал нөгөө талдаа давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс ангижирсан талаар мэдэгдэл өгнө.
- 67. Давагдашгүй хүчин зүйлийн үр дагавар**
- 67.1 Хэрэв гүйцэтгэгч давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээний үндсэн үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болж, энэ тухай ГЕН-ийн 65 дугаар зүйлийн дагуу мэдэгдэн, гэрхүү давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалан ажил хоцрох болон/эсхүл зардал гарсан тохиолдолд гүйцэтгэгч нь ГЕН-ийн 31 дүгээр зүйлийн хүрээнд дараах эрхийг эдэлнэ:
- (а) Хэрэв ажил дуусгах хугацаа хоцорсон эсхүл хоцрохоор байгаа бол ГЕН-ийн 37 дугаар зүйлийн дагуу хоцорсон хугацааг сунгах,
- (б) Хэрэв тухайн үйл явдал буюу нөхцөл байдал нь ГЕН-ийн 64.2 дугаар зүйлд тодорхойлсон төрөл, шинж бүхий бөгөөд (б)-(г) заалтад дурдсаны дагуу тухайн улсад тохиолдсон бол, давагдашгүй хүчин зүйлийн улмаас эвдэрч гэмтсэн бөгөөд ГЕН-ийн 19 дүгээр зүйлд тусгасан даатгалд хамрагдаагүй ажил болон/эсхүл барааг засч сайжруулах эсхүл сольж өөрчлөхтэй холбогдон гарсан зардлыг төлүүлэх.
- 67.2 Төслийн менежер энэ мэдэгдлийг хүлээн авмагц, ГЕН-ийн 10 дугаар зүйлийн дагуу эдгээр асуудлыг хүлээн зөвшөөрөх эсхүл шийдвэрлэх талаар арга хэмжээ авна.
- 68. Давагдашгүй хүчин зүйл туслан гүйцэтгэгчид нөлөөлөх**
- 68.1 Хэрэв аль нэг туслан гүйцэтгэгч нь энэхүү заалтад тодорхойлсноос өөр нэмэлт эсхүл илүү өргөн нөхцөл бүхий давагдашгүй хүчин зүйлээс чөлөөлөгдөх ажилтай хамааралтай ямарваа нэг гэрээ, хэлцлийн дагуу эрх эдлэхээр байгаа бол нийм нэмэлт эсхүл илүү өргөн нөхцөлтэй давагдашгүй хүчин зүйлийн үйл явдал буюу нөхцөл байдал нь гүйцэтгэгчийг гэрээний үүргээ хэрэгжүүлэхгүй байх үндэслэл болохгүй буюу түүнд энэхүү заалтын хүрээнд үүргээс чөлөөлөгдөх эрхийг олгохгүй.
- 69. Сайн дураар гэрээ цуцлах, төлбөр төлөх, үүргээс чөлөөлөх**
- 69.1 Хэрэв нийт хэрэгжиж буй ажлын гүйцэтгэл бүхэлдээ ГЕН-ийн 65 дугаар зүйлийн дагуу мэдэгдэл хийсэн гэрхүү давагдашгүй хүчин зүйлийн нөлөөгөөр тасралтгүй 84 өдрийн турш эсхүл тэрхүү мэдэгдэл хийсэн давагдашгүй хүчин зүйлийн улмаас нийтдээ 140-өөс дээш өдөр бүхий удаан хугацааны туршид саатсан бол аль нэг тал нь нөгөө талдаа гэрээ цуцлах мэдэгдэл хүргүүлж болно. Энэ тохиолдолд уг мэдэгдлийг



хүргүүлснээс хойш 7 өдрийн дараа гэрээг цуцлах ба гүйцэтгэгч ГЕН-ийн 75 дугаар зүйлийн дагуу дараагийн арга хэмжээг авна.

69.2 Ийнхүү гэрээг цуцалмагц, төслийн менежер хийгдсэн ажлын үнэлгээг тогтоож, дараах мэдээг агуулсан төлбөрийн мэдэгдлийг олгоно:

(а) Үнийн дүн нь гэрээнд тусгагдаж, гүйцэтгэл хийгдсэн аливаа ажилд төлбөл зохих мөнгөн дүн;

(б) Гүйцэтгэгч ажлын зориулалтаар захиалж ирүүлсэн эсхүл хүлээн авах байгууламж ба материалын зардал. Эдгээр байгууламж, материал нь захиалагч төлбөрийг хийсэн даруйд захиалагчийн өмчлөл (мөн эрсдэл)-д хамаарах бөгөөд гүйцэтгэгч тэдгээрийг захиалагчийн захиран зарцуулах эрхэд шилжүүлнэ;

(в) Гүйцэтгэгч ажлыг дуусгах үүднээс тухайн үүссэн нөхцөл байдлын хүрээнд зохих ба зайлшгүй шаардлагын дагуу гаргасан бусад зардал, өр төлбөрүүд;

(г) Ажлын талбайгаас туслах ажил болон гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжийг зайлуулан гаргах, мөн эдгээр зүйлийг өөрийн орон руу (эсхүл үүнээс илүүгүй зардлаар өөр бусад газарт) гүйцэтгэгчийн ажилд шилжүүлэн буцаахтай холбогдон гарах зардлууд;

(д) Гэрээ цуцлах өдөр гаргах үү гүйцэтгэгчийн ажилтай холбоотойгоор хөлслө ажиллуулсан ажилтан, ажилчдыг эх оронд нь буцаах зардал.

70. Гүйцэтгэлээс чөлөөлөх

70.1 Энэхүү заалтын аль нэг хэсэгт хэрхэн зохицуулагдсанаас үл хамааран, талуудын хяналтаас гадуур ямарваа нэг үйл явдал буюу нөхцөл байдал (давагдашгүй хүчин зүйлийг оруулан, гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй) үүсч бий болсон, ингэснээр аль нэг эсхүл хоёр талыг өөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болгосон эсхүл тийнхүү үүргээ гүйцэтгэх нь хуульд үл нийцэхэд хүргэсэн, эсхүл, аль нэг талын нөгөө талд уг үйл явдал буюу нөхцөл байдлын талаар мэдэгдсэнээр гэрээнд мөрдөх хуулийн дагуу талуудыг гэрээний цаашдын гүйцэтгэлээс чөлөөлөгдөхөд хүргэсэн тохиолдолд:

(а) урьд өмнө нь гаргасан гэрээний зөрчилтэй холбоотойгоор нөгөө талын эрхэд халдангүйгээр талууд цаашдын үүргийн гүйцэтгэлээс чөлөөгдөх; ба

(б) тухайн гэрээ ГЕН-ийн 69 дүгээр зүйлийн дагуу цуцлагдах тохиолдолд захиалагчаас гүйцэтгэгчид төлбөл зохих мөнгөн дүн нь уг 69 дүгээр зүйлийн дагуу төлбөл зохих мөнгөн дүнтэй тэнцүү байна.

Ё. Гэрээг дуусгах

71. Ажил дуусгах

71.1 Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Барилга угсралтын ажлыг бүрэн гүйцэтгэсэн даруйдаа гүйцэтгэгч зам, орон нутгийн бусад дэд бүтэц, эдэлбэр газар зэргийг хамгийн багадаа гэхэд төсөл эхлүүлэхээс өмнөх нөхцөл байдалд байсан хэмжээнд бүрэн сэргээнэ.

72. Хүлээж авах

72.1 Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш долоо хоногийн дотор захиалагч ажлын талбай болон ажлыг хүлээж авна.

73. Эцсийн төлбөр

73.1 Гүйцэтгэгч чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог



төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв дээрх тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг уг тооцоог хүлээн авснаас хойш 28 хоногийн дотор баталгаажуулна. Хэрэв тооцоо буруу бол төслийн менежер шаардлагатай залруулга, нэмэлт, өөрчлөлтийн талаарх хуваарийг 28 хоногийн дотор гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.

**74. Ашиглалт,
засвар
үйлчилгээний
гарын авлага**

74.1 Ажлын “гүйцэтгэлийн” зураг болон/эсвэл ашиглалтын ба засвар үйлчилгээний гарын авлага шаардлагатай бол гүйцэтгэгч тэдгээрийг ГТН-д заасан хугацаанд багтаан хүлээлгэн өгнө.

74.2 Хэрэв гүйцэтгэгч ГЕН-ийн 74.1-д дурдсан зураг болон/эсвэл гарын авлагыг ГТН-д заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс ГТН-д заасан үнийн дүнг суутгана.

75. Гэрээг цуцлах

75.1 Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.

75.2 Доор дурдсан нөхцлийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй:

(а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 хоногоор зогсоосон;

(б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;

(в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад шалтгаанаар татан буугдсан;

(г) захиалагч төслийн менежерийн гаргасан төлбөрийн мэдэгдлийн дагуу төлөх төлбөрийг уг мэдэгдлийг гаргасан өдрөөс хойш 60 хоногийн дотор төлөөгүй;

(д) тодорхой зөрчил гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;

(е) гүйцэтгэгч захиалагчийн шаардсан баталгааг хангаагүй;

(ё) гүйцэтгэгч ажил дуусгах хугацааг хэдэн өдрөөр хоцроосон ба хоцроосон хугацаанд ГТН-д заасан алдангийн дээд хэмжээг төлөх;

(ж) захиалагчийн үзэж байгаагаар гүйцэтгэгч нь ГЕН-ийн 76-р зүйлд заасны дагуу гэрээ байгуулах эрхийг олж авахаар өрсөлдөх эсхүл гэрээг хэрэгжүүлэх явцдаа авлига эсхүл залилан мэхлэх үйлдэлд холбогдсон.

75.3 Хэрэв гэрээний аль нэг тал нь ГЕН-ийн 75.2-г зааснаас өөр шалтгааны улмаас гэрээг ноцтой зөрчсөн тухай мэдэгдлийг төслийн менежер



өгсөн бол төслийн менежер энэ нь ноцтой зөрчил мөн эсэхийг шийдвэрлэнэ.

75.4 Захиалагч шаардлагатай тохиолдолд дээр дурьдсанаас үл хамааран гэрээг цуцлах эрхтэй.

75.5 Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг нэн даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, ажлын талбайг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.

76. Залилсан ба авлига

76.1 АХБ-ны авлигын эсрэг бодлого (1998, цаашид нэмж өөрчлөх) нь зээлдэгч (түүний дотор АХБ-ны санхүүжилттэй үйл ажиллагааны үр шим хүртэгч) төдийгүй АХБ-ны санхүүжилттэй гэрээний гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч, үйлдвэрлэгч болон зөвлөхөөс худалдан авах ажиллагаа болон гэрээний хэрэгжилтийн явцад ёс зүйн өндөр хэм хэмжээг баримтлахыг шаарддаг. Энэ бодлогыг мөрдлөг болгох үүднээс АХБ нь:

(a) Энэхүү заалтын хүрээнд дор дурдсан нэр томъёог дараах байдлаар тодорхойлно:

- (i) “авлигын үйлдэл” гэдэг нь бусад талын үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөхийн тулд ямар нэг үнэ цэнэтэй зүйлийг шууд буюу шууд бусаар санал болгох, өгөх, авах, эсхүл хүсэхийг;
- (ii) “залилсан мэхлэх үйлдэл” гэдэг нь санхүүгийн болон бусад үр шим хүртэх эсвэл үүрэг хариуцлагаас мултрах зорилгоор аливаа талыг санаатайгаар буюу санамсаргүйгээр төөрөгдүүлэх, эсвэл төөрөгдүүлэхийг оролдсон аливаа үйлдэл хийх, баримтыг орхигдуулах, худал мэдүүлэхийг;
- (iii) “дарамт шахалт үзүүлэх үйлдэл” гэдэг нь аливаа талын үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөхийн тулд аливаа талд буюу түүний өмч хөрөнгөнд шууд эсвэл шууд бусаар хохирол учруулах, эсвэл хохирол учруулахаар заналхийлэхийг;
- (iv) “үгсэн хуйвалдах үйлдэл” гэдэг нь хоёр буюу түүнээс дээш талууд зүй бус зорилгод хүрэх, түүний дотор бусад талын үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөх зорилгоор хоорондоо тохиролцоо хийхийг;
- (v) “шамшигдуулах үйлдэл” гэж АХБ-ны холбогдох үйл ажиллагаанд зориулсан хөрөнгийг санаатайгаар эсвэл болгоомжгүй байдлаар худгайлах, үрэгдүүлэх болон зүй бусаар ашиглахыг;
- (vi) “сонирхлын зөрчил” гэж нэг тал нь нөгөө талын албан үүргээ гүйцэтгэх, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх эсхүл холбогдох хууль тогтоомжийг мөрдөх явцад нь зүй бусаар нөлөөлөх сонирхол бүхий аливаа нөхцөл байдлыг;
- (vii) “саад учруулах” гэж нь (a) АХБ-ны шалгалтад нотолгоо болох баримт бичгийг санаатайгаар устгах, хуурамчаар үйлдэх, өөрчлөх буюу нуун дарагдуулах, АХБ-ны шалгалтад саад учруулах үүднээс шалгагч нарт худал мэдүүлэг өгөх; (б) шалгалттай холбоотой асуудлаар мэдээллийг тараахгүй байлгах, түүнчлэн шалгалтыг явуулахгүй байх зорилгоор бусдыг айлган сүрдүүлэх, заналхийлэх, дарамт шахалт үзүүлэх; (в) АХБ-ны



аудитын гэрээний эрхийг хэрэгжүүлэх эсвэл мэдээлэл олж авахад их хэмжээгээр саад учруулахыг;

(viii) "шударга байдлын зөрчил" гэдэг нь АХБ-ны Шударга байдлын зарчим ба журамд тодорхойлсноор, (i)-ээс (vii)-д дээр дурдсан үйлдэл, түүнчлэн АХБ-ны хориг арга хэмжээг зөрчих, хэв журам сахиулагч эсхүл гэрчийн эсрэг сөрөг ажиллагаа явуулах, ёс зүйн дээд хэм хэмжээг үл баримтлах гэх мэтээр АХБ-ны Авлигын эсрэг бодлогыг зөрчихийг тус тус хэлнэ.

- (б) гэрээний эрх олгохоор санал болгосон тендерт оролцогч нь гэрээний эрхийн төлөө өрсөлдөх явцдаа шууд өөрөө эсвэл төлөөлөгчөөр дамжуулан авлига авах, залилан мэхлэх, дарамт шахалт үзүүлэх, үгсэн хуйвалдах эсвэл саад учруулах эсвэл бусад шударга байдлыг зөрчих зэрэг үйлдэлд оролцсон болох нь тогтоогдвол гэрээний эрх олгох саналаас татгалзана;
- (в) АХБ-наас санхүүжилт авсан зээлдэгчийн эсвэл АХБ-ны санхүүжилтээс үр шим хүртэгчийн төлөөлөгч нь худалдан авах ажиллагаа, эсвэл гэрээг хэрэгжүүлэх явцад авлига авах, залилан мэхлэх, дарамт шахалт үзүүлэх, үгсэн хуйвалдах эсвэл саад учруулах эсвэл бусад шударга байдлыг зөрчих зэрэг үйлдэлд оролцсон, мөн зээлдэгч энэ байдлыг арилгах талаар АХБ-ны шаардлагад нийцэхүйц зохистой арга хэмжээг цаг тухайд нь аваагүй болох нь хэзээ нэгэн цагт тогтоогдвол тухайн гэрээнд хуваарилсан санхүүжилтийн хэсгийг цуцална;
- (г) хэрэв компани ба хувь хүн шууд өөрөө эсвэл төлөөлөгчөөр дамжуулан авлига авах, залилан мэхлэх, дарамт шахалт үзүүлэх, үгсэн хуйвалдах эсвэл саад учруулах эсвэл бусад шударга байдлыг зөрчих зэрэг үйлдэлд оролцсон болох нь тогтоогдвол, тодорхой эсхүл тодорхойгүй хугацаагаар АХБ-наас санхүүждэг, захиран зарцуулдаг эсвэл дэмжлэгтэй арга хэмжээнд оролцох, эсвэл АХБ-наас санхүүждэг, захиран зарцуулдаг эсвэл дэмжлэгтэй гэрээнээс санхүүгийн болон бусад хэлбэрээр үр шим хүргэх эрхгүй болохыг зарлах гэх мэтээр АХБ-ны Авлигын эсрэг бодлого, Шударга байдлын зарчим ба журмын дагуу компани, хувь хүнд зөрчлийг арилгах арга хэмжээг хэдийд ч авч хэрэгжүүлнэ.

76.2 АХБ-тай холбогдол бүхий үйл ажиллагаанд оролцож буй бүх тендерт оролцогч, зөвлөх, гүйцэтгэгч, нийлүүлэгч эсвэл бусад гуравдагч тал нь АХБ-наас шаардсан тохиолдолд аливаа эрэн сурвалжлах хяналт шалгалтын үед бүрэн хэмжээнд хамтран ажиллах үүрэгтэй байна. Уг хамтын ажиллагаа нь дараах хэлбэрээр байх ба мөн үүгээр үл хязгаарлагдана. Тухайлбал:

- (а) ярилцлага хийхэд биечлэн оролцох, асуусан бүх асуултад үнэн зөв, бүрэн гүйцэд хариулт өгөх;
- (б) тухайн этгээдийн хяналтанд байгаа бичиг баримт, биет зүйлс зэргийг АХБ-ны хүсэлтээр гаргаж өгөх, мөн үүгээр үл хязгаарлагдана;
- (в) АХБ-наас бичгээр гаргасан хүсэлтийн дагуу эрэн сурвалжлах ажиллагаатай холбогдуулан тухайн байгууллага эсхүл асуудалд шууд ба шууд бусаар хамаарах онц ач холбогдол бүхий мэдээллийг шууд АХБ-д гаргаж өгөхийг бусад холбогдох байгууллагад зөвшөөрөх;
- (г) өөрийн ажилтан, ажлын талбараас гадна файл, цахим өгөгдлийн сан болон АХБ-ны үйл ажиллагаанд зориулан ашигласан, эсхүл (гар утас, хувийн цахим төхөөрөмж болон нэмэлт хагуу диск



буюу сахим мэдээллийн хадгалалт хийх төхөөрөмж зэрэг) АХБ-ны Мэдээлэл Харилцааны Технологи (МХТ)-ийн эх үүсвэр болон системийг ашиглаж буй хувийн өмчийг эрэл хайгуул хийх болон биечлэн шалгалт явуулахтай холбогдсон бүхий л хүсэлтийн хүрээнд хамтран ажиллах;

- (д) АХБ-наас шаардсан аливаа сорил туршилтыг өгөх, тухайлбал, хурууны хээ таниулах, бичгийн хэв тогтоох шинжилгээ өгөх, бист үзлэг болон нарийн шинжилгээ өгөх ба үүгээр үл хязгаарлагдана;
- (е) АХБ-аас шаардсаны дагуу хэлэлцсэн бүх мэдээллийг хадгалж түүний нууцлалтыг чандлан хамгаална.

76.3 Бүх тендерт оролцогч, зөвлөх, гүйцэтгэгч, нийлүүлэгч нар нь АХБ-тай холбогдол бүхий үйл ажиллагааны хүрээнд туслан гүйцэтгэгч болон гуравдагч талтай байгуулж буй хамтран ажиллах гэрээнд уг туслан гүйцэтгэгч, гуравдагч тал нь АХБ-наас шаардсан тохиолдолд аливаа эрэн сурвалжлах хяналт шалгалтын үед дээр дурдсан үүргийг нэгэн адил хэрэгжүүлж бүрэн хэмжээнд хамтран ажиллах үүрэгтэй байхыг баталгаажуулна.

77. Гэрээг цуцлахад хийх төлбөр

77.1 Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл төлөгдсөн урьдчилгаа төлбөр болон дуусаагүй ажлын ГТН-д заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Гүйцэтгэгчид нэмэлт алданги ногдуулахгүй. Хэрэв захиалагчид төлөх төлбөрийн нийт дүн гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс хэтэрвэл, хэтэрсэн дүн нь гүйцэтгэгчээс захиалагчид төлөх ёстой өр болно.

77.2 Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл захиалагч гэрээг ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, зөвхөн ажлын зорилгоор хөлслөн ажилдуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдон гарах гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл гаргасан өдөр хүртэл төлөгдсөн урьдчилгаа төлбөрийг эдгээр зардлаас хасна.

78. Өмч

78.1 Гүйцэтгэгчийн буруугаас шалтгаалж гэрээ цуцлагдсан бол захиалагчаас үнийг нь төлсөн, ажлын талбай дээрх бүх материал, байгууламж, тоног төхөөрөмж, туслах ажил болон ажлыг захиалагчийн өмч гэж үзнэ.

79. Гүйцэтгэлээс чөлөөлөх

79.1 Давагданшгүй хүчин зүйлийн нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй байдал үүссэн бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн аюулгүй байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

80. АХБ-ны зээлийг зогсоох

80.1 АХБ захиалагчид олгосон зээлээ зогсоосон бөгөөд түүнээс гүйцэтгэгчид төлбөр хийгдэх тохиолдолд:

- (а) Захиалагч АХБ-наас зогсоох тухай мэдэгдэл хүлээн авсанаас хойш 7 хоногийн дотор уг мэдэгдлийн талаар гүйцэтгэгчид



мэдэгдэж, төслийн менежерт мэдэгдлийн хуулбар хувийг өгөх үүрэг хүлээнэ.

- (б) Хэрэв гүйцэтгэгч үүнтэй холбогдуулан ГЕН-ийн 52.1-д заасны дагуу хийгдэх төлбөрийг 28 хоногийн дотор хүлээж аваагүй бол гэрээ цуцлах тухай 14 хоногийн мэдэгдлийг нэн даруй гаргаж болно.

81. Эрх бүхий нөхцөл

- 81.1 Гүйцэтгэгч нь тендерийн баримт бичгийн 5 дугаар бүлэг (Эрх бүхий орнууд)-г заасан эрх бүхий улсын харьяалалтай байна. Хэрэв гүйцэтгэгч аль нэг улсын иргэн эсхүл уг улсын хуулийн дагуу үүсэн байгуулагдсан буюу нэгтгэгдсэн эсхүл үйл ажиллагаа явуулдаг бол түүнийг уг улсын харьяалалтай гэж үзнэ. Энэ шалгуурыг гэрээний аль нэг хэсгийг дагалдах үйлчилгээний хамт гүйцэтгүүлэхээр санал болгосон туслан гүйцэтгэгч эсхүл нийлүүлэгчийн харьяаллыг тодорхойлоход мөн адил хэрэглэнэ.
- 81.2 Гэрээний хүрээнд нийлүүлэх материал, тоног төхөөрөмж болон үйлчилгээ нь тендерийн баримт бичгийн 5 дугаар бүлэг (Эрх бүхий орнууд)-г заасан эрх бүхий орны гарал үүсэлтэй байх ба гэрээний дагуу гарах бүх зардал нь эдгээр материал, тоног төхөөрөмж болон үйлчилгээгээр хязгаарлагдана. Захиалагч нь гэрээлэгчээс материал, тоног төхөөрөмж болон үйлчилгээний гарал үүслийн нотолгоог гаргаж өгөхийг шаардаж болно.
- 81.3 ГЕН-ийн 81.2-г дурдсан “гарал үүсэл” гэдэг нь тухайн материал болон тоног төхөөрөмжийг олборлосон, ургуулсан, хийж бүтээсэн эсхүл үйлдвэрлэсэн, түүнчлэн дагалдах үйлчилгээ үзүүлсэн улс буюу газар нутгийг хэлнэ. Материал болон тоног төхөөрөмжийг хийж бүтээсэн гэдэгт үйлдвэрлэсэн, боловсруулсан эсхүл эд ангиудыг дийлэнхийг нь эсхүл гол хэсгийг нь угсарч, энэ эд ангиудын үндсэн шинж чанар, зориулалт эсхүл ашиглалтын хэлбэрээс илт өөр арилжааны шинэ бүтээгдэхүүн гаргахыг хамруулна.



8 дугаар бүлэг – Гэрээний тусгай нөхцөл

Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцлийг бүрэн тодорхойлж гаргасан байна. Захиалагч холбогдох хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

ГЕН 1.1	Захиалагч: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ГЕН 1.1	Төслийн менежер: Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Хөрс, ургамал хамгаалал, үр сортын хэлтсийн дарга бөгөөд "Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй" төслийн захирал Н.Оюунсувд
ГЕН 1.1	Гэрээний нэр болон ялгах дугаар: CW-3-1, Услалтын системийг шинэчлэн сайжруулах барилгын ажил Эрдэнэбүрэн дэд төсөл (Эрдэнэбүрэн, Ховд)
ГЕН 1.1	Ажил нь дараах ажлуудаас бүрдэнэ. <ol style="list-style-type: none"> 1. Толгойн барилга байгууламж 2. Тохируулах усан сан 3. Гол суваг 4. Хуваарилах суваг 5. Насос, насос станцын барилга 6. Бороожуулагч машин, усалгааны тоног төхөөрөмж 7. Хамгаалалтын хашаа 8. Ойн зурвас 9. Услалтын системийн дотоод зам, хамгаалалтын зурвас, гарам, гарц 10. Барилгын ажлын тоо хэмжээ 11. Бороожуулагч машин, усалгааны тоног төхөөрөмжийн худалдан авалт болон угсралт, суурилуулалт, зүгшрүүлэлт 12. Услалтын системийн тохируулан зүгшрүүлэх туршилт, хүлээлгэн өгөх 13. Чанарын баталгаат хугацаа буюу 1 жилийн турш услалтын системийн засвар үйлчилгээг хариуна.
ГЕН 1.1	Ажил эхлэх өдөр: 2024 оны 6-р сарын 1-ний өдөр Ажлыг эхлүүлэх нь ГЕН 25.3 дугаар заалтын хэрэгжилтээс хамаарна.
ГЕН 1.1	Ажлын талбай нь Ховд аймгийн Эрдэнэбүрэн суманд байрших ба GF-05/2023 дугаар зурагт зааснаар тодорхойлогдсон болно.
ГЕН 2.2	Хэсэгчилэн дуусгахыг “Зөвшөөрөхгүй”
ГЕН 2.3(j)	Дараах бичиг баримт нь гэрээний салшгүй хэсэг байна: <ol style="list-style-type: none"> 1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2. Жендерийн үйл ажиллагааны төлөвлөгөө 3. Нийгмийн хөгжлийн үйл ажиллагааны төлөвлөгөө 4. Ковид -19-ийн эрүүл мэнд ба аюулгүй байдлын төлөвлөгөө
ГЕН 3.1	Гэрээний баримт бичгүүд нь Монгол хэл дээр байна.
ГЕН 3.1	Гэрээнд Монгол улсын хуулийг баримтална.
ГЕН 8.1	Гүйцэтгэгч түүнчлэн байгаль орчин, эрүүл мэнд ба аюулгүй байдлын хяналт шалгалт хариуцсан улсын болон орон нутгийн байгууллагын бүх шаардлагыг биелүүлнэ. Гүйцэтгэгч байгаль орчинтой холбоотой улсын болон орон нутгийн бүх хууль дүрмийг мөрдөнө.
ГЕН 14.1	Бусад гүйцэтгэгчийн хуваарь: Гэрээнд гарын үсэг зурах үед бэлэн болно.
ГЕН 19.1	Даатгалд зайлшгүй хамруулах зүйл, даатгалын дүнгийн доод хэмжээ: <ol style="list-style-type: none"> (а) Ажил, байгууламж ба материалын даатгалд суутгах: 86,249,000 төгрөг (б) Тоног төхөөрөмжийн даатгалд суутгах: 8,700,000 төгрөг (в) Гэрээтэй холбоотой эд хөрөнгө (ажил, байгууламж ба материалаас бусад)-ийн даатгалд суутгах: 8,700,000 төгрөг (г) Гэнэтийн ослын буюу амь насны даатгалд суутгах <ol style="list-style-type: none"> (i) гүйцэтгэгчийн ажилтнууд: 36 сарын цалинтай тэнцүү хэмжээгээр даатгуулна. (ii) бусад хүмүүс: 100%



<p>ГЕН 20.1</p>	<p>Ажлын талбайн судалгааны тайлан: <i>[Ажлын талбайн судалгааны тайланг жагсаан бичих]</i></p> <ol style="list-style-type: none"> 1. Зураг 2. Тайлбар бичиг 3. Инженер гоелогийн судалгаа 4. Геодезийн байрзүйн зураглал 5. ББЭХС ТӨХК-ийн Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын нутагт баригдах Эрдэнэбүрэн усжуулалтын системийг ЦЭХ-ээр хангах техникийн нөхцөл №01/2023 6. АХБ-наас боловруулсан төслийн Байгаль орчны анхан шатны үнэлгээний тайлан 7. Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын нутагт хэрэгжих “Эрдэнэбүрэн усалтын систем” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан 8. Услалтын системийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө 9. Жендерийн үйл ажиллагааны төлөвлөгөө 10. Нийгмийн хөгжлийн үйл ажиллагааны төлөвлөгөө 11. Гомдол барагдуулах журам
<p>ГЕН 23.1, 37.1</p>	<p>Ажил дуусгах өдөр 2026 оны 11-р сарын 30-ны өдөр.</p>
<p>ГЕН 25.3</p>	<p>(i) Захиалагч нь ажлын талбайн ажилтнуудыг аюулгүй, эрүүл орчинд ажлын нөхцлөөр хангах, осол, гэмтэл, өвчнөөс урьдчилан сэргийлэх ажиллагааны тогтолцоог бүрдүүлэх асуудлыг хариуцна. Үүнд орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд барилгын ажлын улмаас үүсэх сөрөг үр дагавар, эрсдлээс зайлсхийх, ба зайлсхийх боломжгүй тохиолдолд бууруулах зорилгоор урьдчилан сэргийлэх, онцгой байдалд бэлэн байх, хариу арга хэмжээ авах зэргийг оруулна.</p> <p>(ii) Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл (буюу хүлээн зөвшөөрсөн тухай захидал)-ийн өдрөөс хойш 28 өдөрт багтаан, гүйцэтгэгч ажлын талбайд хамаарах байгаль орчин, эрүүл мэнд ба аюулгүй байдлын менежментийн төлөвлөгөө (АТХБОЭМАБМТ)-г дэлгэрэнгүйгээр менежерийн зөвшөөрөл авах зорилгоор ирүүлэх ёстой. Энэ төлөвлөгөө нь байгаль орчин, эрүүл мэнд ба аюулгүй байдлын хууль тогтоомж, гэрээнд дурдсан бусад холбогдох шаардлагад хэрхэн нийцэхээр байгааг харуулах бөгөөд тендерийн баримт бичгийн “Тодорхойлолт ба бусад шаардлага” буюу 6 дугаар бүлэгт хавсаргасан төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээ (БОНУ), байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ), мөн нэмэлт мэдээлэлд тусгасан хяналт, эрсдлийн бүхий л арга хэмжээг хамрана. Төслийн менежерээс АТХБОЭМАБМТ-ний талаар зөвшөөрөл авах хүртэл ажлын талбай дээр ажил үл эхлүүлнэ. Төслийн менежерээс ийм зөвшөөрөл авч баталгаажуулах нь гүйцэтгэгчийг тэрээний хүрээнд хүлээсэн аливаа үүрэг хариуцлагаас үл чөлөөлнө.</p> <p>(iii) Гүйцэтгэгч АТХБОЭМАБМТ-нд зааснаар, ажлын талбайн бүх ажилтнууд, захиалагчийн ажилтнууд, түр зочдыг хөл (аюулгүйн гутал), толгой, нүд, чих (аюулгүйн малгай) ба гар зэргийг хамгаалах үүднээс хувийн хамгааллын хэрэгслээр хангах шаардлагатай. Туслан гүйцэтгэгч АТХБОЭМАБМТ-г мөрдөн, өөрийн ажилтнуудыг зохих хэрэгслээр хангаж байгаа эсэхийг гүйцэтгэгч баталгаажуулна.</p> <p>(iv) Гүйцэтгэгч (а) байгаль орчин, эрүүл мэнд ба аюулгүй байдлын нөлөөг удирдан захирах зорилгоор үйл ажиллагааны системийг байгуулж, (б) АТХБОЭМАБМТ-ний хүрээнд төслийн БОМТ-ний хэрэгжилтийг хянахад захиалагчийг бэлтгэлтэй байлгахын тулд, батлагдсан АТХБОЭМАБМТ, мөн хамгааллын мониторингийн тайланд дурдсан засаж залруулах эсвэл урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг мөрдөж, (в) ийм арга хэмжээ, шаардлага, үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах үүднээс шаардлагатай төсвийг хуваарилж, (г) төслийн менежер, захиалагчид хагас жил тутам уг арга хэмжээний биелэлтийн талаар тайлан бэлтгэж явуулна.</p>



	<p>(v) Гэрээний үед санамсаргүй байдлаар эрүүл мэнд, аюулгүй байдлын аюул осол илэрхий болсон тохиолдолд, гүйцэтгэгч ажлын талбайн ажилд үзүүлэх нөлөө, түүнийг бууруулах зохих арга хэмжээг тодорхойлж, төслийн менежерийн зөвшөөрөл авах үүднээс АТХБОЭМАБМТ-г шинэчлэн өөрчлөх шаардлагатай.</p> <p>(vi) Эмнэлгийн эмчилгээ, эмнэлэгт хэвтэх, эсхүл үхэл зэрэг ноцтой осол гэмтэл гарсан тохиолдолд, гүйцэтгэгч төслийн менежерт амаар даруй мэдэгдэж, албан ёсоор тайланг осол гарснаас хойш аль болох хурдан гаргаж өгнө. Үхэлтэй холбоотой болон холбоогүй бүх төрлийн ослын хувьд, гүйцэтгэгч түүнчлэн холбогдох хуулийн дагуу орон нутгийн зохих байгууллагад мэдэгдэнэ.</p>
ГЕН 27.2	Ажлын талбайг ашиглуулж эхлэх өдөр Ховд аймгийн Эрдэнэбүрэн сум 2024 оны 6-р сарын 01-ний өдөр



ГЕН 30.1	Маргаан таслагчийг томилох эрх бүхий байгууллага: Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим
ГЕН 31.3	Маргаан таслагчид төлөх ажлын цагийн хөлс: 50,000 төгрөг Нөхөн олгох зардал: Замын зардал, орон нутагт байрлах буудлын зардал, томилолт багтана.
ГЕН 36.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай (буюу хүлээн зөвшөөрсөн тухай захидал)-ийн өдрөөс хойш мэдэгдлийг хүлээн авсанаас хойш 30 хоногийн дотор ажлын хөтөлбөрийг гаргана. Ийм хөтөлбөрийг явуулахдаа ГЕН 25.3-д шаардсан байгаль орчин, эрүүл мэнд ба аюулгүй байдлын талаарх мэдээллийг оруулна.
ГЕН 36.3	Ажлын хөтөлбөрийг 30 хоног тутам тодотгоно. Тодотгосон ажлын хөтөлбөрийг хугацаа хоцроон ирүүлсэн тохиолдолд суутгах үнийн дүн нь 500,000 төгрөг байна.
ГЕН 44.1	Чанарын баталгаат хугацаа нь 365 хоног байна.
ГЕН 52.1	Төлбөрийг төлбөрийн мэдэгдэл гаргасан өдрөөс хойш 45 хоногийн дотор хийнэ.
ГЕН 56.1	ГЕН-ийн 56 дугаар зүйлийн дагуу гэрээнд үнийн тохируулга хийж болно. Үнийг тохируулах итгэлцүүр нь: Төгрөгийн хувьд: (1) тохируулга хийгдэхгүй хувийн жин нь 0.63 байна. (итгэлцүүр А) (2) тохируулга хийгдэх хувийн жин нь 0.37 байна. (итгэлцүүр В)
ГЕН 57.1	Төлбөрөөс суутгах барьцаа хөрөнгийн хэмжээ нь 5 хувь байна.
ГЕН 58.1	Нийт ажилд ногдуулах алданги хоногт гэрээний үнийн 0,05 байна. Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн 5 хувь байна.
ГЕН 59.1	Гэрээнд урамшуулал тооцохгүй.
ГЕН 60.1	Урьдчилгаа төлбөрийн хэмжээ нь 10 хувь байх ба гүйцэтгэгчид 2024 оны 10-р сарын 1-ний өдрөөс өмнө төлнө.
ГЕН 61.1	Гүйцэтгэлийн баталгаа нь гэрээний үнийн 5 хувьтай тэнцүү байна. Хүлээн зөвшөөрөгдөх гүйцэтгэлийн баталгаа нь тендерийн баримт бичгийн 9 дүгээр бүлэгт заасан маягтын дагуу гаргасан банкны баталгаа байна.
ГЕН 74.1	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг 2026 оны 10 дугаар сарын 1-ний дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг 2026 оны 10 дугаар сарын 1-ний дотор гаргаж өгнө.
ГЕН 74.2	Гүйцэтгэлийн зураг болон ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг ГЕН-ийн 74.1-д шаардсан хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ 500,000 төгрөг байна.
ГЕН 77.1	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын 10 хувиар тооцно.



9 дүгээр бүлэг – Гэрээний маягт

Энэ бүлэг нь гэрээний маягтуудыг агуулж байгаа бөгөөд тэдгээрийг бөглөснөөр гэрээний салшгүй хэсэг болно. Шаардлагатай бол, зөвхөн шалгарсан тендерт оролцогч гүйцэтгэлийн баталгаа ба урьдчилгаа төлбөрийн баталгааны маягтуудыг гэрээ байгуулах эрх олгосны дараа бөглөнө.

Агуулга

Гэрээ байгуулах эрх олгох тухай илэрхийлэл бүхий мэдэгдэл

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл

Гэрээ

Гүйцэтгэлийн баталгаа

Урьдчилгаа төлбөрийн баталгаа



Гэрээ байгуулах эрх олгох тухай илэрхийлэл бүхий МЭДЭГДЭЛ

[Захиалагчийн албан бичгийн мөхөт шилжлэл, нэр ба хаягийг оруулах]

[огноо]

Хаана: [Тендерт оролцогчийн нэр]
 Хэнд: [Тендерт оролцогчийг албан ёсоор төлөөлөх этгээдийн нэрийг оруулах]
 Хаяг: [Тендерт оролцогчийг албан ёсоор төлөөлөх этгээдийн хаягийг оруулах]
 Утас/Факсын дугаар: [Тендерт оролцогчийг албан ёсоор төлөөлөх этгээдийн утас/факсын дугаарыг оруулах]
 Цахим шуудан: [Тендерт оролцогчийг албан ёсоор төлөөлөх этгээдийн цахим шууданг оруулах]

Бид гэрээ байгуулах эрх олгох тухай илэрхийлэл [Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэд заасан гэрээний ялгах нэр, дугаарыг оруулах]-ийг үүгээр мэдэгдэж байна. Энэ мэдэгдлийг гаргаснаас хойш [ТШӨХ-ийн ТӨӨЗ 39.1-д заасан хоногийн тоог оруулах] хоногийн дотор та (i) таны тендерийг хэрхэн үнэлсэн талаар тайлбар хүсэх; мөн/эсхүл (ii) гэрээ байгуулах эрх олгох тухай илэрхийлэл бүхий уг мэдэгдэлтэй холбогдуулан ТӨӨЗ-ны 44.1-д заасан журмын дагуу тендер шалгаруулалтын талаар гомдол гаргаж болно.

Үнэлгээний хураангуй мэдээлэл:

1. Тендерт оролцогчдын нэр

Тендерт оролцогчийн нэр	Тендерийн нээлтийн үед зарлагдсан тендерийн үнэ	Тендерийн үнэлэгдсэн үнэ

2. Таны тендерээс татгалзсан үндэслэл

.....

3. Шалгарсан тендерт оролцогч

Тендерт оролцогчийн нэр:	
Хаяг:	
Гэрээний үнэ:	
Гэрээ хэрэгжүүлэх хугацаа:	
Хэрэгжүүлэх гэрээний цар хүрээ:	
Гүйцэтгэлийн баталгааны дүн:	

Эрх бүхий этгээдийн гарын үсэг:

Гарын үсэг зурсан этгээдийн нэр, албан тушаал:

Байгууллагын нэр:



Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл

[Захиалагчийн албан бичгийн маягт ашиглана]

Хүлээн зөвшөөрсөн тухай захидал

[огноо]

Хэнд: [Гүйцэтгэгчийн нэр хаяг]

Агуулга: ... тоот гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл

[огноо]-ний өдөр ирүүлсэн таны тендер нь [Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэд заасан гэрээний ялгаа нэр, дугаарыг оруулах] гэрээг Тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу залруулж өөрчилсөн [үнийн дүнг үсгээр болон тоогоор, валютын нэрийг оруулах] бүхий гэрээний анхны үнийн дүнгээр хэрэгжүүлэхээр шалгарсныг үүгээр мэдэгдэж байна.

Та гэрээний нөхцөлд заасны дагуу гүйцэтгэлийн баталгааг 28 хоногийн дотор, мөн таны тендерийг үнэлсний эцэст шаардах аливаа нэмэлт баталгааны хамт Тендерийн баримт бичгийн 9 дүгээр бүлэг (Гэрээний маягт)-ийн гүйцэтгэлийн баталгааны маягтын дагуу гаргаж ирүүлнэ.

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Гарын үсэг зурсан этгээдийн нэр, албан тушаал:

Байгууллагын нэр:

Хавсралт: Гэрээ



Гэрээ

Гэрээний дугаар CW-3-1

Энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) нэг талаас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (цаашид "захиалагч" гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн нэрийг оруулах] (цаашид "гүйцэтгэгч" гэх) 20... оны ... дугаар сарын ... -ний өдөр байгуулав:

ҮҮНД захиалагч нь Услагтын системийг шинэчлэн сайжруулах барилгын ажил Эрдэнэбүрэн дэд төсөл (Эрдэнэбүрэн, Ховд)-ийн барилгынажлыг гүйцэтгэгчээр хийлгүүлэх болсон бөгөөд эдгээр ажлыг гүйцэтгэж дуусгах, мөн аливаа зөрчил доголдлыг арилгахаар гүйцэтгэгчийн ирүүдсэн тендерийг хүлээн зовшоорсон болно,

Захиалагч ба гүйцэтгэгч дараах зүйлийг харилцан тохиролцов:

1. Энэхүү гэрээнд хэрэглэгдсэн үг, хэллэг нь гэрээний баримт бичгүүдийн холбогдох хэсэгт заасантай ижил утгыг илэрхийлнэ.
2. Дараах баримт бичгүүд нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно. Энэхүү гэрээнд ач холбогдлоор нь дараах дарааллыг баримтлах бөгөөд гэрээний бусад бүх баримт бичгүүдээс давуу үйлчлэлтэй байна.

(а) Гэрээ,

(б) Хүлээн зовшоорсон тухай захидал,

(в) Тендер ирүүлэх маягт,

(г) Нэмэлт өөрчлөлт № ... [нэмэлт өөрчлөлтийн дугаарыг оруулах, хэрэв байгаа бол],

(д) Гэрээний тусгай нөхцөл,

(е) Тендерийн баримт бичгийн 5 дугаар бүлэгт дурдсан Эрх бүхий орнуудын жагсаалт,

(ё) Гэрээний ерөнхий нөхцөл,

(ж) Тодорхойлолт,

(з) Ажлын зураг,

(и) Үйл ажиллагааны эцсийн хуваарь,

(й) Байгаль, орчны менежментийн төлөвлөгөө

(к) Жендерийн үйл ажиллагааны төлөвлөгөө

(л) Нийгмийн хөгжлийн үйл ажиллагааны төлөвлөгөө

(м) Төсөв, төсвийн задаргаа

(н) Ковид -19-ийн эрүүл мэнд ба аюулгүй байдлын төлөвлөгөө

3. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчаас түүнд төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөлд нийцүүлэн ажлыг гүйцэтгэж, аливаа зөрчил доголдлыг арилгах үүрэг хариуцлагыг хүлээнэ.

4. Захиалагч нь гүйцэтгэгчийн хийж дуусгах ажил, түүнд холбогдох аливаа зөрчил доголдлыг арилгах үйлчилгээг үндэслэн гэрээнд шаардсан хугацаа ба арга хэлбэрээр гэрээний үнэ, эсхүл гэрээний нөхцөлд заасан бусад төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Гэрээний талууд энэхүү гэрээг дээр тэмдэглэсэн он, сар, өдөр Монгол улсын хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлэхээр байгуулсан болохыг үүгээр гэрчлэв.

ЗАХИАЛАГЧИЙГ төлөөлж:

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ төлөөлж:



Т.Жамбалцэрэн:

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны

Төрийн нарийн бичгийн дарга

Нэр ба албан тушаал:

ТАМГА

Хаяг:

Утас/Факс:

Нэр ба албан тушаал:

ТАМГА

Хаяг:

Утас/Факс:



Гүйцэтгэлийн баталгаа

[Баталгаа гаргаж буй банкны нэр, салбарын хаяг]

Хүлээн авагч: [Захиалагчийн нэр, хаягийг оруулах]

Огноо:

Гүйцэтгэлийн баталгааны дугаар:

[Гүйцэтгэлийн нэрийг оруулах] (цаашид “гүйцэтгэгч” гэх) нь [огноо]-ны өдөр танай байгууллагатай байгуулсан гэрээний дугаар [холбогдох гэрээний дугаарыг оруулах]-тай, [гэрээний нэр болон гүйцэтгэх ажлын товч тодорхойлолтыг оруулах] (цаашид “гэрээ” гэх) ажлыг гүйцэтгэх болсон тухай мэдээллийг бид хүлээн авсан болно.

Гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний нөхцөлд заасны дагуу гүйцэтгэлийн баталгааг гаргаж ирүүлэх шаардлагатайг бид бүрэн ойлгож байгаа бөгөөд үүнтэй холбогдуулан,

Банк нь гүйцэтгэгчийн хүсэлтээр [баталгааны дүн тоогоор, мөнгөн тэмдэгтээр] [дүн үсгээр] хэтрэхгүй мөнгөн дүнтэй төлбөрийг [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх)-ийн өмнө хариуцаж, гүйцэтгэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай захиалагчийн бичгээр гаргасан анхны шаардлагыг хүлээн авсан даруй үл маргалдах журмаар энэхүү төлбөрийг хийх үүрэг хүлээж байна. Ингэхдээ дээр дурдсан [баталгааны дүн тоогоор, төгрөг] [дүн үсгээр]-ийн хүрээнд захиалагчийн шаардсан аливаа дүнг төлөхдөө ямарваа нэгэн нотолгоо, үндэслэл болон тайлбар шаардахгүй.

Энэхүү баталгаа нь [огноо]¹³-д дуусгавар болох ба уг баталгааны дагуу нэхэмжлэх аливаа төлбөрийг уг хугацааг дуусахаас өмнө баталгааг гаргасан банкны салбарт хандан нэхэмжилнэ.

Энэхүү баталгааг 20(a)(ii) дэд зүйлд зааснаас бусад тохиолдолд ОУХТ-ын хэвлэлийн 458 дугаар [эсхүл ОУХТ-ын хэвлэлийн 758 дугаар]-тай баталгааны нэгдсэн дүрэмд нийцүүлэн гаргав.¹⁴

[Банкны гарын үсэг, тамга (хэрэв шаардлагатай бол)]

Тендерт оролцогчид зориулсан санамж

Хэрэв гүйцэтгэлийн баталгаа гаргагч нь захиалагчийн улсын гадна байрлаж үйл ажиллагаа явуулдаг бол уг баталгааг хэрэгжүүлэх нөхцөлийг хангах үүднээс захиалагчийн улсад өөрийн харилцагч санхүүгийн байгууллагатай байна.

¹³ Ажил дуусгавар болохоор төлөвлөж буй хугацаанаас хойш 28 хоногийн дараах огноог оруулна. Захиалагч нь гэрээ хэрэгжүүлж дуусгах хугацааг сунгах тохиолдолд уг баталгааг нэгэн адил сунгах хүсэлтийг баталгаа гаргагчид хүргүүлэх шаардлагатай. Уг хүсэлтийг бичгээр гаргаж, баталгаанд заасан хугацаа дуусахаас өмнө үйлднэ. Уг баталгааг бэлтгэхдээ захиалагч дараах өгүүлбэрийг маягтын төгсгөлд нэмж оруулж болно: “Баталгаа гаргагч нь энэхүү баталгааг [6 сар] эсхүл [1 жил]-ээс хэтрэхгүй хугацаагаар баталгаа гаргагчид уг баталгаа дуусгавар болох хугацаанаас өмнө захиалагчийн бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн нэг удаа сунгахыг зөвшөөрч байна.”

¹⁴ ОУХТ-ын хэвлэлийн 758 дугаартай, баталгааны нэгдсэн дүрмийг ашиглаж байгаа бол энэ заалттай ижилхэн буюу ижил төстэй заалт байна.



Урьдчилгаа төлбөрийн баталгаа

[Баталгаа гаргаж буй банкны нэр, салбарын хаяг]

Хүлээн авагч: [Захиалагчийн нэр, хаягийг оруулах]

Огноо:

Урьдчилгаа төлбөрийн баталгааны дугаар:

[Гүйцэтгэгчийн нэрийг оруулах] (цаашид "гүйцэтгэгч" гэх) нь [олноо]-ны өдөр танай байгууллагатай байгуулсан гэрээний дугаар [холбогдох гэрээний дугаарыг оруулах]-тай, [гэрээний нэр болон гүйцэтгэх ажлын товч тодорхойлолыг оруулах] (цаашид "гэрээ" гэх) ажлыг гүйцэтгэх болсон тухай мэдээллийг банк хүлээн авсан болно.

Гэрээний нөхцөлд заасны дагуу [валютын нэр, үнийн дүнг үсгээр болон тоогоор илэрхийлэх]¹⁵ –ийн урьдчилгаа төлбөрийг олгоход уг үнийн дүнтэй тэнцэх урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргаж ирүүлэх шаардлагатайг банк бүрэн ойлгож байгаа бөгөөд үүнтэй холбогдуулан,

Банк [банкны нэрийг оруулах] нь Гүйцэтгэгчийн хүсэлтээр [валютын нэр, мөнгөн дүнг үсгээр болон тоогоор оруулах]¹⁶ –ийн буюу үүнээс хэтрэхгүй үнийн дүн бүхий төлбөрийг хариуцах ба гүйцэтгэгчийг гэрээний дагуу хүлээсэн буюу дор дурдсан үүргээ зөрчсөн тухай танай байгууллагын бичгээр гаргасан анхны мэдэгдлийг хүлээн авсан даруй үл маргалдах журмаар уг төлбөрийг төлөх үүргийг хүлээж байна. Хэрэв гүйцэтгэгч нь:

- (а) Урьдчилгаа төлбөрийг эхлэлийн болон ажил гүйцэтгэхэд шаардагдах мөнгөн урсгалын зардлыг санхүүжүүлэхээс бусад зорилгоор ашигласан бол;
- (б) Гүйцэтгэгч нь урьдчилгаа төлбөрийг гэрээний нөхцөлд заасан хугацаанд багтаан уг урьдчилгаа төлбөрийн үнийн дүнтэй тэнцэх гүйцэтгэлээр буцаан төлөх үүргээ зөрчсөн.

Энэ нь гүйцэтгэгч [банкны нэр ба хаяг] банк дахь өөрийн [гүйцэтгэгчийн дансны дугаар] тоот дансандаа дээр дурдсан урьдчилгаа төлбөрийг хүлээн авсан тохиолдолд энэхүү баталгааны дагуу аливаа төлбөрийг нэхэмжлэх нөхцөл болно.

Энэхүү баталгааны дүн нь гүйцэтгэгчээс урьдчилгаа төлбөрийг эргэн төлөх бүрт уг дүнгээр буурах ба явцын тайланд энэ тухай дурдсан бол хуулбарыг эсхүл төлбөрийн гэрчилгээг банкинд ирүүлсэн байх шаардлагатай. Энэхүү баталгааны хүчинтэй хугацаа нь гэрээний үнийн ерөн хувь (90%)-тай тэнцэх дүнтэй төлбөр төлөгдөхөөр баталгаажсан тухай явцын төлбөрийн гэрчилгээний хуулбарыг банк хүлээн авсан даруйд эсхүл [он] [сар] [өдөр]¹⁷ –ний өдрийн аль богино хугацаанд дуусгавар болно. Иймд уг баталгааны дагуу аливаа төлбөрийн нэхэмжлэлийг уг өдрөөс өмнө банкны энэ салбарт ирүүлсэн байх шаардлагатай.

Энэхүү баталгааг ОУХТ-ын хэвлэлийн 458 дугаар [эсхүл ОУХТ-ын хэвлэлийн 758 дугаар]-тай баталгааны нэгдсэн дүрэмд нийцүүлэн гаргах.

.....
[Банкны гарын үсэг, тамга (хэрэв шаардлагатай бол)]

Тендерт оролцогчид зориулсан санамж

Хэрэв урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргагч банк нь захиалагчийн улсын гадна байрлаж үйл ажиллагаа явуулдаг бол уг баталгааг хэрэгжүүлэх нөхцөлийг хангах үүднээс захиалагчийн улсад өөрийн харилцагч санхүүгийн байгууллагатай байна.

¹⁵ Баталгаа гаргагч банк нь урьдчилгаа төлбөрийн үнийн дүнг оруулахдаа төгрөгөөр илэрхийлнэ.

¹⁶ Зүүлт тайлбар 31

¹⁷ Ажил дуусгавар болохоор төлөвлөж буй олноог оруулна. Захиалагч нь гэрээ хэрэгжүүлж дуусгах хугацааг сунгах тохиолдолд уг баталгааг нэгэн адил сунгах хүсэлтийг баталгаа гаргагчид хүргүүлэх шаардлагатай. Уг хүсэлтийг бичгээр гарган баталгаанд заасан хугацаа дуусахаас өмнө ирүүлсэн байна. Уг баталгааг бэлтгэхдээ захиалагч нь дараах текстийг маягтын төгсгөлд нэмж оруулж болно: "Баталгаа гаргагч банк нь энэхүү баталгааг [6 сар] эсхүл [1 жил]-ээс хэтрэхгүй хугацаагаар баталгаа гаргагчид уг баталгаа дуусгавар болох хугацаанаас өмнө захиалагчийн бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн нэг удаа сунгахыг зөвшөөрч байна."

